

2022-07-04-ний өдрийн Ээлжит Их хурлын 08 тоот тогтоолоор батлав.

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

MONGOLIAN FOOTBALL
FEDERATION STATUTES

2022



ТОВЪЁОГ

Зүйлүүд

Хуудас

НЭР ТОМЪЁО	4
I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛҮҮД /1-10/	8
II. ГИШҮҮНЧЛЭЛ /11-22/	16
III. ХҮНДЭТ ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ХҮНДЭТ ГИШҮҮД /23/	32
IV. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ /24-56/	34
A. Их хурал	36
Б. Зөвлөл	54
В. Ерөнхийлөгч	64
Г. Байнгын хороод	66
Д. Клуб лицензжүүлэх байгууллагууд	72
Е. Ерөнхий нарийн бичгийн даргын газар	74
V. ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУД /57-63/	78
VI. САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД /64/	86
VII. АРБИТР /65-66/	88
VIII. САНХҮҮ /67-74/	90
IX. ТЭМЦЭЭН БОЛОН ТЭМЦЭЭНИЙ БА БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР ЭДЛЭХ ЭРХ /75-77/	94
X. ОЛОН УЛСЫН ТОГЛОЛТ БА ТЭМЦЭЭН /78-80/	98
XI. ТӨГСГӨЛИЙН ЗҮЙЛҮҮД /81-85/	100
ХАВСРАЛТ 1: ХОЛБООНЫ ТУГ, БЭЛЭГ ТЭМДЭГ	
ХАВСРАЛТ 2: ХОЛБООНЫ БҮТЦИЙН ЗУРАГ	
ХАВСРАЛТ 3: ШУДАРГА БАЙДЛЫН АМЛАЛТ	
ХАВСРАЛТ 4: ИХ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ДЭГИЙН ЗААВАР	

CONTENTS

Article	Page
DEFINITIONS	5
I. GENERAL PROVISIONS /1-10/	9
II. MEMBERSHIP /11-22/	17
III. HONORARY PRESIDENT AND HONORARY MEMBER /23/	33
IV. ORGANISATION /24-56/	35
A. Congress	37
B. Council	55
C. President	65
D. Standing committees	67
E. Club licensing bodies	73
F. General secretariat	75
V. INDEPENDENT BODIES /57-63/	79
VI. DISCIPLINARY MEASURES /64/	87
VII. ARBITRATION /65-66/	89
VIII. FINANCE /67-74/	91
IX. COMPETITIONS AND RIGHTS IN COMPETITIONS AND EVENTS /75-77/	95
X. INTERNATIONAL MATCHES AND COMPETITIONS /78-80/	99
XI. FINAL PROVISIONS /81-85/	101
ANNEX 1: TRADEMARKS	
ANNEX 2: ORGANISATIONAL CHART	
ANNEX 3: INTEGRITY CHECKS	
ANNEX 4: STANDING ORDERS OF THE CONGRESS	

НЭР ТОМЪЁО

ДАРААХ НЭР ТОМЪЁОГ ДОР ДУРДСАНААР ОЙЛГОНО:

МХБХ: “Монголын хөлбөмбөгийн холбоо”, Олон улсын хөлбөмбөгийн холбооноос гишүүнээр хүлээн зөвшөөрөгдсөн хөлбөмбөгийн холбоо (“хөлбөмбөг” гэдэг үгийг салгахгүй хамтад нь бичиж хэрэглэнэ.)

ОУХБХ: “Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо”;

АХБХ: “Азийн Хөлбөмбөгийн Холбоо”;

ЗАХБХ: “Зүүн Азийн Хөлбөмбөгийн Холбоо”;

Холбоо: Энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хөлбөмбөгийн үйл ажиллагаа явуулдаг, ОУХБХ, харъяа тивийн холбоонд хүлээн зөвшөөрөгдсөн холбоог хэлнэ. Энэ нь ОУХБХ-ны гишүүн байна;

Лиг: Холбоонд захирагдах байгууллага;

Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо: Холбоонд захирагдах байгууллага;

Тивийн холбоо: ОУХБХ-ноос хүлээн зөвшөөрсөн, нэг ижил тивд хамаарах (газар зүйн ижил бүсэд оршдог) Холбоодын нэгдэл;

Клуб: ОУХБХ-ны гишүүн Холбооны гишүүн эсвэл Холбооноос хүлээн зөвшөөрсөн Лигийн тэмцээнд нэгээс дээш баг нь оролцдог гишүүн

Албаны хүмүүс: ОУХБХ, Тивийн холбоо, ОУХБХ-ны гишүүн холбоо, Лиг, Клуб ба ОУХБХ-ны дүрмийг сахин биелүүлдэг аливаа этгээдийн техник, спортын анагаах ухаан ба захиргааны асуудал хариуцсан Удирдах зөвлөл (Холбооны Зөвлөлийн гишүүдийг багтааж үзнэ), хорооны гишүүн, шүүгч ба туслах шүүгч, дасгалжуулагч, сургагч зэрэг тоглогчоос бусад гишүүдийг хэлнэ.

Тоглогч: Холбоонд бүртгэлтэй хөлбөмбөгийн тоглогч;

Их хурал: Холбооны эрх барих дээд байгууллага;

Төлөөлөгч: Их хуралд гишүүнийг төлөөлж буй бие хүн;

Зөвлөл: Холбооны стратеги ба бодлого тодорхойлох байгууллага;

Их хурлын гишүүн: Их хурлаас Холбооны гишүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн хуулийн этгээд болон их хурлын гишүүн байна;

DEFINITIONS

THE TERMS GIVEN BELOW DENOTE THE FOLLOWING:

MFF: “Mongolian Football Federation”.

FIFA: "Fédération Internationale de Football Association".

AFC: “Asian Football Confederation”.

EAFF: “East Asian Football Federation”.

Association: a football association recognised as such by FIFA and by the relevant confederation. It is a member of FIFA, unless a different meaning is evident from the context.

League: an organisation that is subordinate to an Association.

Regional Association: an organisation that is subordinate to an Association.

Confederation: a group of Associations recognised by FIFA and belonging to the same continent (or assimilable geographic area).

Club: a member of an Association (that is a Member of FIFA) or of a League recognised by an Association that enters more than one team in a competition.

Official: every board member (including the members of the Council), committee member, referee and assistant referee, coach, trainer and any other person (except Players) responsible for technical, medical and administrative matters in FIFA, a Confederation, a FIFA Member Association, League or Club as well as any other persons obliged to comply with the FIFA Statutes.

Player: a football player registered with the MFF.

Congress: the supreme and legislative body of MFF.

Delegate: a natural person validly representing a Member at the Congress.

Council: strategic and oversight body of MFF.

Member: a legal entity that has been admitted into membership of MFF by the Congress and that is a Member of the Congress.

Гишүүн: МХБХ ба эсвэл МХБХ-ны Их хурлаас гишүүнээр хүлээн зөвшөөрөгдсөн, Их хуралд санал өгөх эрхгүй хөлбөмбөгийн оролцогч (хуулийн этгээд);

Холбооны тэмцээн уралдаанууд: ОУХБХ-ноос хяналт тавьж Тоглолтын дүрэмд заасны дагуу зохион байгуулагдах тэмцээн;

Тоглолтын дүрэм: ОУХБХ-ны хөлбөмбөгийн холбоодын Зөвлөл, ОУХБХ-ны дүрэм болон зохих журмын дагуу боловсруулсан хөлбөмбөгийн тоглолтын дүрэм;

ОУХБХ-ны зөвлөл: Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны хөлбөмбөгийн холбоодын Зөвлөл;

Шүүх: Нийтийн болон хувийн эрх зүйн маргааныг шийддэг шүүх;

Монголын Олон улсын ба Үндэсний спортын Арбитр: Монгол улсын нутаг дэвсгэр дээр маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх эрх бүхий, МХБХ-нд хүлээн зөвшөөрөгдсөн, хуулийн дагуу байгуулагдсан бие даасан байгууллага;

Спортын Арбитрын Шүүх (САШ): Швейцарь Улсын Лозанна хотод байрладаг Спортын Арбитрын Шүүх.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл: Монголын Тусгай Олимпын Хорооны төлөөллөөс бүрдсэн зөвлөлийг хэлнэ.

Тэмдэглэл: Дүрэмд заасан хувь хүн гэсэн нэр томьёо нь бүх төрлийн хүйсийн этгээдийг илэрхийлнэ. Нэг тоон дээр бичигдсэн аливаа нэр томьёо нь олон тоог, мөн олон тоо нь нэг тоог илэрхийлнэ.

Affiliate: a football stakeholder (legal entity) that has been recognised by the MFF and/or by one of its Members.

Association Football: the game controlled by FIFA and organised in accordance with the Laws of the Game.

Laws of the Game: the laws of association football issued by the IFAB in accordance with the relevant provisions of the FIFA Statutes.

IFAB: the International Football Association Board.

Ordinary Courts: state courts which hear public and private legal disputes.

Mongolian International and National Sports Arbitration Tribunal: an independent and duly constituted private court of justice recognised by MFF, seated in the territory of Mongolia under MFF and acting instead of an Ordinary Court.

CAS: Court of Arbitration for Sport in Lausanne (Switzerland).

Disability Football Board: a board that composed of representatives of the Special Olympics Committee of Mongolia.

NB: Terms referring to natural persons include both genders. Any term in the singular applies to the plural and vice-versa.

I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛҮҮД

1-Р ЗҮЙЛ. **НЭР, ТӨВ БАЙР БОЛОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЭЛБЭР**

1. Монголын Хөлбөмбөгийн Холбоо нь (цаашид “Холбоо” гэх) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 1959 оны 10 сарын 30-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Хууль зүйн яаманд 10009656 дугаартайгаар бүртгэгдсэн, Холбооны шинж чанартай олон нийтийн төрийн бус байгууллага мөн. Тус төрийн бус байгууллага нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.
2. Холбооны төв байр нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороонд байрлана.
3. Холбоо нь Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо, Азийн Хөлбөмбөгийн Холбоо болон Зүүн Азийн Хөлбөмбөгийн Холбооны гишүүн мөн болно.
4. Холбооны туг нь Хавсралт №1(а)-д заасны дагуу байна.
5. Холбооны бэлэг тэмдэг нь Хавсралт №1(б)-д заасны дагуу байна.
6. Туг, бэлэг тэмдэг нь Олон улсын ба Монгол улсын оюуны өмчийн эрх бүхий байгууллагад хууль ёсны бүртгэлтэй байна.

2-Р ЗҮЙЛ. **ЗОРИЛГО**

1. Холбоо нь дараах зорилготой байна. Үүнд:
 - 1.1. Хөлбөмбөгийн спортыг тогтвортой хөгжүүлэх мөн хүүхэд залуучуудын болон хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хөлбөмбөгийн спортын эв нэгдэл, боловсрол, соёл болон хүмүүнлэгийн ач холбогдлыг Монгол улс даяар сурталчлан таниулж, хяналт тавих, мөрдөх;
 - 1.2. Улсын чанартай бүх төрлийн хөлбөмбөгийн тэмцээнийг зохион явуулах;
 - 1.3. Холбогдох журам, зааврыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах;
 - 1.4. Холбооны гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах;

I. GENERAL PROVISIONS

ARTICLE 1 NAME, HEADQUARTERS, LEGAL FORM AND TRADEMARKS

1. MFF is a public non-government organisation of an associative nature formed on 30 October 1959 in compliance with the legislation of Mongolia and registered by the Ministry of Justice of Mongolia under Register no. 10009656 in the city of Ulaanbaatar. It is formed for an unlimited period.
2. The headquarters are located in the city of Ulaanbaatar, Khan-Uul district, 15th khoroo.
3. MFF is a member of FIFA, AFC and EAFF.
4. The flag of MFF is set in Annex 1(a).
5. The emblem of MFF is set in Annex 1(b).
6. The flag and emblem are legally registered with the National and International intellectual certified authority property protection bodies.

ARTICLE 2 OBJECTIVES

1. The objectives of MFF are the following:
 - 1.1. to develop the game of football constantly and promote, regulate, and control it throughout the territory of Mongolia in the light of fair play and its unifying, educational, cultural, and humanitarian values, particularly through youth and development programmes;
 - 1.2. to organise competitions in all its forms at national level;
 - 1.3. to draw up regulations and provisions and ensure their enforcement;
 - 1.4. to protect the interests of its Members;

- 1.5. ОУХБХ, АХБХ, ЗАХБХ, МХБХ-ны Дүрэм, журам, бодлого, шийдвэр болон Тоглолтын дүрэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, өөрөө болон өөрийн гишүүдээр эдгээр дүрэм, журам, шийдвэрийг сахин мөрдүүлэх;
- 1.6. Холбооны гишүүд, албаны хүмүүс, тоглогчид, уралдаан тэмцээн ба тоглолтуудын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх эсвэл Холбооны зохион байгуулдаг тэмцээн уралдааныг гутаан доромжлоход хүргэх аливаа авлига, сэргээш, тоглолтыг урьдчилан үгсэн тохирох зэрэг зүй бус үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх үүднээс эв нэгдэл, ёс зүй, шударга тоглолтыг хөхүүлэн дэмжих;
- 1.7. Монгол улсын нутаг дэвсгэрт зохион байгуулах хөлбөмбөгийн бүх төрлийн нөхөрсөг тоглолтод хяналт тавьж, удирдлагаар хангах;
- 1.8. Улсын аваргын түвшний тэмцээнүүд болон Монгол улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдах олон улсын чанартай тоглолтуудад ОУХБХ, АХБХ, ЗАХБХ-ны дүрэм болон холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангаж, удирдлагаар хангах;
- 1.9. Холбооны тэмцээн уралдаантай холбоотой бүхий л спортын олон улсын харилцааг зохицуулах;
- 1.10. Олон улсын болон бусад түвшний тэмцээнүүдийг эх орондоо хүлээн авч зохион байгуулах;
- 1.11. Засаглалын сайн зарчмыг сахин хамгаалж Монгол улсын хэмжээнд өөрийн гишүүдээр мөрдүүлэх;
- 1.12. Эмэгтэй хөлбөмбөгийн хөгжлийг дэмжиж бүхий л түвшинд эмэгтэй хөлбөмбөгийн оролцоог бүрэн хангахын төлөө ажиллах.

- 1.5. to respect and prevent any infringement of the Statutes, regulations, directives, and decisions of FIFA, AFC, EAFF, MFF and as well as the Laws of the Game, and to ensure that these are also respected by its Members;
- 1.6. to promote integrity, ethics, and fair play with a view of preventing and fighting all methods or practices, such as ethical misconduct, corruption, doping or match manipulation, which might jeopardise the integrity of matches, competitions, Players, Officials and Members or give rise to abuse of Association football, futsal or beach soccer;
- 1.7. to control and supervise all friendly football matches of all forms played throughout the territory of Mongolia;
- 1.8. to control and supervise Association football at national level and to control, supervise all forms of international football matches played throughout the territory of Mongolia, in accordance with the relevant Statutes and regulations of FIFA and of the Confederations;
- 1.9. to manage international sporting relations connected with Association Football in all its forms;
- 1.10. to host competitions at international and other levels;
- 1.11. to promote and strengthen good governance principles and practices at national level and encourage its Members to adopt their own good governance principles;
- 1.12. to promote the development of women's football and the full participation of women at all levels of football governance;

3-Р ЗҮЙЛ. ХҮНИЙ ЭРХ

1. Холбоо нь олон улсын жишгийн дагуу хүний эрхийг хүндэтгэн хамгаалахын төлөө ажиллах үүрэгтэй.

4-Р ЗҮЙЛ. ҮЛ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ БА ТЭГШ БАЙДАЛ

1. Улс, арьс өнгө, үндэс угсаа болон нийгмийн гарал, хүйсийн ялгаа, хэл, харагдах байдал, нас, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон бусад үзэл бодол, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, чинээлэг байдал, хүйсийн чиг хандлага зэрэг шалтгаанаар улс орон, хувь хүн эсвэл бүлэг хүмүүсийг ялгаварлан гадуурхах аливаа явдлыг хатуу хориглож, ийм явдал гаргавал гишүүнээс түр болон бүрмөсөн түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

5-Р ЗҮЙЛ. ТӨВИЙГ САХИХ БА ХАРААТ БУС БАЙДАЛ

1. Холбоо нь улс төр, шашны асуудлаар төвийг сахисан байр суурь баримтална.
2. Холбооны гишүүд нь улс төр, шашны асуудлаар төвийг сахисан байр суурьтай байх ба өөрийн гишүүдийг төвийг сахисан байлгана.
3. Холбоо нь улс төрийн оролцооны аливаа хэлбэрт үл автаж хараат бус байна. Өөрийн асуудлаа бие даан хараат бусаар шийдвэрлэж, гуравдагч этгээдийн нөлөөнд автахгүй явуулна.

6-Р ЗҮЙЛ. НӨХӨРСӨГ ХАРИЛЦААГ ДЭМЖИХ

1. Холбоо нь хүмүүнлэгийн зорилгоор өөрийн гишүүд, клубүүд, албаны хүмүүс ба тоглогчдын хооронд болон нийгэмд нөхөрсөг харилцааг хөгжүүлнэ.
2. Холбоо нь өөрийн гишүүн, клубүүд, албаны хүмүүс, тоглогчдын хооронд үүсч болзошгүй дотоодын чанартай аливаа маргааныг таслан шийдвэрлэх шаардлагатай механизмтай байна.

ARTICLE 3 HUMAN RIGHTS

1. MFF is committed to respecting all internationally recognised human rights and shall strive to promote the protection of these rights.

ARTICLE 4 NON-DISCRIMINATION AND EQUALITY

1. Discrimination of any kind against a country, private person or group of people on account of race, skin colour, ethnic, national or social origin, gender, language, age, physical appearance, religion, political opinion or any other opinion, wealth, birth or any other status, sexual orientation, disability or any other reason conducted by member is strictly prohibited and punishable by suspension or expulsion and/or disciplinary measures.

ARTICLE 5 NEUTRALITY AND INSTITUTIONAL INDEPENDENCE

1. MFF is neutral in matters of politics and religion.
2. The Members of MFF shall also be neutral in matters of politics and religion and shall ensure that their own members remain neutral.
3. MFF shall remain independent and shall avoid any form of undue political interference. MFF shall manage its affairs independently and shall ensure that its own affairs are not influenced by any third parties.

ARTICLE 6 PROMOTING FRIENDLY RELATIONS

1. MFF shall promote friendly relations between its Members, Clubs, Officials and Players and in society for humanitarian objectives.
2. MFF shall have the necessary institutional means to resolve any internal dispute that may arise between Members, Clubs, Officials, and Players of MFF.

7-Р ЗҮЙЛ. **ТОГЛОГЧ**

1. Тоглогчийн статус ба шилжилт хөдөлгөөнийг ОУХБХ-ны Тоглогчийн шилжилт хөдөлгөөний журамд нийцүүлэн МХБХ-ны Зөвлөлөөс баталсан “Тоглогчийн эрх зүйн байдал ба шилжилт хөдөлгөөний журам”-аар зохицуулна.
2. Тоглогчдыг Холбооны журмын дагуу бүртгэнэ.

8-Р ЗҮЙЛ. **ТОГЛОЛТЫН ДҮРЭМ**

1. Холбоо, түүний гишүүд нь Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс баталсан “Тоглолтын дүрэм”-ийн дагуу холбооны тэмцээн уралдаанд оролцоно. “Тоглолтын дүрэм”-ийг гагцхүү Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс (IFAB) тогтоох ба өөрчилнө.
2. Холбоо болон түүний гишүүд футзалыг “Футзалын тоглолтын дүрэм”-ийн дагуу тоглоно. Футзалын тоглолтын дүрмийг зөвхөн ОУХБХ-ноос тогтоох ба өөрчилнө.
3. Холбоо болон түүний гишүүд элсний хөлбөмбөгийг “Элсний хөлбөмбөгийн тоглолтын дүрэм”-ийн дагуу тоглоно. Элсний хөлбөмбөгийн тоглолтын дүрмийг зөвхөн ОУХБХ-ноос тогтоох ба өөрчилнө.

9-Р ЗҮЙЛ. **БАЙГУУЛЛАГА, АЛБАНЫ ХҮМҮҮСИЙН ЁС ЗҮЙ**

1. Холбооны бүхий л байгууллагын гишүүд, албаны хүмүүс нь үйл ажиллагаандаа ОУХБХ, АХБХ, ЗАХБХ болон Холбооны дүрэм, журам, шийдвэр, зааварчилга болон Сахилгын ба Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.
2. МХБХ-ны газар нутагт Холбооны хөлбөмбөг, элсний хөлбөмбөг, футзалын тэмцээн уралдаанд оролцож буй хүн, байгууллага бүр ОУХБХ, АХБХ, ЗАХБХ, МХБХ-ны үндсэн дүрэм болон бусад журмуудыг дагаж мөрдөн, шударга байдал, шударга тоглолт, эв нэгдэл, спортын мөн чанарыг сахин хүндэтгэнэ.

ARTICLE 7 PLAYERS

1. The status of Players and the provisions for their transfer shall be regulated by the Council of MFF in accordance with the FIFA Regulations on the Status and Transfer of Players.
2. Players shall be registered in accordance with the regulations of MFF.

ARTICLE 8 LAWS OF THE GAME

1. MFF and each of its Members play Association Football in compliance with the Laws of the Game issued by IFAB. Only IFAB may lay down and alter the Laws of the Game.
2. MFF and each of its Members play futsal in accordance with the Futsal Laws of the Game issued by FIFA. Only FIFA may lay down and alter the Futsal Laws of the Game.
3. MFF and each of its Members play beach soccer in accordance with the Beach Soccer Laws of the Game issued by FIFA. Only FIFA may lay down and alter the Beach Soccer Laws of the Game.

ARTICLE 9 CONDUCT OF BODIES AND OFFICIALS

1. All bodies and Officials of MFF must observe the Statutes, regulations, directives, decisions and the Code of Ethics and the Disciplinary Code of FIFA, AFC, EAFF and MFF in their activities.
2. Every person and organisation involved in the game of Association Football, futsal, and beach soccer in the territory of MFF is obliged to observe the Statutes and regulations of FIFA, AFC, EAFF, MFF and any other relevant statutes, as well as the principles of fair play, loyalty, integrity and sportsmanship.

10-Р ЗҮЙЛ. АЛБАН ЁСНЫ ХЭЛ

1. Холбооны албан ёсны хэл нь Монгол хэл байна. Холбооны дүрэм, журмууд зэрэг албан ёсны бичиг баримтуудыг Монгол ба Англи хэл дээр үйлдэнэ. Хэрэв дүрэмд зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.
2. Их хурлын албан ёсны хэл Монгол хэл байна.

II. ГИШҮҮНЧЛЭЛ

11-Р ЗҮЙЛ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ГИШҮҮНЧЛЭЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ

1. Гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх ба гишүүнээс чөлөөлөх асуудлыг Холбооны Их хурал шийдвэрлэнэ.
2. Тус дүрмийн дагуу Холбооноос тавьж буй шаардлагыг хангасан тохиолдолд гишүүнээр элсүүлж болно.
3. Гишүүнээс татгалзсан эсвэл чөлөөлөгдсөн тохиолдолд гишүүнчлэлийг дуусгавар болгоно. Гишүүнчлэлээ алдсанаар уг гишүүний Холбоонд хамаарах бүхий л эрх дуусгавар болох боловч энэ нь гишүүн байхдаа Холбоо болон Холбооны бусад гишүүдийн өмнө хүлээсэн санхүүгийн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
4. Дүрмийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тус гишүүнийг Дүрмийн 17, 18 дугаар зүйлүүдийн дагуу Их хурлаар эрхийг нь түдгэлзүүлэх, эсвэл чөлөөлнө.
5. Холбоо холбогдох бүх оролцогч талуудыг Их хуралд оролцуулах боломжийг хангах бөгөөд эмэгтэй хөлбөмбөгийн сонирхол Их хуралд зүй зохистойгоор төлөөлөгдсөн байна.

ARTICLE 10 OFFICIAL LANGUAGES

1. The official language of MFF shall be Mongolian. MFF Statutes and regulations shall be written in Mongolian and English. In the event of an inconsistency in the MFF Statutes and regulations, the English version prevails.
2. The official language at the Congress shall be Mongolian.

II. MEMBERSHIP

ARTICLE 11 ADMISSION, SUSPENSION, AND EXPULSION

1. The Congress shall decide whether to admit, suspend or expel a Member.
2. Admission may be granted if the applicant fulfils the requirements of MFF in accordance with these Statutes.
3. Membership is terminated by resignation or expulsion. Loss of membership does not relieve the Member from its financial obligations towards MFF or other Members of MFF, but leads to cancellation of all rights in relation to MFF.
4. A Member which fails to meet its obligations stipulated in art. 16 par. 1 of these Statutes, may be suspended or expelled by the Congress in accordance with art. 17 and 18 of these Statutes.
5. MFF shall ensure that all relevant stakeholders are represented within its Congress. The interests of women's football shall also be adequately represented in the Congress.

12-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

1. Холбоо нь дараах Их хурлын гишүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - 1.1. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоод (21 аймаг тус бүрээс 1);
 - 1.2. Клубүүд 24 (Клуб лицензжүүлэх журамд заасан шаардлага хангасан);
 - 1.3. Шүүгчдийн зөвлөл;
 - 1.4. Дасгалжуулагчдын зөвлөл;
 - 1.5. Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөл;
 - 1.6. Мастер ангиллын тамирчдын зөвлөл;
 - 1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл.

13-Р ЗҮЙЛ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ

1. Холбооны гишүүнээр элсэх хүсэлтэй хуулийн этгээд Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газарт бичгээр хүсэлтээ гаргаж өгнө.
2. Өргөдөлд дараах зайлшгүй дагалдах бичиг баримтыг хавсаргасан байна. Үүнд:
 - 2.1. Хүсэлт гаргагчийн хуулийн хүчин төгөлдөр дүрмийн хуулбар;
 - 2.2. ОУХБХ, АХБХ, ЗАХБХ болон Холбооны дүрэм, журам, шийдвэрийг өөрөө болон гишүүд, клубүүд, албаны хүмүүс, тоглогчид нь дагаж биелүүлэх амлалт;
 - 2.3. Хүчин төгөлдөр үйлчилж буй хөлбөмбөг, футзал, элсний хөлбөмбөгийн тоглолтын дүрмийг сахиж биелүүлэх тухай амлалт;
 - 2.4. ОУХБХ, АХБХ, ЗАХБХ болон Холбооны дүрэм, журамд өөрөөр заагаагүй тохиолдолд ОУХБХ, АХБХ, ЗАХБХ болон Холбооны дүрэм, журам, шийдвэр болон зааврыг тайлбарлах, хэрэглэх асуудлаар шүүхэд хандахгүй гэсэн амлалт;

ARTICLE 12 MEMBERS

1. The Members of MFF are:
 - 1.1. The 21 Regional Football Associations;
 - 1.2. 24 Clubs (who fulfilled requirements under the Club licensing regulation);
 - 1.3. The Refereeing board;
 - 1.4. The Coaching board;
 - 1.5. The Women's board;
 - 1.6. Players' board for master level;
 - 1.7. The Disability football board;

ARTICLE 13 ADMISSION

1. Any legal entity wishing to become a Member of MFF shall apply in writing to the general secretariat of MFF.
2. The application must be accompanied by the following mandatory items:
 - 2.1. a copy of its legally valid statutes and regulations;
 - 2.2. a declaration that it will always comply with the Statutes, regulations and decisions of MFF, FIFA, AFC and EAFF and ensure that these are also respected by its own members, clubs, officials and players;
 - 2.3. a declaration that it will comply with the Laws of the Game in force as laid down by The IFAB, as well as the Beach Soccer Laws of the Game and the Futsal Laws of the Game as laid down by FIFA;
 - 2.4. a declaration that it will not take matters of interpretation and application of the FIFA, AFC, EAFF and MFF Statutes, regulations, decisions and directives to Ordinary Courts, unless the FIFA, the AFC, EAFF or the MFF regulations provide for or stipulate recourse to Ordinary Courts;

- 2.5. Энэ дүрэмд заасан Швейцарийн Лозанна хотноо төвтэй Олон улсын спортын арбитрын шүүхийг (CAS) болон Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитрыг хүлээн зөвшөөрч байгаа тухай мэдэгдэл;
- 2.6. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 2.7. Талбайн эзэн багийн албан ёсны бүх тоглолтоо Монгол улсын нутаг дэвсгэрт явуулах тухай амлалт;
- 2.8. Гишүүнээр элсэх хүсэлт гаргасан хуулийн этгээд нь эрх зүйн хувьд гадны ямар нэгэн нөлөөгүйгээр бие даан шийдвэр гаргах чадвартай гэсэн тодорхойлолт;
- 2.9. Гуравдагч этгээдтэй байгуулах хууль зүйн гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалт;
- 2.10. Холбоотой урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр нөхөрсөг тоглолт зохион байгуулах буюу нөхөрсөг тоглолтод оролцоно гэсэн амлалт;
- 2.11. Өөрийн эрх барих дээд байгууллагын хамгийн сүүлд хуралдсан хурлын тэмдэглэлийн хуулбар;
- 2.12. Хөгжлийн хөтөлбөр;
- 2.13. Аудит хийсэн санхүүгийн тайлан;
- 2.14. Клуб бүртгүүлэх тохиолдолд Клуб лицензжүүлэх журмын дагуу шаардлага хангасан лицензтэй байх. (А, В, С лиценз)

14-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

1. Их хурлын гишүүнээр элсүүлэх үйл ажиллагааг Холбооны Зөвлөлөөс баталсан тусгай журмаар зохицуулна.
2. Их хурлын шинэ гишүүнийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг Зөвлөлийн санал болгосноор Их хурал шийдвэрлэнэ. Их хурлын гишүүнээр элсэх болсон шалтгаанаа Их хуралд мэдүүлнэ.

- 2.5. a declaration that it recognises the Court of Arbitration for Sport (CAS) in Lausanne, and (if applicable) the Mongolian International and National Sports Arbitration Tribunal, as specified in these Statutes;
- 2.6. a declaration that it is located and registered in the territory of Mongolia;
- 2.7. a declaration that it will play all official home matches in the territory of Mongolia;
- 2.8. a declaration to the effect that the legal composition of the applicant guarantees that it can make decisions independently of any external entity;
- 2.9. a list of Officials, specifying those who are authorised signatories with the right to enter into legally binding agreements with third parties;
- 2.10. a declaration that it undertakes to organise or participate in friendly matches only with the prior consent of MFF;
- 2.11. a copy of the minutes of its last congress or constitutional meeting;
- 2.12. a Development program (if any strategic plan);
- 2.13. the Audited financial balance and report;
- 2.14. In case of a Club, it needs to have a license under the Club licensing regulations (categories A, B or C).

ARTICLE 14 **REQUEST AND PROCEDURE FOR APPLICATION**

1. The procedure for admission of Members shall be regulated by special regulations approved by the Council of MFF.
2. The Council shall request the Congress either to admit or not to admit an applicant. The applicant may state the reasons for its application to the Congress.

3. Их хурлын шинэ гишүүн нь Их хурлаар хүлээн зөвшөөрөгдсөн үеэс эхлэн Холбооны гишүүнчлэлийн эрх ба үүрэг үүснэ. Их хурлын гишүүн сонгогдох эрхээ нэн даруй эдэлнэ.

15-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЭРХ**

1. Холбооны гишүүд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 1.1. Их хуралд оролцох, хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах, товлосон хугацаанд Их хуралд дуудагдах, санал өгөх эрхээ эдлэх;
 - 1.2. Их хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах, хуралдаанд оролцох, санал өгөх;
 - 1.3. Холбооны бүх байгууллагын сонгуульд нэр дэвшүүлэх;
 - 1.4. Холбооны үйл ажиллагааны талаар Холбооны эрх бүхий байгууллагаас мэдээлэл авах;
 - 1.5. Холбооноос зохион байгуулж буй бүхий л тэмцээн, уралдаан болон спортын бусад арга хэмжээнд оролцох,
 - 1.6. Холбооны дүрэм, журамд тусгагдсан бусад эрх.
2. Дээр дурдсан эрхийг хэрэгжүүлэхэд энэхүү Дүрмийн бусад заалт болон холбогдох журмыг удирдлага болгоно.

16-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ**

1. Холбооны гишүүд дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 1.1. ОУХБХ, АХБХ, ЗАХБХ тэдгээрийн байгууллагууд болон Холбооны дүрэм, журам, заавар болон шийдвэрийг биелүүлэх, хүндэтгэн сахих, өөрийн гишүүдээр хангуулах;
 - 1.2. Шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудаа дөрвөн жил тутамд нэг удаа сонгох;
 - 1.3. Байгууллагынхаа эрх барих дээд байгууллагын хурлыг тогтмол, жилд нэг удаа аль эсвэл тодорхой нөхцөлд хоёр жилд нэгээс доошгүй удаа тус тус хуралдуулах;

3. The new Member shall acquire membership rights and duties as soon as it has been admitted by the Congress. Its delegates are eligible to be elected with immediate effect.

ARTICLE 15 MEMBERS' RIGHTS

1. The Members of MFF have the following rights:
 - 1.1. to take part in the Congress of MFF, to know its agenda in advance, to be called to the Congress within the prescribed time and to exercise their voting rights;
 - 1.2. to draw up proposals for inclusion in the agenda of the Congress;
 - 1.3. to nominate candidates for elections to all bodies of MFF;
 - 1.4. to be informed of the affairs of MFF through the official bodies of MFF;
 - 1.5. to take part in competitions [if applicable] and/or other sporting activities organised by MFF;
 - 1.6. to exercise all other rights arising from the Statutes and regulations of MFF.
2. The exercise of these rights is subject to other provisions in these Statutes and the applicable regulations.

ARTICLE 16 MEMBERS' OBLIGATIONS

1. The Members of MFF have the following obligations:
 - 1.1. to comply fully with the Statutes, regulations, directives and decisions of FIFA, AFC, EAFF and MFF at all times and to ensure that these are also respected by its member;
 - 1.2. to ensure the election of its decision-making bodies every four years;
 - 1.3. to convene its supreme and legislative body at regular intervals, as a general rule once a year, but in circumstances so require, at least every two years;

- 1.4. Холбооноос зохион байгуулах тэмцээн болон спортын бусад арга хэмжээнд оролцох;
- 1.5. Гишүүний татвараа төлөх;
- 1.6. Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс баталсан Тоглолтын дүрэм ба ОУХБХ-ноос баталсан футзал, элсний хөлбөмбөгийн дүрмүүдийг өөрөө болон гишүүдээрээ сахин мөрдүүлэх;
- 1.7. ОУХБХ-ны дүрэм ба энэхүү дүрэмд заасны дагуу ОУХБХ, АХБХ, ЗАХБХ болон Холбооны дүрэм, журам, заавар болон шийдвэртэй холбогдох тухайн гишүүн буюу өөр гишүүнийг хамарсан аливаа маргааныг Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитрт гаргах, Холбоо нь Үндэсний Арбитргүй бол зөвхөн Швейцарь улс дахь Лозанна хотод байрладаг Спортын арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх гэсэн заалтыг өөрийн дүрэмдээ тусгах мөн уг асуудлаар шүүхэд хандахыг хориглох;
- 1.8. Асуудлаа бие даан хараат бусаар шийдвэрлэх, энэ дүрмийн 20-р зүйл заалтанд заасны дагуу гуравдагч этгээдийн нөлөөгүйгээр өөрийн үйл ажиллагааг эрхлэх;
- 1.9. Байгууллагууд нь сонгууль эсвэл томилгооны хараат бус байдлын дагуу сонгогдох эсвэл томилогдох;
- 1.10. Өөрийн дотоод дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан мөн гуравдагч этгээдтэй байгуулах хууль зүйн заавал биелүүлэх гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд Холбоонд нэн даруй мэдэгдэх;
- 1.11. Их хурлаас хүлээн зөвшөөрөөгүй болон гишүүнчлэлийг нь түдгэлзүүлсэн эсвэл гишүүнээс чөлөөлөгдсөн байгууллага, хувь хүмүүстэй спортын харилцааг тогтоохгүй байх;
- 1.12. Шударга тоглолтын илэрхийлэл болсон тууштай үнэнч, эв нэгдэл, спортын сахилгын зарчмуудыг өөрийн дүрэмд тусгаж мөрдөх;

- 1.4. to take part in competitions [if applicable] and other sporting activities organised by MFF;
- 1.5. to pay their membership subscriptions;
- 1.6. to respect the Laws of the Game as laid down by IFAB and the Beach Soccer and Futsal Laws of the Game as laid down by FIFA, and to ensure that these are also respected by its members through a statutory provision;
- 1.7. to adopt a statutory clause specifying that any dispute requiring arbitration involving itself or one of its members and relation to the Statutes, regulations, directives and decisions of FIFA, AFC, or MFF shall only be referred to the Mongolian International and National Sports Arbitration Tribunal, as specified in the FIFA Statutes and in these Statutes and that any recourse to Ordinary Courts is prohibited;
- 1.8. to manage their affairs independently and ensure that their own affairs are not influenced by any third parties in accordance with art. 20 of these Statutes;
- 1.9. to ensure that their bodies are either elected or appointed according to a procedure that guarantees the complete independence of the election or appointment;
- 1.10. to immediately communicate to MFF any amendment of its statutes and regulations as well as the list of its Officials or persons who are authorised signatories with the right to enter legally binding agreements with third parties;
- 1.11. not to maintain any relations of a sporting nature with entities that are not recognised or with Members that have been suspended or expelled by the Congress;
- 1.12. to observe the principles of loyalty, integrity and good sporting behaviour as an expression of fair play through a statutory provision;

- 1.13. Гишүүнийхээ хугацаанд дүрмийн 13 дугаар зүйлийн 2-р заалтыг бүрэн биелүүлэх;
 - 1.14. Гишүүд нь өөрийн гишүүний бүртгэлийг хөтөлж, байнга шинэчлэх, шинэчилсэн тухай нэн даруй Холбоонд бичгээр мэдэгдэх;
 - 1.15. Өөрийн дүрмийг Холбооны дүрмийн шаардлагад нийцүүлэн батлах;
 - 1.16. ОУХБХ, АХБХ, ЗАХБХ болон Холбооны дүрэм, журамд заасан бусад үүргийг дагаж мөрдөх;
 - 1.17. ОУХБХ-ны дүрмийн дагуу шигшээ багт дуудагдсан тоглогчдыг нэн даруй шигшээ багийн бэлтгэлд хамрагдахыг зөвшөөрөх.
2. Дээр дурдсан үүргийг зөрчсөн үйлдэл нь тухайн гишүүнд энэ дүрэмд заасны дагуу шийтгэл оногдуулах үндэслэл болно.
 3. Гуравдагч этгээдийн нөлөөллөөс үл хамаарч энэ зүйлийн 1.8 дахь заалтыг зөрчсөн үйлдэл нь тухайн гишүүний санаатай, болгоомжгүй, гэм буруугүй зэргээс үл хамаарч сахилгын шийтгэл оногдуулна. МХБХ-ны гишүүн бүр, өөрийн гишүүдийн үл тоосон, хайхрамжгүй байдал, санаатай буруу үйлдлийн улмаас буй болсон аливаа асуудлыг МХБХ-ны өмнө хариуцна.

17-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ**

1. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Их хурал шийдвэрлэнэ. Гэхдээ Гишүүн үүргийн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд Зөвлөл гишүүнчлэлийг түр түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно. Ийнхүү түдгэлзүүлсэн бол Зөвлөл уг шийдвэрийг цуцлаагүй тохиолдолд дараагийн Их хурал хүртэл хүчинтэй хэвээр байна.
2. Санал өгөх эрхтэй гишүүдийн 50-аас дээш хувийн олонх оролцож байж гишүүнчлэлийг түдгэлзүүлэх асуудалд санал хураана. Гишүүнчлэлийг түдгэлзүүлснийг Их хуралд оролцсон, санал өгөх эрхтэй нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар баталгаажуулна. Ийнхүү баталгаажуулаагүй тохиолдолд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн нь шууд цуцлагдана.

- 1.13. to observe the mandatory items specified under art 13, par 2 of these Statutes for the duration of their affiliation;
 - 1.14. to administer a register of members which shall regularly be updated. Shall communicate the updated record to MFF through written form;
 - 1.15. to ratify statutes that are in accordance with the requirements of the Statutes of MFF;
 - 1.16. to comply fully with all other duties arising from the Statutes and other regulations of FIFA, AFC, EAFF and MFF;
 - 1.17. to release the players to the national teams of Mongolia in necessary course in accordance with the pertinent FIFA regulations.
2. Violation of the above-mentioned obligations by any Member may lead to sanctions as provided for in these Statutes.
 3. Violation of par. 1.8. above may also lead to sanctions, even if the third-party influence was not the fault of the Member concerned. Each Member of MFF is responsible towards MFF for any and all acts of the members of their bodies caused by the gross negligence or wilful misconduct of such members.

ARTICLE 17 **SUSPENSION**

1. The Congress is responsible for suspending a Member. The Council may, however, temporarily suspend a Member that seriously violates its obligations as a Member with immediate effect. The suspension shall last until the next Congress, unless the Council has lifted it in the meantime.
2. The presence of a majority (more than 50%) of the delegates representing the Members eligible to vote is necessary for a suspension to be valid. A suspension of a Member by the Congress or the Council shall be confirmed at the next Congress by two-thirds of the delegates representing the members present and eligible to vote. If it is not confirmed, the suspension is automatically lifted.

3. Гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөлд гишүүний эрх дуусгавар болно. Холбооны бусад гишүүд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн гишүүнтэй спортын чиглэлээр харилцаа хөгжүүлэхгүй. Гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн тохиолдолд өөр бусад шийтгэлийг мөн Сахилгын хорооноос ногдуулж болно.
4. Холбооноос зохион байгуулдаг үйл ажиллагаанд давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар нэг жил оролцоогүй тохиолдолд гишүүнээс түдгэлзүүлж ээлжит Их хуралд санал өгөх эрхгүйгээр оролцох бөгөөд уг үүргээ биелүүлтэл тухайн гишүүний төлөөлөл нь сонгогдох ба томилогдох эрх эдлэхгүй болно.

18-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ, ХӨӨХ**

1. Гишүүн нь ОУХБХ, АХБХ, ЗАХБХ, МХБХ-ны дүрэм, журам, шийдвэрийг ноцтойгоор, удаа дараа зөрчсөн тохиолдолд Их хурал гишүүнээс чөлөөлнө.
2. Гишүүн энэ дүрмийн 17 дугаар зүйлд заасан үүрэг, ОУХБХ, АХБХ, ЗАХБХ, МХБХ-ны дүрэм, журам, шийдвэр, зааварчилгааг арванхоёроос ихгүй сараар зөрчсөн тохиолдолд гишүүнээс чөлөөлөх, хөөх үндэслэл болно. Гишүүнээс түдгэлзсэн хугацаандаа зөрчлөө арилгаагүй тохиолдолд гишүүнээс хөөнө.
3. Гишүүнээс чөлөөлөх асуудлыг санал өгөх эрхтэй Их хурлын төлөөлөгчдийн ирц олонх (50 хувиас дээш) байж хэлэлцэх бөгөөд шийдвэр нь төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар хүчин төгөлдөр болно.

19-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ТАТГАЛЗАХ**

1. Их хурлын гишүүд нь Холбооны гишүүнчлэлээс татгалзаж болох ба энэ шийдвэр нь тухайн оны хөлбөмбөгийн улирлын төгсгөлд хэрэгжиж эхэлнэ. Их хурлын гишүүнээс татгалзах өргөдлөө хөлбөмбөгийн улирал дуусахаас зургаан сарын өмнө Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн байна.
2. Холбоо болон бусад гишүүдийн өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ дуусгавар болгосон нөхцөлд Их хурлын гишүүнээс татгалзах асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

3. A suspended Member shall lose its membership rights. Other Members may not entertain sporting contact with a suspended Member. The Disciplinary Committee may impose further sanctions.
4. Members that do not participate in the sporting activities of MFF for a full calendar year shall be suspended from membership and suspended from voting at the Congress and their representatives shall not be elected or appointed until they have fulfilled their obligations in this respect. This provision shall not apply in case the non-participation was the direct result of a force majeure situation.

ARTICLE 18 **EXPULSION**

1. The Congress may expel a Member if it seriously and repeatedly violates the Statutes, regulations, directives or decision of FIFA, AFC, EAFF and MFF.
2. A Member may also be expelled by the Congress if it was suspended on the basis of art. 17 of these Statutes for a period of no less than 12 months for having violated the Statutes, regulations, directives or decisions of FIFA, AFC, EAFF and MFF and does not remedy the relevant violation following that period of suspension.
3. The presence of a majority (more than 50%) of delegates representing the Members eligible to vote at the Congress is necessary for an expulsion to be valid, and the motion for expulsion must be adopted by a 2/3 majority of the valid votes cast.

ARTICLE 19 **RESIGNATION**

1. Member may resign from MFF with effect from the end of the football season. Notice of resignation must reach the general secretariat no later than six months before the end of the football season.
2. The resignation is not valid until the Member wishing to resign has fulfilled its financial obligations towards MFF and the other Members of MFF.

20-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮД БОЛОН ТЭДГЭЭРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БИЕ ДААСАН БАЙДАЛ**

1. Гишүүн бүр гуравдагч этгээдийн нөлөөнд үл автан, бие дааж, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулна.
2. Холбооны Их хурлын гишүүд өөрийн дотоод байгууллагуудаа сонгож, томилох бөгөөд гишүүд дүрэмдээ энэ эрхээ бие дааж хэрэгжүүлэхээ баталгаажуулна.
3. Уг зүйлийн 2-т заасны дагуу сонгогдож томилогдоогүй байгууллагыг Холбоо хүчин төгөлдөрт тооцохгүй.
4. Уг зүйлийн 2-т заасны дагуу сонгогдож томилогдоогүй байгууллагын шийдвэрийг Холбоо хүчин төгөлдөрт тооцохгүй.

21-Р ЗҮЙЛ. **КЛУБ, ЛИГ, ОРОН НУТГИЙН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО БОЛОН БУСАД КЛУБУУДИЙН НЭГДЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

1. Клуб, Лиг, Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо болон бусад клубүүдийн нэгдэл нь Холбоогоор хүлээн зөвшөөрөгдөж, түүний удирдлага дор үйл ажиллагаагаа явуулна. Монгол улсын хэмжээнд үндэсний мэргэжлийн нэг дээд лиг байна. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо, клубүүдийн эрх хэмжээ, эрх үүргийг Холбооны Их хурлаар баталсан жишиг дүрмийн дагуу тодорхойлно. Шүүгч, сэргээш, тоглогчийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн, клуб лицензжүүлэлт, сахилгын болон ёс зүйн арга хэмжээ, тэмцээн уралдааны шударга байдлыг хамгаалахтай холбоотой асуудлыг Холбооны бүрэн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэнэ.
2. Клуб, Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо, албан ёсны гишүүнчлэлтэй холбоод нь аливаа гадны байгууллагаас үл хамааран бие даан шийдвэр гаргана. Энэ үүрэг нь зохион байгуулалтын бүтцээс үл хамааран бүх клуб, орон нутгийн хөлбөмбөгийн холбоодод хамаатай болно.
3. Аливаа тоглолт, тэмцээний шударга байдал алдагдахаас сэргийлж хувь хүн болон хуулийн этгээд (үүнд үндсэн болон охин компаниуд багтана) нэгээс илүү клубийг хянах, харьяалагдахыг хориглоно.

ARTICLE 20 INDEPENDENCE OF MEMBERS AND THEIR BODIES

1. Each Member shall manage its affairs independently and with no influence from third parties.
2. The Members' bodies shall be either elected or appointed. The Members' statutes shall provide for a procedure that guarantees the complete independence of the election or appointment.
3. Any Member's bodies that have not been elected or appointed in compliance with the provisions of par. 2 above, even on interim basis, shall not be recognised by MFF.
4. Decisions passed by bodies that have not been elected or appointed in compliance with par. 2 shall not be recognised by MFF.

ARTICLE 21 STATUS OF CLUBS, LEAGUES, REGIONAL FOOTBALL ASSOCIATIONS, AND OTHER GROUPS OF CLUBS

1. Clubs, Leagues, Regional Football Associations or any other groups of clubs affiliated to MFF shall be subordinate to and recognised by MFF. There shall only be one top-tier national league on the territory of MFF. These Statutes define the scope of authority and the rights and duties of these clubs and groups. Their statutes and regulations must be approved by the MFF and must be in line with the Example Statutes approved by the Congress. MFF shall have the primary responsibility to regulate matters relating to refereeing, the fight against doping, the registration of players, club licensing, the imposition of disciplinary measures, including for ethical misconduct, as well as measures required to protect the integrity of competitions.
2. The affiliated Clubs, Regional Football Associations and groups of MFF shall take all decisions on any matters regarding their membership independently of any external body. This obligation applies regardless of their corporate structure.
3. In any case, no natural or legal person (including holding companies and subsidiaries) shall exercise control over and/or belong to more than one Club or group whenever the integrity of any match or competition could be jeopardised.

22-Р ЗҮЙЛ. **ГИШҮҮН**

1. Гишүүнээр элсүүлэх үйл ажиллагааг Холбооны Зөвлөлөөс баталсан тусгай журмаар зохицуулна.
2. Гишүүний үүрэг, хариуцлагыг Холбооны тухайлсан дүрэм, журмаар зохицуулна. Эсвэл Их хурлын гишүүнд тавигдах шаардлага бүхий журмаар шийдвэрлэж болно. Гишүүн нь Холбооны Их хурлын гишүүн болж болох бөгөөд энэ дүрмийн 13, 14 дүгээр зүйл заалтуудад заасныг дагаж мөрдөнө.

III. ХҮНДЭТ ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ХҮНДЭТ ГИШҮҮД

23-Р ЗҮЙЛ. **ХҮНДЭТ ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ХҮНДЭТ ГИШҮҮД**

1. Холбооны Их хурлаас хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэх үйлсэд онцгой гавьяа байгуулсан хувь хүнд Хүндэт Ерөнхийлөгч эсвэл хүндэт гишүүний цол, өргөмжлөлийг олгоно.
2. Зөвлөл энэ цол, өргөмжлөлд нэр дэвшүүлнэ.
3. Хүндэт Ерөнхийлөгч эсвэл хүндэт гишүүд Их хуралд оролцоно. Тэд Их хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүй байна.

ARTICLE 22 AFFILIATES

1. The procedure for admission of affiliates shall be regulated by special regulations approved by the Council of MFF.
2. The rights and obligations of affiliates shall be defined in the regulations of MFF or in the regulations of the Members of MFF. Affiliates may also become Members of MFF, provided they comply with the provisions of art. 13 and 14 of these Statutes.

III. HONORARY PRESIDENT AND HONORARY MEMBER

ARTICLE 23 HONORARY PRESIDENT AND HONORARY MEMBER

1. The Congress may bestow the title of honorary president or honorary member upon any person for meritorious service to football.
2. The Council shall make these nominations.
3. The honorary president or honorary member may take part in the Congress. They may join the debates but are not entitled to vote.

IV. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

24-Р ЗҮЙЛ. ХОЛБООНЫ БҮТЦИЙН БАЙГУУЛЛАГУУД

1. Холбооны Их хурал нь Холбооны эрх барих дээд байгууллага мөн болно.
2. Холбооны Ерөнхийлөгч нь Холбоог албан ёсоор төлөөлнө.
3. Холбооны Зөвлөл нь стратеги ба бодлого тодорхойлох байгууллага мөн.
4. Байнгын болон түр хороод нь Зөвлөлд үүргээ биелүүлэхэд нь зөвлөж туслалцаа үзүүлнэ.
5. Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь захиргааны байгууллага мөн.
6. Хараат бус байгууллагууд нь тус дүрэм болон зохих журмуудын дагуу байгуулагдсан байна. Хараат бус байгууллагууд гэдэгт Сонгуулийн хороод болон Эрх зүйн байгууллагууд, Аудит ба дүрэм журмын хяналтын нэгж тус тус хамаарна.
7. Сахилгын хороо, Ёс зүйн хороо болон Маргаан таслах хорооны үйл ажиллагаа нь Эрх зүйн байгууллагад хамаарна.
8. Клуб лицензжүүлэх системийг Клуб лицензжүүлэх байгууллагууд хариуцна.
9. Сонгуулийн хороод нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах болон хяналт тавих эрх бүхий байгууллага мөн.
10. Холбооны байгууллагуудыг тус дүрмийн дагуу ямар нэгэн хөндлөнгийн нөлөөгүйгээр, энэхүү дүрмийн дагуу Холбооноос шууд сонгох буюу томилно. Холбооны бүтцийн байгууллагын гишүүд нь Монгол улсын хууль дүрмийн дагуу ямарваа нэг ял, шийтгэл эдэлж байгаагүй этгээд байна.
11. Холбооны бүтцийн зураг Хавсралт №2-т заасны дагуу байна.
12. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, Холбооны байгууллагын аливаа гишүүн өөрт холбогдолтой асуудлыг шийдвэрлэхэд оролцохгүй байна. Ялангуяа эдгээр байгууллагын гишүүд нь ОУХБХ-ны Ёс зүйн дүрмийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зүйл заалтын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

IV. ORGANISATION

ARTICLE 24 BODIES OF MFF

1. The Congress is the supreme and legislative body.
2. President represents the MFF officially.
3. The Council is the strategic and oversight body.
4. Standing and ad-hoc committees shall advise and assist the Council in fulfilling its duties.
5. The general secretariat is the administrative body.
6. The independent bodies fulfil their functions in accordance with these Statutes and applicable regulations. The independent bodies are the Audit and Compliance Unit, the electoral committees and the judicial bodies.
7. The judicial bodies are the Disciplinary Committee, the Ethics Committee and the Appeal Committee.
8. The Club Licensing Bodies are in charge of the club licensing system within MFF.
9. The Electoral Committees are the bodies in charge of organising and supervising the election process.
10. The bodies of MFF shall be either elected or appointed by MFF itself without any external influence and in accordance with the procedures described in these Statutes. The members of the bodies of MFF shall not have previously been found guilty of any criminal offence under the laws of Mongolia incompatible with their position.
11. The organisational chart of MFF can be found in Annex 2.
12. Any member of the bodies must withdraw from the debate and from taking a decision if there is any risk or possibility of a conflict of interest. In particular, members of the bodies shall always be aware of, and comply with, the relevant provisions of the FIFA Code of Ethics on conflicts of interest and adjust their conduct as necessary (e.g. abstain from performing their duties, notify the chairperson in cases of potential conflicts of interest, etc.).

25-Р ЗҮЙЛ. БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛӨХ

1. Их хурал нь хувь хүн эсвэл байгууллагын гишүүнийг чөлөөлж болно. Зөвлөл нь Хараат бус байгууллагуудаас бусад байгууллагын гишүүнийг түр хугацаагаар чөлөөлж, дараагийн Их хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулна. Дараагийн Их хурал нь сонгуульт Их хурал байвал нэр дэвших зохих шалгуурыг хангаж, чөлөөлөгдсөн тухайн гишүүний асуудлыг чөлөөлөх тухай Их хурлын эцсийн шийдвэр нь сонгуулиас өмнө гарсан байх ёстой.
2. Байгууллагын гишүүнийг чөлөөлөх талаар санал гаргахад заавал шалтгаан, үндэслэлийг нь заан өгч түүнийгээ хэлэлцэх асуудлын хамт Зөвлөл ба Их хурлын төлөөлөгчдөд хүргэнэ.
3. Байгууллагын чөлөөлөгдөж буй гишүүн нь Зөвлөл болон Их хурлын өмнө өөрийгөө өмгөөлөх эрхтэй.
4. Чөлөөлөх асуудлыг хэлэлцэхдээ Зөвлөл болон Их хурлын санал хураалтыг нууцаар явуулж, хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёр (2/3)-ын саналаар шийдвэрлэнэ.
5. Үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн этгээд нь оногдсон үүргээсээ нэн даруй чөлөөлөгдөнө. (түр эсвэл бүрэн)

А. ИХ ХУРАЛ

26-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН ТОДОРХОЙЛОЛТ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

1. Их хурал нь Холбооны гишүүдийн тогтмол хуралддаг эрх барих дээд байгууллага бөгөөд дүрмийн дагуу хуралдсан Их хурлын шийдвэр нь хүчин төгөлдөр байх болно. Их хурал нь ардчилсан, хөлбөмбөг дэх хүйсийн эрх тэгш байдлыг хангасан зарчмыг баримтална. Их хурал нь тус Дүрмийн дагуу хуралдсан тохиолдолд шийдвэрийг хүчинтэйд тооцно.
2. Их хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас цахим хэлбэрээр хуралдаж болно. Харилцаа холбооны аргаар, телеконференц, видео хурал хэлбэрээр явагдах үед цахим саналыг хүчин төгөлдөрт тооцно. Сонгуульт Их хурлыг цахимаар зохион байгуулахгүй.

ARTICLE 25 DISMISSAL OF A MEMBER OF A BODY

1. The Congress may dismiss a member of a body. The Council may also dismiss a member of a body provisionally, with the exception of the members of the independent bodies. The provisional dismissal approved by the Council shall be confirmed by the next Congress, unless the Council has lifted it in the meantime. If the next Congress is of an elective nature, a dismissed member shall be allowed to be an elective candidate (provided that he fulfils the relevant eligibility criteria) on a conditional basis depending on the final decision of the Congress on his dismissal which shall be taken before the election.
2. The motion for dismissal must be justified and shall be sent to the members of the Council and/or to the Members of MFF along with the respective agenda.
3. The member of the body in question has the right to defend himself in front of the Council and/or the Congress.
4. The motion for dismissal shall be decided by means of secret ballot at the Council and/or the Congress. For the motion to be passed, a majority of two-thirds of the valid votes cast is required.
5. The member dismissed (provisionally or not) is relieved of his functions with immediate effect.

A. CONGRESS

ARTICLE 26 DEFINITION AND COMPOSITION OF THE CONGRESS

1. The Congress is the meeting at which all of the Members of MFF regularly convene. It represents the supreme and legislative authority of MFF. It must be constituted in accordance with the principles of representative democracy and taking into account the importance of gender equality in football. Only a Congress that is duly convened in accordance with the Statutes has the authority to make decisions.
2. A Congress may be an Ordinary or Extraordinary Congress. As a general rule, a Congress will be conducted in person. However, a Congress may be held by teleconference or videoconference, in case of force majeure except if it is an elective Congress.

3. Ерөнхийлөгч нь энэхүү Дүрэм, Их хурал хуралдуулах дэгийн заавар болон бусад холбогдох дүрэм журамд заасны дагуу Их хурлыг удирдан хуралдуулна.
4. Зөвлөл Их хуралд оролцох ажиглагчийг томилж болох бөгөөд тус ажиглагч нь хэлэлцүүлэгт орох болон санал өгөх эрхгүй байна.

27-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, САНАЛ ХУРААЛТ**

1. Их хурал 52 төлөөлөгчдөөс бүрдэнэ. Их хурлын төлөөлөгчдийн тоог дараах хуваарийн дагуу тогтооно. Үүнд:
 - 1.1. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо (21 аймаг) тус бүрээс 21;
 - 1.2. Холбоонд бүртгэлтэй Клубүүд 24;
 - 1.3. Шүүгчдийн зөвлөл 1;
 - 1.4. Дасгалжуулагчдын зөвлөл 1;
 - 1.5. Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөл 2;
 - 1.6. Мастер ангиллын тамирчдын зөвлөл 2 ;
 - 1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл 1.
2. Их Хурлын төлөөлөгч Холбооны гишүүн байгууллагыг төлөөлж түүнд харьяалагдсан байх бөгөөд тэндээсээ сонгогдсон буюу томилогдсон байна. Шаардлагатай гэж үзвэл үүнийгээ баримтаар баталгаажуулах болно.
3. Төлөөлөгч бүр Их хурлын санал хураалтад (саналын нэг эрхтэй) оролцоно. Их хуралд зөвхөн өөрийн биеэр оролцсон төлөөлөгч санал өгөх эрхтэй. Санал өгөх эрхээ бусдад шилжүүлэх эсвэл албан бичгээр санал өгөхийг хориглоно.
4. Зөвлөлийн гишүүд болон Ерөнхий нарийн бичгийн дарга Их хуралд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Зөвлөлийн гишүүд сонгуульт хугацаандаа харьяалагдах Холбооны гишүүн байгууллагаасаа Их хуралд төлөөлөгчөөр сонгогдож үл болно.

3. The President shall conduct the Congress in compliance with these Statutes, the Standing Orders of the Congress as well as any applicable regulations.
4. The Council may appoint observers who take part in the Congress without the right to debate or to vote.

ARTICLE 27 **DELEGATES AND VOTES**

1. The Congress is composed of 52 delegates. The number of delegates is allocated as follows:
 - 1.1 21 delegates for the Regional Football Associations (1 delegate per Regional Football Association);
 - 1.2 24 delegates for the clubs mentioned in art. 12 par. 1.2 (one delegate per club);
 - 1.3 one delegate for the Refereeing Board;
 - 1.4 one delegate for the Coaching Board;
 - 1.5 two delegates for the Women's' Football Board;
 - 1.6 two delegates for the Players' board for master level;
 - 1.7 one delegate for the Disability Football Board.
2. Delegates must belong to the Member that they represent and be appointed or elected by the appropriate body of that Member. They must also be able to produce evidence of this upon request.
3. Each delegate has one vote in the Congress. Only the delegates present are entitled to vote. Attendance by teleconference or by videoconference shall constitute presence. Voting by proxy or by letter is not permitted.
4. The Council and the General Secretary shall take part in the Congress without voting rights. During their terms of office, members of the Council may not be appointed as delegates for their association.

28-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

1. Их хурал дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
 1. Холбооны дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 2. Өмнөх хурлын тэмдэглэлийг хянах, батлах гурван гишүүнийг томилох;
 3. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид болон Зөвлөлийн гишүүдийг сонгох;
 4. Хараат бус байгууллагуудын дарга, дэд дарга болон гишүүдийг сонгох;
 5. Их хурлын тооллогын комиссын гурван гишүүнийг томилох;
 6. Санхүүгийн тайланг батлах;
 7. Төсөв батлах;
 8. Ажлын тайланг батлах;
 9. Зөвлөлийн санал болгосон хөндлөнгийн аудиторыг батлах;
 10. Зөвлөлийн саналын дагуу Холбооны гишүүдийн татварын хэмжээг тогтоох;
 11. Зөвлөлөөс Хүндэт Ерөнхийлөгч, Хүндэт гишүүн цол өргөмжлөл олгохоор нэр дэвшүүлсэн саналыг шийдвэрлэх;
 12. Их хурлын гишүүнээр элсүүлэх, Их хурлын гишүүнийг түдгэлзүүлэх болон Их хурлын гишүүнээс чөлөөлөх эсвэл хөөх асуудлыг шийдвэрлэх;
 13. Гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс чөлөөлөх эсвэл хөөх асуудлыг шийдвэрлэх;
 14. Холбооны байгууллагын гишүүдийг чөлөөлөх;
 15. Холбоог татан буулгах;
 16. Их хурлын гишүүнээс гаргасан хүсэлтийг дүрмийн дагуу хүлээж авах эсэх талаар шийдвэрлэх;

ARTICLE 28 AREAS OF AUTHORITY

1. The Congress has the following authority:
 1. adopting or amending the Statutes and the Standing Orders of the Congress;
 2. appointing three Members to check the minutes and approving the minutes of the last meeting;
 3. electing the President, the vice-presidents and members of the Council;
 4. electing the chairpersons, deputy chairpersons and members of the independent bodies;
 5. appointing the 3 scrutineers;
 6. approving the annual audited financial statements and the annual report;
 7. approving the budget;
 8. approving the activity report;
 9. appointing the independent and external auditors upon the proposal of the Council;
 10. fixing the membership subscriptions on the recommendation of the Council;
 11. deciding, upon the nomination of the Council, whether to bestow the title of honorary president or honorary member;
 12. admitting, suspending or expelling a Member;
 13. admitting, suspending or expelling a Affiliates;
 14. dismissing a member of a body of MFF;
 15. dissolving MFF;
 16. deciding on the request of a Member in accordance with these Statutes;

17. Дүрмийн дагуу гишүүнээс гаргасан хүсэлтийг тогтоолоор батлах, эсвэл дүрмийн дагуу Их хурлын гаргасан шийдвэрүүдийг тогтоолоор батлах.

29-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ИРЦ**

1. Их хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн ирц энгийн олонх (50 хувиас дээш)-д хүрсэн тохиолдолд Их хурлаас гарах шийдвэр хүчин төгөлдөр байна.
2. Хурлын ирц олонхид хүрээгүй тохиолдолд 24 цагийн дотор тухайн хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүйгээр Их хурлаа дахин хуралдуулна.
3. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Зөвлөлийн гишүүдийг сонгох, Холбооны байгууллагын нэг буюу хэд хэдэн гишүүнийг гишүүнээс чөлөөлөх болон Холбоог татан буулгах зэрэг асуудлаас бусад аливаа асуудлыг хэлэлцэхэд хоёр дахь удаагийн Их хурлын ирц олонх байх шаардлагагүй.
4. Их хурлын төлөөлөгчдийн ирцийг хүчин төгөлдөрт тооцсоны дараа төлөөлөгчид явсан тохиолдолд ирцэд нөлөөлөхгүй. Нэгэнт Их хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсоны дараа ирсэн төлөөлөгч Их хуралд санал өгөх эрхгүй оролцоно.

30-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ШИЙДВЭР**

1. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд саналыг илээр буюу цахим төхөөрөмжөөр хураана. Ил санал хураалтаар олонх болсон гэж тодорхойлоход хүндрэлтэй байвал Хурлын төлөөлөгчдийн нэрсийг цагаан толгойн дарааллын дагуу дуудаж санал хураана.
2. Энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр болоход олонхын санал (50 хувиас дээш) байхад хангалттай. Олонх болсныг тогтоохдоо хоосон ба хүчингүй болсон, түдгэлзсэн саналын хуудас болон цахим төхөөрөмжөөр будлиан үүсгэсэн саналыг хасаж тооцно.

17. passing decisions at the request of a Member in accordance with these Statutes or passing any decision entrusted to the Congress in accordance with these Statutes.

ARTICLE 29 **QUORUM OF THE CONGRESS**

1. Decisions passed by the Congress shall only be valid if a majority (more than 50%) of the delegates representing the Members eligible to vote are present.
2. If a quorum is not achieved, a second Congress shall take place within 24 hours with the same agenda.
3. A quorum is not required for the second meeting of the Congress unless any item on the agenda proposes the amendment of the Statutes of MFF, the election of the President, Vice Presidents and the election of the members of the Council, the dismissal of one or several members of a body of MFF, the expulsion of a Member of MFF or the dissolution of MFF.
4. Once it is declared that the Congress has been convened and composed in accordance with these Statutes, the quorum shall not be influenced by delegates departing. Delegates arriving after it has been declared that the Congress has been convened and composed in accordance with these Statutes may join the debates but may no longer vote.

ARTICLE 30 **DECISIONS OF THE CONGRESS**

1. A decision that requires a vote shall be reached by a show of hands or by means of an electronic count. If a show of hands does not result in a clear majority in favour of a motion, the vote shall be taken by calling the roll in alphabetical order.
2. Unless otherwise stipulated in the Statutes, a majority (more than 50%) of the valid votes cast is sufficient for a decision to be valid. Blank ballot papers, invalid votes or electronic votes manipulated in any other way as well as abstentions shall be disregarded when calculating the majority.

31-Р ЗҮЙЛ. СОНГУУЛЬ

1. Сонгуулийг нэр дэвшүүлж явуулна. Сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Нэр дэвшигчийн тоо мандатын тоотой тохирсон тохиолдолд нэр дэвшигчдийг карт эсвэл гар өргөж сонгоно.
2. Холбооны сонгууль, Холбооны гишүүдийн сонгуулийг дүрэмд өөрөөр заагаагүй бол Холбооны Сонгуулийн дүрмийн дагуу Сонгуулийн хороо явуулна.
3. Зөвлөлийн гишүүдийн сонгуулийг энэ дүрмийн 38.1-д заасны дагуу дараах дарааллаар явуулна. Үүнд:
 - 3.1. **Ерөнхийлөгч:** Ерөнхийлөгчийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдоно.
 - 3.2. **Дэд ерөнхийлөгч:** Дэд ерөнхийлөгчийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.
 - 3.3. **Эмэгтэй Дэд ерөнхийлөгч:** Эмэгтэй Дэд ерөнхийлөгчийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.
 - 3.4. **Зөвлөлийн бусад гишүүн:** Санал авсан эрэмбийн дагуу үлдсэн суудалд сонгогдоно.

ARTICLE 31 ELECTIONS

1. Elections shall take place by position and shall be conducted by secret ballot. If the number of candidates is equal to the number of vacancies, candidates may be elected by a show of hands or cards.
2. Elections of MFF shall be supervised by the MFF Electoral Committee and conducted in accordance with the Electoral Code of MFF.
3. Elections for positions of the Council shall follow the pre-defined order listed in art. 38 par. 1 below and shall be held as follows:
 - 3.1. **President:** A majority (more than 50%) of the valid votes cast is necessary for the election of the President. If there are more than two candidates for the office of President, whoever obtains the lowest number of votes is eliminated after each ballot. This process shall continue (if required) until only two candidates are left, and a majority (more than 50%) is achieved.
 - 3.2. **Vice president:** A majority (more than 50%) of the valid votes cast is necessary for the election of the Vice president. If there are more than two candidates for the office of Vice president, whoever obtains the lowest number of votes is eliminated after each ballot. This process shall continue (if required) until only two candidates are left, and a majority (more than 50%) is achieved.
 - 3.3. **Female vice president:** A majority (more than 50%) of the valid votes cast is necessary for the election of the female vice president. If there are more than two candidates for the office of the female Vice president, whoever obtains the lowest number of votes is eliminated after each ballot. This process shall continue (if required) until only two candidates are left, and a majority (more than 50%) is achieved.
 - 3.4. **Ordinary members:** For the election of the ordinary members, the candidate(s) who receive(s) the most votes in respect of the free seat(s) shall be elected.

- 3.5. **Эмэгтэй гишүүн:** Эмэгтэй гишүүнийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэр нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.
- 3.6. **Орон нутгийн төлөөлөл:** Орон нутгийн төлөөллийг Их хуралд оролцож буй 21 аймгийн төлөөлөгчдийн өгсөн саналаас хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчийг сонгоно. Тухайн нэр дэвшигчийг тус Их хурал дээр батламжилна.
- 3.7. **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөг:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл нь өөрийн дүрмийн дагуу төлөөллөө сонгох бөгөөд тус төлөөлөгчийг Холбооны Их хурлын гишүүдийн 50 хувиас дээш саналаар батламжилна.
4. Холбооны бусад байгууллагын дарга, дэд дарга болон гишүүдийг хамгийн их санал авсан дарааллаар сонгоно. Тус сонгуулийг багцаар нь явуулна.
5. Санал тэнцсэн тохиолдолд дараагийн санал хураалтыг тус Дүрэмд заасны дагуу дахин явуулна. (санал тэнцэж санал хураалтыг дахин явуулах тоо таваас хэтрэхгүй байна) Хэрэв дээрх тохиолдолд санал тэнцсээр байвал энэ Дүрмийн дагуу дараагийн сонгуульд Их хурал хүртэл албан тушаалыг хоосон үлдээнэ.
6. Холбооны бүтцийн байгууллагад нэр дэвшиж буй тухайн нэр дэвшигч сонгуульд Их хурал болохоос 30 хоногоос багагүй хугацааны өмнө Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газарт нэр дэвших өргөдлөө өгнө. Сонгуульд Их хурал болохоос 10 хоногийн өмнө Холбооны гишүүдэд нэр дэвшигчдийн нэрсийг хүргүүлсэн байна.
7. Хоосон саналын хуудас, хүчингүй саналын хуудас, цахим хуурамч саналын хуудас зэргийг саналын хүчинтэй хуудаст тооцохгүй.

- 3.5. **Female member:** A majority (more than 50%) of the valid votes cast is necessary for the election of the female member. If there are more than two candidates for the office of the female member, whoever obtains the lowest number of votes is eliminated after each ballot. This process shall continue (if required) until only two candidates are left, and a majority (more than 50%) is achieved.
- 3.6. **Member of the Regional Football Associations:** For the election of the member of the Regional Football Associations, the candidate who receives the most votes from the 21 delegates representing the Regional Football Associations at the Congress shall be elected. The successful candidate shall then be immediately ratified by the MFF Congress with a majority (more than 50%) of the valid votes cast.
- 3.7. **Member of the Disability Football:** The Disability Football Board shall elect its member according to its own rules and regulations during its own congress. The candidate proposed by the Disability Football Board shall be ratified by the MFF Congress with a majority (more than 50%) of the valid votes cast.
4. For the election of the Chairpersons, Deputy Chairpersons and members of all other bodies of MFF, the candidate(s) who receive(s) the most votes in respect of the free seat(s) or the list which receives the most votes shall be elected. These elections may be conducted en bloc.
5. In case of a tied vote in any elections of any body, further ballots shall be conducted in accordance with the procedure set forth in this article. If the tied vote remains after four (4) new rounds, the relevant position shall remain vacant until a new elective Congress convenes to proceed with new elections according to these Statutes.
6. Candidatures for any of the positions of any of the bodies of the MFF must be sent to the General Secretariat of MFF at the latest 30 days prior to the elective Congress. The official list of candidates must be passed to the members of the MFF 10 days before the relevant elective Congress.
7. Blank ballot papers, invalid votes or electronic votes manipulated in any way as well as abstentions shall be disregarded when calculating the majority.

32-Р ЗҮЙЛ. **ЭЭЛЖИТ ИХ ХУРАЛ**

1. Ээлжит Их хурал жил тутам хуралдана.
2. Их хурал болох өдөр, газрыг Зөвлөлөөс товлон. Их хурлын зарыг хуралдахаас 45 хоногийн өмнө гишүүдэд албан ёсоор мэдэгдэнэ.
3. Гишүүд Их хурлаар хэлэлцүүлэх аливаа саналаа бичгээр товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн газарт Их хурал болохоос 30 хоногийн өмнө ирүүлнэ.
4. Их хурал болохоос 10 хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудал, ажлын тайлан, санхүүгийн болон аудитын тайлан, бусад холбогдох бичиг баримтыг Холбооны Их хурлын төлөөлөгчдөд хүргүүлнэ.

33-Р ЗҮЙЛ. **ЭЭЛЖИТ ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Зөвлөл болон Их хурлын гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэж Их Хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулна.
2. Их хурал дараах асуудлыг дарааллын дагуу хэлэлцэнэ. Үүнд:
 - 2.1. Холбооны Их хурлыг Холбооны дүрмийн дагуу хүчин төгөлдөр болж буйг мэдэгдэх;
 - 2.2. Хэлэлцэх асуудлыг батлах;
 - 2.3. Ерөнхийлөгч үг хэлэх;
 - 2.4. Хурлын тэмдэглэл хянах гишүүдийг томилох;
 - 2.5. Тооллогын комиссын гишүүдийг томилох;
 - 2.6. Гишүүнээс түдгэлзүүлэх болон чөлөөлөх тухай асуудал (шаардлагатай бол);
 - 2.7. Өмнөх хурлын тэмдэглэлийг батлах;
 - 2.8. Ажлын тайлан; (өмнөх Их хурлаас хойш хийсэн ажлын тайлан)
 - 2.9. Санхүүгийн тайлан тэнцэл болон хараат бус хөндлөнгийн аудитын тайланг танилцуулах;

ARTICLE 32 ORDINARY CONGRESS

1. The Ordinary Congress shall be held every year.
2. The Council shall fix the place and date. The Members shall be notified in writing at least 45 days in advance.
3. Any proposal that a Member wishes to submit to the Congress shall be sent to the general secretariat in writing, with a brief explanation, at least 30 days before the date of the Congress.
4. The formal convocation shall be made in writing at least 10 days before the date of the Congress. This convocation shall contain the agenda, activity report, the financial statements and the auditors' report and any other relevant documents.

ARTICLE 33 ORDINARY CONGRESS AGENDA

1. The General Secretary shall draw up the agenda based on proposals from the Council and the Members.
2. The Congress agenda shall include the following mandatory items (in chronological order):
 - 2.1. a declaration that the Congress has been convened and composed in compliance with the Statutes of MFF;
 - 2.2. approval of the agenda;
 - 2.3. an address by the President;
 - 2.4. appointment of Members to check the minutes;
 - 2.5. appointment of scrutineers;
 - 2.6. suspension or expulsion of Members (if applicable);
 - 2.7. approval of the minutes of the preceding Congress;
 - 2.8. activity report (containing the activities since the last Congress);
 - 2.9. presentation of the consolidated and revised balance sheet and the profit and loss statement, as well as the independent and external auditor's report;

- 2.10. Санхүүгийн аудитын тайланг батлах;
 - 2.11. Төсөв батлах;
 - 2.12. Холбооны дүрэм болон Их хурал хуралдуулах дэгийн зааварт нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал хураах;
 - 2.13. Энэ зүйлийн 3-т заасны дагуу Холбооны гишүүд болон Зөвлөлөөс гаргасан саналыг хэлэлцэх;
 - 2.14. Зөвлөлийн саналын дагуу хөндлөнгийн аудиторыг томилох (шаардлагатай бол);
 - 2.15. Холбооны байгууллагыг татан буулгах эсвэл хувь хүнийг чөлөөлөх (шаардлагатай бол);
 - 2.16. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Зөвлөлийн гишүүдийг сонгох (шаардлагатай бол);
 - 2.17. Хараат бус байгууллагуудын гишүүдийг сонгох (Аудит ба дүрэм журмын хяналтын нэгж, сонгуулийн хороод, эрх зүйн байгууллагууд гэх мэт (шаардлагатай бол));
 - 2.18. Гишүүнчлэлийг батлах (шаардлагатай бол);
 - 2.19. Бусад.
3. Хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй зүйлийг Их хурал хэлэлцэхгүй. Гэхдээ санал өгөх эрхтэй төлөөлөгчдийн гуравны хоёрын (2/3) саналаар ээлжит Их хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулан хэлэлцэж болно.

34-Р ЗҮЙЛ. **ЭЭЛЖИТ БУС ИХ ХУРАЛ**

1. Зөвлөл шаардлагатай тохиолдолд ээлжит бус Их хурлыг хуралдуулж болно.
2. Холбооны Их хурлын гишүүдийн гуравны хоёроос дээш гишүүдийн албан ёсоор ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Зөвлөл ээлжит бус Их хурлыг хуралдуулна. Их хурлын гишүүд тавьсан хүсэлтэндээ хэлэлцэх асуудлыг тодорхой заана. Хүсэлтийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор ээлжит бус Их хурлыг хуралдуулна. Хэрэв ээлжит бус Их хурлыг хуралдуулахгүй тохиолдолд хүсэлт гаргасан төлөөлөгчид өөрсдөө ээлжит бус Их хурлыг хуралдуулж болно. Энэ тохиолдолд Холбооны

- 2.10. approval of the audited financial statements;
 - 2.11. approval of the budget;
 - 2.12. votes on proposals for amendments to the Statutes and the Standing Orders of the Congress;
 - 2.13. discussion of proposals submitted by the Members and the Council in accordance with the procedure stipulated under art. 33 par. 3 of these Statutes;
 - 2.14. appointment of independent and external auditors (if applicable) upon the proposal of the Council;
 - 2.15. dismissal of a person or a body (if applicable);
 - 2.16. election of the President, vice-presidents and members of the Council (if applicable);
 - 2.17. election of the members of the independent bodies, i.e. Audit and Compliance Unit, Electoral Committees and judicial bodies (if applicable);
 - 2.18. admission for membership (if applicable);
 - 2.19. any other items.
3. The Congress shall not take a decision on any point not included in the agenda. However, the agenda of an Ordinary Congress may be altered and discussed, provided two-third of the delegates representing the Members present at the Congress and eligible to vote agree to such a motion.

ARTICLE 34 **EXTRAORDINARY CONGRESS**

1. The Council may convene an Extraordinary Congress at any time if it is deemed necessary.
2. The Council shall convene an Extraordinary Congress if more than two third of the delegates representing the Members of MFF make such a request in writing. The request shall specify the items for the agenda. An Extraordinary Congress shall be held within one month of receipt of the request. If an Extraordinary Congress is not convened, the delegates representing the Members who requested it may convene the

Их хурлын гишүүд Зөвлөлд ээлжит бус Их хурал болох газар, хурлын товыг энэ зүйлийн 3 дахь заалтад заасан хэлэлцэх асуудлын хамт мэдэгдэнэ.

3. Ээлжит бус Их хурал хуралдуулах хугацаа, газар болон зорилгын тухай нийт гишүүдэд хурал эхлэхээс 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
4. Ээлжит бус Их хурлыг Зөвлөлийн санаачилгаар хийх тохиолдолд хэлэлцэх асуудлыг Зөвлөл боловсруулна. Харин ээлжит бус Их хурлыг гишүүдийн хүсэлтээр хуралдуулах тохиолдолд, хэлэлцэх асуудалд тэдний саналыг тусгах ёстой.
5. Ээлжит бус Их хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахгүй.

35-Р ЗҮЙЛ. **ХОЛБООНЫ ДҮРЭМ БОЛОН ИХ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ДЭГИЙН ЗААВАРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

1. Их хурал нь Дүрэм, Их хурал хуралдуулах дэгийн зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хариуцна.
2. Их хурлын гишүүд эсвэл Зөвлөл Холбооны дүрэм болон Их хурал хуралдуулах дэгийн зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа бичгээр гаргаж товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлнэ. Гишүүнээс гаргаж буй санал нь гурваас доошгүй гишүүд дэмжиж түүнийгээ бичгээр илэрхийлсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.
3. Холбооны дүрэм болон Их хурал хуралдуулах дэгийн зааварт орох нэмэлт, өөрчлөлтийг санал өгөх эрхтэй төлөөлөгчдийн ирц олонхид (50 хувиас дээш) хүрсэн тохиолдолд хэлэлцэнэ.
4. Холбооны дүрэм болон Их хурал хуралдуулах дэгийн зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал нь хуралд оролцсон, санал өгөх эрхтэй нийт гишүүдийн дийлэнх олонхийн (2/3)-ын саналаар дэмжигдэж батлагдана.
5. Холбоо нь Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг ОУХБХ болон АХБХ-нд мэдэгдэнэ.

Congress themselves. In doing so, they shall inform all the Members of MFF and the Council of the date and location of the Extraordinary Congress, along with the items to be included in the agenda in accordance with par. 3 below.

3. The Members shall be notified of the place, date and the purpose of the Extraordinary Congress at least 14 days before the Extraordinary Congress.
4. When an Extraordinary Congress is convened on the initiative of the Council, it must draw up the agenda. In case of when an Extraordinary Congress is convened upon the request of Members, the agenda must contain the points raised by those Members.
5. The agenda of an Extraordinary Congress may not be altered.

ARTICLE 35 AMENDMENTS TO THE STATUTES AND STANDING ORDERS OF THE CONGRESS

1. The Congress is responsible for amending the Statutes and the Standing Orders of the Congress.
2. Any proposals for an amendment to the Statutes and the Standing Orders of the Congress must be submitted in writing with a brief explanation to the general secretariat by a Member or by the Council. A proposal submitted by a Member is valid, provided it has been supported in writing by at least three delegates representing the Members.
3. For a vote on an amendment to the Statutes or the Standing Orders of the Congress to be valid, a majority (more than 50%) of the delegates representing the Members eligible to vote must be present.
4. A proposal for an amendment to the Statutes or the Standing Orders of the Congress shall be adopted only if more than two-third of the delegates representing the Members present and eligible to vote agree to it.
5. MFF shall inform FIFA and the AFC of any amendments to its Statutes.

36-Р ЗҮЙЛ. ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

1. Их хурлын тэмдэглэл хөтлөлтийг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцан хөтөлнө. Томилогдсон гишүүд Их хурлын тэмдэглэлийг хянаж, дараагийн Их хурлаар баталгаажуулна.

37-Р ЗҮЙЛ. ШИЙДВЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ ХУГАЦАА

1. Энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй эсвэл Их хурал шийдвэр хүчин төгөлдөр болох өөр хугацаа тогтоогоогүй тохиолдолд Их хурлаас гаргасан шийдвэр нь уг Их хурал дуусмагц хүчин төгөлдөр болж гишүүдэд үйлчилнэ.

Б.ЗӨВЛӨЛ

38-Р ЗҮЙЛ. БҮРЭЛДЭХҮҮН

1. Зөвлөл 15 гишүүнтэй байна. Үүнд:
 - 1.1. Ерөнхийлөгч-1;
 - 1.2. Дэд ерөнхийлөгч-1;
 - 1.3. Эмэгтэй Дэд ерөнхийлөгч-1;
 - 1.4. Гишүүн-9;
 - 1.5. Эмэгтэй гишүүн-1;
 - 1.6. Орон нутгийн төлөөлөл-1;
 - 1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл-1.
2. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид болон Зөвлөлийн бусад гишүүд тус дүрмийн 31-р зүйлд заасны дагуу сонгогдоно. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, гишүүд, эмэгтэй гишүүнд нэр дэвшигчдийг 5-аас багагүй гишүүн байгууллага нэр дэвшүүлнэ. Орон нутгийн төлөөлөлд нэр дэвшигчийг 3-аас цөөнгүй гишүүн байгууллагаас нэр дэвшүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлд нэр дэвшигч нь өөрийн дүрэм, журамд заасны дагуу нэр дэвшинэ.

ARTICLE 36 MINUTES

1. The General Secretary shall be responsible for recording the minutes at the Congress. The minutes shall be checked by those Members designated, and finally approved at the next Congress.

ARTICLE 37 EFFECTIVE DATES OF DECISIONS

1. Decisions passed by the Congress shall come into effect for the Members immediately after the close of the Congress, unless otherwise stipulated in the present Statutes or unless the Congress fixes another date for a decision to take effect.

B. COUNCIL

ARTICLE 38 COMPOSITION

1. The Council consists of 15 members:
 - 1.1. 1 President;
 - 1.2. 1 Vice-President;
 - 1.3. 1 female Vice-President;
 - 1.4. 9 ordinary members;
 - 1.5. 1 female member;
 - 1.6. 1 from the Regional Associations;
 - 1.7. 1 from the Disability Football Board.
2. The President, the Vice-Presidents and all other members of the Council shall be elected by the Congress according to the provisions of art. 31 of these Statutes. Every candidate in the election for President, Vice-Presidents, ordinary members or female candidate must be proposed by at least 5 Members. Every candidate in the election for the representative from the Regional Football Associations must be proposed at least by 3 Members representing the Regional Football Associations. The Disability Football Board elects its candidate according to its own rules and regulations.

3. Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Бүрэн эрхийн хугацаа тухайн сонгуулиар сонгогдсон даруйд хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгч (дараалсан эсвэл дараалаагүй нийт хоёроос илүү удаа сонгогдохгүй)-өөс бусад Зөвлөлийн гишүүд улиран сонгогдож болно. (Тухайн сонгогдсон дөрвөн жилийг бүрэн гүйцэтгээгүй ч ажилласанд тооцно)
4. Зөвлөлийн гишүүн нь 18-аас дээш настай, энэ дүрмийн хавсралт 3-т заасан шударга байдлын мэдэгдлийг бөглөж, хангасан, сонгууль эсвэл дахин сонгуулиас өмнө сонгуулийн хороонд материалаа шалгуулсан, хөлбөмбөгийн спортод дөрвөөс доошгүй жил идэвхтэй оролцсон, Монгол улсын хууль тогтоомжийг зөрчиж, гэмт хэрэгт холбогдоогүй, Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэн байна.
5. Зөвлөлийн гишүүн нь Их хурлын төлөөлөгч, эсвэл Холбооны Хараат бус байгууллагуудын гишүүнээр давхар томилогдон ажиллахыг хариглоно.
6. Зөвлөлийн гишүүн эсвэл Зөвлөлийн гишүүдийн 50 хүртэлх хувь нь орон гарсан тохиолдолд Зөвлөл дараагийн ээлжит болон ээлжит бус Их хурлаар ижил шалгуурын дагуу хуралдуулах асуудлыг хариуцах бөгөөд Их хурал дутуу гишүүдийн тоог орон гарсан гишүүний бүрэн эрхийнх нь хугацаагаар нөхөж сонгоно.
7. Зөвлөлийн гишүүдийн 50 хувиас дээш хувь нь орон гарсан тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга нь ээлжит бус Их хурал зарлан хуралдуулж, үлдсэн бүрэн эрхийн хугацааны дахин сонгууль явуулна.
8. Зөвлөлийн гишүүн нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан эсвэл хуралдаанд нэг жилд гурван удаа оролцоогүй бол гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно. (үүнд ээлжит болон ээлжит бус хуралдаан аль аль нь хамаарна)

3. The mandate of the members of the Council is for four years. Their mandates shall begin after the end of the Congress which has elected them. They may be re-elected, except for the President of MFF who may not serve for more than two terms of office (whether consecutive or not). Any partial term shall count as full term.
4. The members of the Council shall not be younger than 18 and shall undergo an integrity check (see Annex 3), to be conducted by the Electoral Committee prior to their election or re-election. They shall have already been active in football (in any capacity) for at least four years, must not have been previously found guilty of a criminal offence according to the laws of Mongolia that is incompatible with their position and have residency within the territory of Mongolia.
5. A member of the Council may not at the same time be a member of independent bodies of MFF, or a delegate to the MFF Congress.
6. If a position or up to 50% of the positions of the Council become vacant, the Council shall fill the position(s) in question with member(s) who have the same category or status as the member(s) who have produced the vacancy, until the next Congress, when a replacement will be elected for the remaining term of mandate.
7. If more than 50% of the positions of the Council become vacant, the General Secretary shall convene an Extraordinary Congress which shall elect the replacements for the remaining term of mandate.
8. A position will be considered vacant in case of death, of permanent disability or if a member of the Council does not participate in three meetings per year. It includes extraordinary and ordinary meetings.

39-Р ЗҮЙЛ. ХУРАЛДААН

1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
2. Зөвлөлийн хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит бус хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж, оролцож болно.
3. Зөвлөлийн ээлжит хуралдаан нь улиралд нэг удаа хуралдана. Ерөнхийлөгч хуралдааныг зарлан хуралдуулж даргална.
4. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Ерөнхийлөгч долоо хоногийн дотор зарлан хуралдуулна. Хэрэв Ерөнхийлөгч энд дурдсан хугацаанд хуралдааныг зарлан хуралдуулахгүй бол Зөвлөлийн гишүүдийн 50 хувийн саналаар зарлан хуралдуулна.
5. Ерөнхийлөгч хуралдааны хэлэлцэх асуудлыг тодорхойлно. Зөвлөлийн гишүүн бүр хэлэлцэх асуудлын талаар санал өгөх эрхтэй. Хэлэлцэх асуудлыг Ээлжит хуралдаан болохоос долоо хоногийн өмнө, Ээлжит бус хуралдаан болохоос гурав хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.
6. Ерөнхий нарийн бичгийн дарга Зөвлөлийн хуралдаанд саналын эрхгүйгээр зөвлөх үүрэгтэй оролцоно. Ерөнхий нарийн бичгийн дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд өөрийн төлөөллийг Зөвлөлөөр батлуулсан даруйд оролцуулж болно.
7. Зөвлөлийн хуралдаан хаалттай явагдана. Зөвлөлийн хуралдаанд гуравдагч этгээдийг урьж оролцуулж болно. Уг гуравдагч этгээд нь санал өгөх эрхгүй байх бөгөөд зөвхөн Зөвлөлийн зөвшөөрлөөр санал бодлоо илэрхийлж оролцоно.
8. Хоёр хуралдааны хооронд шуурхай хэлэлцэх асуудал гарсан тохиолдолд Ерөнхийлөгч Зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааг үл хамаарч эсвэл өөрчилж болно. Шийдвэрүүдийг харилцаа, холбооны бүхий л хэлбэрээр батална. (и-мэйл, мессеж гэх мэт)

ARTICLE 39 MEETINGS

1. The method of main operation of Council shall be through meetings.
2. The meetings can be ordinary or extraordinary. The extraordinary meetings may be held online and members may attend online.
3. The Ordinary council shall meet one time per quarter. The President shall convene the Council meetings.
4. The President shall convene extraordinary meeting within 7 days. If the President does not convene the requested meeting within the aforementioned deadline, the 50% of more of the members of the Council shall convene it themselves.
5. The President shall compile the agenda. Each member of the Council is entitled to propose items for inclusion in the agenda. The agenda must be sent out to the members of the Council within 7 days for ordinary meeting, and within 3 days for extraordinary meeting.
6. The General Secretary shall take part in the meetings of the Council in a consultative role without voting rights. If the General Secretary is unable to attend a meeting, he/she may nominate a representative to attend the meeting on his/her behalf, subject to the approval of the Council.
7. The meetings of the Council shall not be held in public. The Council may invite third party to attend. Those third parties shall not have voting rights, and may only express an opinion with the permission of the Council.
8. The President may also convene the Council on an urgent basis to deal with any matter requiring immediate settlement between two meetings of the Council. In such cases, the deadlines mentioned in par. 4 above may be either reduced or disregarded if the urgency so requires, and decisions may be passed through other modern means of written communication (e.g. emails, messaging apps).

40-Р ЗҮЙЛ. ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

Зөвлөл нь:

1. Холбооны эрхэм зорилго, стратегийн чиглэл, бодлого, үнэт зүйлсийг тодорхойлно;
2. Холбооны Их хурлын бүрэн эрхэд хамаараагүй бусад асуудлыг эсвэл Дүрэмд заасан бусад байгууллагуудын бүрэн эрхэд заагаагүй асуудлыг шийдвэрлэнэ;
3. Холбооны Ээлжит болон Ээлжит бус Их хурлын бэлтгэлийг хангаж хуралдуулна;
4. Байнгын хороодын дарга, дэд дарга болон гишүүдийг Холбооны гишүүд эсвэл Ерөнхийлөгчийн санал болгосноор томилох;
5. Шаардлагатай үед Түр хороо байгуулах шийдвэр гаргаж болно;
6. Байнгын болон Түр хороодын ажиллах журмыг батална;
7. Ерөнхийлөгчийн санал болгосноор Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох эсвэл чөлөөлөх;
8. Их хуралд хараат бус хөндлөнгийн аудиторыг санал болгох;
9. Холбооны тэмцээнүүдийн зохион байгуулалт ба тэдгээрт оролцох нөхцлийг зааж өгсөн журмыг гаргана. Энэ нь Их хурлын бүтэц, зохион байгуулалтад нөлөөлөхөөргүй байна;
10. Шигшээ багийн дасгалжуулагч болон техникийн бусад бүрэлдэхүүнийг томилох;
11. МХБХ-ны дотоод бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон журам батална;
12. Холбооны Дүрмийн хэрэгжилтийг хангуулах, түүнийг хэрэгжүүлэхэд авах шаардлагатай арга хэмжээг батална;
13. Ээлжит Их хурал хүртэл түр хугацаагаар Холбооны байгууллагын гишүүнийг чөлөөлнө;

ARTICLE 40 POWERS OF THE COUNCIL

The Council:

1. shall defines MFF's mission, strategic direction, policies and values;
2. shall pass decisions on all cases that do not come within the sphere of responsibility of the Congress or are not reserved for other bodies by law or under these Statutes;
3. shall prepare and convene the Ordinary and Extraordinary Congress of MFF;
4. shall appoint the chairpersons, deputy chairpersons and members of the standing committees on the proposal of the Members of MFF or the President of MFF;
5. may decide to set up ad-hoc committees if necessary at any time;
6. shall compile the regulations for the organisation of standing committees and ad-hoc committees;
7. shall appoint or dismiss the General Secretary on the proposal of the President;
8. shall propose the independent and external auditors to the Congress;
9. shall draw up regulations governing the conditions of participation in and the staging of competitions organised by MFF. This shall not affect the composition of the Congress;
10. shall appoint the coaches for the representative national teams and other technical staff;
11. shall approve regulations stipulating how MFF shall be organised internally;
12. shall ensure that the Statutes are applied and adopt the executive arrangements required for their application;
13. may dismiss a member of a body of MFF provisionally until the next Congress;

14. Зөвлөлийнхөө эрх хэмжээнд Холбооны бусад байгууллага ба гуравдагч этгээдэд үүрэг даалгавар өгч болно;
15. Их хурлын хэлэлцүүлэгт оролцох эсвэл санал өгөх эрхгүй ажиглагчдыг томилж болно;
16. Их хурал болох хүртэл Хараат бус байгууллагуудын дутуу гишүүдийг томилно;
17. Клуб лицензжүүлэх байгууллагуудын гишүүдийг сонгох ба чөлөөлнө.

41-Р ЗҮЙЛ. **ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРҮҮД**

1. Зөвлөлийн хуралдааны ирц олонх (50 хувиас дээш)-д хүрсэн тохиолдолд хүчинтэйд тооцогдоно.
2. Зөвлөлийн шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар (50 хувиас дээш) батална. Санал тэнцсэн үед Ерөнхийлөгчийн саналаар шийдвэрлэнэ. Санал өгөх эрхийг бусдад шилжүүлэх эсвэл албан бичгээр өгөхийг үл зөвшөөрнө. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас харилцаа холбооны аргуудаар эсвэл видео болон телеконференц хэлбэрээр зөвлөлийн хуралдаан зохион байгуулагдсан тохиолдолд цахим саналыг хүчин төгөлдөрт тооцно.
3. Ашиг сонирхлын зөрчил гарах магадлалтай тохиолдолд Зөвлөлийн гишүүн нь тухайн асуудал хэлэлцэх мөн шийдвэр гаргахаас татгалзана.
4. Хуралдаанаас гарсан шийдвэрүүдийг хурлын тэмдэглэлд тусгана.
5. Зөвлөл нь өөрөөр тогтоогоогүй бол тухайн хуралдаанаас гарсан шийдвэрүүд тэр даруйд хүчин төгөлдөр болно.

14. may delegate tasks arising out of its area of authority to other bodies of MFF or third parties;
15. may appoint observers who take part in the Congress without the right to debate or to vote;
16. shall appoint replacements for vacancies in the independent bodies until the next Congress;
17. electing or dismissing the members of the Club Licensing bodies.

ARTICLE 41 **DECISIONS**

1. The Council shall not engage in valid debate unless a majority (more than 50 percent) of its members are present.
2. The Council shall reach decisions by a majority (more than 50%) of the valid votes cast. In the event of a tied vote, the President shall have the casting vote. Voting by proxy or by letter is not permitted. When a Council is held by teleconference or by videoconference, voting online is permitted.
3. Any member of the Council must withdraw from the debate and from taking a decision if there is any risk or possibility of a conflict of interests.
4. The decisions taken from meeting shall be recorded in the minutes.
5. The decisions taken by the Council shall come into effect immediately, unless the Council decides otherwise.

В. ЕРӨНХИЙЛӨГЧ

42-Р ЗҮЙЛ. ЕРӨНХИЙЛӨГЧ

1. Ерөнхийлөгч нь Холбоог албан ёсоор төлөөлнө.
2. Ерөнхийлөгч ажлын албатай байна. Ерөнхийлөгчийн ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх асуудлыг Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.
3. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд Сонгуульт Их хурал дуусмагц бүрэн эрх нь хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгчийг нэг удаа улируулан сонгож болно.
4. Ерөнхийлөгчийн нэн тэргүүнд хариуцах асуудлууд. Үүнд:
 - 4.1. Ерөнхий нарийн бичгийн даргын газраар дамжуулан Их хурал болон Зөвлөлөөс гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх;
 - 4.2. Энэхүү Дүрмийн зорилтуудыг биелүүлэхийн тулд Холбооны байгууллагууд нь үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулж буй эсэхэд хяналт тавих;
 - 4.3. Ерөнхий нарийн бичгийн даргын газрын ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;
 - 4.4. Холбоо ба Холбооны гишүүн байгууллагууд, ОУХБХ, АХБХ, ЗАХБХ улс төрийн болон бусад байгууллага хоорондын харилцааг хариуцна.
5. Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох ба чөлөөлөх асуудлыг гагцхүү Ерөнхийлөгч санал болгоно.
6. Ерөнхийлөгч Их хурал, Зөвлөлийн хуралдааныг тус тус даргална.
7. Ерөнхийлөгч Зөвлөлийн хуралдаанд энгийн саналаар оролцох бөгөөд гагцхүү санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгчийн санал шийдвэрлэх үүрэгтэй байна.
8. Ерөнхийлөгч энэ дүрмийн 38.8 дахь заалтанд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд хамгийн удаан ажилласан Дэд ерөнхийлөгч, мөн тэдгээрийн эзэнгүй тохиолдолд дараагийн Их хурал болтол хамгийн олон жил ажилласан Зөвлөлийн гишүүн Ерөнхийлөгчийн үүргийг орлоно. Ерөнхийлөгч чөлөөлөгдсөн тохиолдолд үлдсэн хугацаанд сонгогдон ажиллах Ерөнхийлөгчийг Их хурлаар сонгоно.

C. PRESIDENT

ARTICLE 42 PRESIDENT

1. The President represents MFF generally.
2. The President shall head the presidential office and shall be responsible for the appointment or dismissal of the staff members of his presidential office.
3. The mandate of the President is for four years, which shall begin after the end of the electoral Congress. The President may be re-elected once.
4. He is primarily responsible for:
 - 4.1. implementing the decisions passed by the Congress and the Council through the general secretariat;
 - 4.2. ensuring the effective functioning of the bodies of MFF in order that they achieve the objectives described in these Statutes;
 - 4.3. supervising the work of the general secretariat;
 - 4.4. the relations between MFF and its Members, FIFA, AFC, EAFF and political bodies and other organisations.
5. Only the President may propose the appointment or dismissal of the General Secretary.
6. The President shall preside over the Congress and the Council meetings.
7. The President shall have an ordinary vote on the Council and, whenever votes are equal, shall have a casting vote.
8. If the position of the President becomes vacant in the sense of art. 38 par. 8 of these Statutes, the most senior Vice-President, or, if he/she is also unavailable, the longest serving member of the Council, shall deputise until the next Congress. This Congress shall elect a new President for the remaining term of the mandate.

9. Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрхийг Холбооны дотоод зохион байгуулалтын журамд тусгана.

43-Р ЗҮЙЛ. ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨЛ БА ГАРЫН ҮСЭГ

1. Ерөнхийлөгч нь Холбоог хууль ёсоор төлөөлж, байгууллагын нэрийн өмнөөс гарын үсэг зурна. Холбооны үйл ажиллагаатай холбоотой чухал бичиг баримтад хамтарсан гарын үсэг (ялангуяа Ерөнхийлөгчийн эзгүйд) зурахыг Холбооны дотоод зохион байгуулалтын журмаар зохицуулна.

Г. БАЙНГЫН ХОРООД

44-Р ЗҮЙЛ. БАЙНГЫН ХОРООД

1. Холбоо нь дараах Байнгын хороодтой байна. Үүнд:
 - 1.1. Санхүүгийн хороо;
 - 1.2. Тэмцээн зохион байгуулах хороо;
 - 1.3. Техник, хөгжлийн хороо;
 - 1.4. Шүүгчийн хороо;
 - 1.5. Эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн хороо;
 - 1.6. Хүүхэд залуучуудын хөлбөмбөгийн хороо;
 - 1.7. Футзал ба элсний хөлбөмбөгийн хороо
 - 1.8. Тоглогчдын эрх зүйн байдлын хороо;
2. Шүүгчийн хорооноос бусад байнгын хороодыг Зөвлөлийн гишүүд даргална. Зөвлөл нь Ерөнхийлөгч эсвэл Холбооны гишүүдийн саналыг үндэслэж Байнгын хороо тус бүрийн гишүүдийг томилно.
3. Байнгын хороодын дарга, дэд дарга, гишүүд дөрвөн жилийн хугацаагаар томилогдоно. Байнгын нэг хороонд хоёр хүртэлх Зөвлөлийн гишүүн байна.

9. Any additional powers of the President shall be contained in the Internal Organisation Regulations of MFF.

ARTICLE 43 REPRESENTATION AND SIGNATURE

1. The President represents MFF legally and is entitled to sign for MFF. The Internal Organisation Regulations shall regulate the joint signature of directors of MFF concerning all important business of MFF, in particular, in case of the President's absence.

D. STANDING COMMITTEES

ARTICLE 44 STANDING COMMITTEES

1. The standing committees of MFF are:
 - 1.1. Finance Committee;
 - 1.2. Organising Committee for MFF competitions;
 - 1.3. Technical and Development Committee;
 - 1.4. Referees Committee;
 - 1.5. Committee for Women's Football
 - 1.6. Youth Football Committee;
 - 1.7. Futsal and Beach Soccer Committee;
 - 1.8. Players' Status Committee.
2. The chairperson of the standing committees except for the Referees Committee may be members of the Council. The members of each standing committee will be appointed by the Council on the proposal of the Members of MFF or the President of MFF.
3. The chairperson, deputy chairpersons and the other members of the standing committees shall be designated for a term of office of four years. Each committee shall be composed of no more than 2 members of the Council.

4. Хороодын дарга тус бүр өөрийн хороог төлөөлөх бөгөөд Зөвлөлөөс боловсруулсан тухайн хороонд холбогдох журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.
5. Байнгын хороодын дарга нь Ерөнхий нарийн бичгийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр хорооны хурлын товыг тогтоох бөгөөд ажлаа Зөвлөлд тайлагнана.
6. Байнгын хороодын гишүүд нь тухайн ажил үүргийг гүйцэтгэх ур чадвартай, туршлагатай, мэдлэг чадвартай, мэргэшсэн гишүүдээс бүрдсэн байна. Зөвлөл Байнгын хороодын зохих эмэгтэй төлөөллийг хангаж ажиллуулна.
7. Байнгын хороод нь өөрийн журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Зөвлөлөөр хэлэлцүүлж болно.

45-Р ЗҮЙЛ. **САНХҮҮГИЙН ХОРОО**

1. Тус хороо нь санхүүгийн менежментэд хяналт тавьж санхүү болон хөрөнгийн менежменттэй холбогдох асуудлаар Зөвлөлд зөвлөж ажиллана. Тус хороо нь Холбооны төсөв болон Ерөнхий нарийн бичгийн даргын боловсруулсан санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж Зөвлөлд танилцуулж батлуулна. Тус Хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.

46-Р ЗҮЙЛ. **ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО**

1. Тус хороо нь Холбооны тэмцээнүүдийг энэхүү дүрмийн заалтууд болон Холбооны тэмцээнд хамаарах журмуудад нийцүүлэн зохион байгуулах үүрэгтэй. Тус хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.

4. Each chairperson shall represent its standing committee and it shall run its operation in accordance with the approved regulations by Council.
5. Each chairperson shall fix the dates of meetings in collaboration with the General Secretary, ensure that all tasks are carried out and report back to the Council.
6. The standing committees shall be composed in such a way that their members, together, have the knowledge, abilities and specialist experience that is necessary for the due completion of their tasks and duties. The Council shall ensure appropriate female representation on standing committees.
7. Each committee may propose amendments to its regulations to the Council.

ARTICLE 45 FINANCE COMMITTEE

1. The Finance Committee shall monitor the financial management and advise the Council on financial matters and asset management. It shall analyse the budget of MFF and the financial statements prepared by the General Secretary and submit them to the Council for approval. It shall consist of a chairperson, a deputy chairperson and two members.

ARTICLE 46 ORGANISING COMMITTEE FOR MFF COMPETITIONS

1. The Organising Committee for MFF competitions shall organise the competitions of MFF in compliance with the provisions of these Statutes and the regulations applicable to MFF's competitions. It shall consist of a chairperson, a deputy chairperson and two members.

47-Р ЗҮЙЛ. **ТЕХНИК, ХӨГЖЛИЙН ХОРОО**

1. Тус хороо нь хөлбөмбөгийн бэлтгэл, сургалт ба техникийн хөгжлийн үндсэн асуудлуудад дүн шинжилгээ хийнэ. Тус хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.

48-Р ЗҮЙЛ. **ШҮҮГЧДИЙН ХОРОО**

1. Тус хороо нь Тоглолтын дүрмийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Түүнчлэн тус хороо нь Холбооноос зохион байгуулагдаж байгаа аливаа тоглолтын шүүгчийг томилох, Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газартай хамтран шүүгчийн асуудлыг зохион байгуулж, шүүгчийн боловсрол, сургалтад хяналт тавих үүрэгтэй. Тус Хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ. Гишүүдийн 50-иас багагүй хувь нь шүүгчээр ажиллаж байсан туршлагатай байна.

49-Р ЗҮЙЛ. **ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨЛБӨМБӨГИЙН ХОРОО**

1. Тус хороо нь эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж эмэгтэйчүүдийн хөлбөмбөгтэй холбогдох бүхий л асуудлыг хариуцна. Тус хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.

50-Р ЗҮЙЛ. **ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОРОО**

1. Тус хороо нь хүүхдийн хөлбөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж хүүхдийн хөлбөмбөг болон грассруүтстэй холбогдох бүхий л асуудлыг хариуцна. Тус хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.

51-Р ЗҮЙЛ. **ФУТЗАЛ БА ЭЛСНИЙ ХӨЛБӨМБӨГИЙН ХОРОО**

1. Тус хороо нь футзалын ба элсний тэмцээнийг зохион байгуулах ба футзалын ба элсний хөлбөмбөгтэй холбогдох бүхий л асуудлыг хариуцан ажиллана. Тус хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.

ARTICLE 47 TECHNICAL AND DEVELOPMENT COMMITTEE

1. The Technical and Development Committee shall primarily analyse the basic aspects of football training and technical development. It shall consist of a chairperson, a deputy chairperson and two members.

ARTICLE 48 REFEREES COMMITTEE

1. The Referees Committee shall implement the Laws of the Game. It shall appoint the referees for matches in competitions organised by MFF, organise refereeing matters within MFF in collaboration with the administration of MFF and monitor the education and training of referees. It shall consist of a chairperson, a deputy chairperson and two members, at least 50 % of whom shall be ex-referees.

ARTICLE 49 COMMITTEE FOR WOMEN'S FOOTBALL

1. The Committee for Women's Football shall organise women's football competitions and deal with all matters relating to women's football. It shall consist of a chairperson, a deputy chairperson and two members.

ARTICLE 50 YOUTH FOOTBALL COMMITTEE

1. The Youth Football Committee shall organise youth football competitions and deal with all matters relating to youth football and grassroots football. It shall consist of a chairperson, a deputy chairperson and two members.

ARTICLE 51 FUTSAL AND BEACH SOCCER COMMITTEE

1. The Futsal and Beach Soccer Committee shall organise futsal and beach soccer competitions and deal with all matters relating to futsal and beach soccer. It shall consist of a chairperson, a deputy chairperson and two members.

52-Р ЗҮЙЛ. **ТОГЛОГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ХОРОО**

1. ОУХБХ-ноос гаргасан Тоглогчдын эрх зүйн байдал ба шилжилт хөдөлгөөний журамд нийцүүлэн тоглогчдын шилжилт хөдөлгөөний талаар өөрийн журам боловсруулах, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж, Холбооны тэмцээнд оролцож байгаа тоглогчдын эрх зүйн байдлыг тодорхойлно. Тус Хорооны хэрэгжүүлэх эрх хэмжээг тусгасан журмыг Зөвлөлөөс баталж болно. Хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.
2. Холбоо, түүний гишүүд, тоглогчид, албаны хүмүүс, тоглолт болон тоглогчийн агенттай хамаарах тоглогчийн эрх зүйн байдалтай холбогдох аливаа маргааныг энэхүү Дүрэмд заасны дагуу Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитраар шийдвэрлүүлнэ.

53-Р ЗҮЙЛ. **ТҮР ХОРОО**

1. Шаардлагатай тохиолдолд Зөвлөл тусгай үүрэг гүйцэтгэх Түр хороодыг тодорхой хугацаагаар байгуулж болно. Зөвлөл Түр хороодын дарга, дэд дарга болон гишүүдийг томилно. Эдгээр Хороодын чиг үүргийг Зөвлөлөөс гаргасан тусгай журам, заавраар тодорхойлно. Түр хороо ажлаа Зөвлөлд шууд тайлагнана.

Д. КЛУБ ЛИЦЕНЗЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД

54-Р ЗҮЙЛ. **КЛУБ ЛИЦЕНЗЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД**

1. Тус байгууллага клуб лицензжүүлэх асуудлыг хариуцаж, ажлаа АХБХ болон МХБХ тэдгээрийн гаргасан Клуб Лицензжүүлэх Журамд нийцүүлнэ.
2. Клуб лицензжүүлэх байгууллагууд нь Хянан хэлэлцэх байгууллага болон Давж заалдах байгууллагуудаас бүрдэнэ. Давж заалдах байгууллагаас гаргасан шийдвэрийг энэ дүрмийн дагуу Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитрарт давж заалдаж болно.

ARTICLE 52 PLAYERS' STATUS COMMITTEE

1. The Players' Status Committee shall set up and monitor compliance with transfer regulations in accordance with the FIFA Regulations on the Status and Transfer of Players and determine the status of Players for various competitions of MFF. The Council may draw up special regulations governing the Players' Status Committee's powers of jurisdiction. The Players' Status Committee shall consist of a chairperson, a deputy chairperson and two members.
2. Players' status disputes involving MFF, its Members, Players, Officials and match agents and intermediaries shall be settled in the last instance by an Arbitration Tribunal in accordance with these Statutes.

ARTICLE 53 AD-HOC COMMITTEES

1. The Council may, if necessary, create ad-hoc committees for special duties and a limited period of time. The Council shall appoint a chairperson, a deputy chairperson and the members. The duties and function are defined in special regulations drawn up by the Council. An ad-hoc committee shall report directly to the Council.

E. CLUB LICENSING BODIES

ARTICLE 54 CLUB LICENSING BODIES

1. The Club Licensing Bodies are in charge of the club licensing system within MFF in accordance with the Club Licensing Regulations of MFF and the Club Licensing Regulations of AFC.
2. The Club Licensing Bodies shall consist of a first instance body and an appeal body. Decisions passed by the club licensing appeal body may only be appealed before an independent and duly constituted arbitration tribunal in accordance with the provisions in these Statutes.

3. Холбооны уралдаан, тэмцээнд клубүүд хэрхэн яаж оролцох тогтолцоог тодорхойлсон клуб лицензжүүлэх журмыг Зөвлөлөөс батална. Энэ нь ОУХБХ-ны дүрэмд нийцүүлэн АХБХ-ноос гаргасан клуб лицензжүүлэх зайлшгүй шаардлагыг хангасан байна.
4. Хянан хэлэлцэх байгууллага болон Давж заалдах байгууллага нь тус бүр дарга, дэд дарга, гишүүн гэсэн гурван хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээр нь хуулийн, санхүүгийн, хөлбөмбөгийн спортын мэргэшсэн этгээд байна.

Е. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР

55-Р ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР

1. Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь албан ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын удирдлага дор гүйцэтгэнэ. Ерөнхий нарийн бичгийн даргын газрын албан хаагчид Холбооны дотоод зохион байгуулалтын журамд захирагдаж ажиллана.

56-Р ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

1. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Ерөнхий нарийн бичгийн даргын газрыг даргална.
2. Ерөнхий нарийн бичгийн даргыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр томилох бөгөөд тэрээр зохих мэргэжлийн шаардлагыг хангасан байна.
3. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Холбооны дүрэм болон хөдөлмөрийн гэрээнд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
4. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 4.1. Их хурал болон Зөвлөлийн гарсан шийдвэрийг Ерөнхийлөгчийн чиглэлийн дагуу хэрэгжүүлэх;
 - 4.2. Их хурал, Зөвлөл, Байнгын хороод Түр хорооны хуралд оролцох;
 - 4.3. Их хурал, Зөвлөл болон бусад байгууллагуудын хурлыг зохион байгуулах;

3. The Council of MFF shall issue regulations regarding a club licensing system governing the participation of Clubs in the competitions of MFF, in compliance with the minimum requirements of the club licensing system as set up by AFC in conforming with the FIFA regulations.
4. The first instance body and the appeal body shall each be composed of a chairperson, a vice chairperson and a member. The members of each body shall jointly have expertise in football, financial and legal matters..

F. GENERAL SECRETARIAT

ARTICLE 55 GENERAL SECRETARIAT

1. The general secretariat shall carry out all the administrative work of MFF under the direction of the General Secretary in accordance with internal regulation. The members of the general secretariat are bound by the Internal Organisational Regulations of MFF.

ARTICLE 56 GENERAL SECRETARY

1. The General Secretary is the chief Executive of the general secretariat.
2. He/she shall be appointed based on an agreement governed by labour law and shall have the necessary professional qualifications.
3. He/she shall obey the MFF statutes and have the rights stated on the labour contract.
4. He/she shall be responsible for:
 - 4.1 implementing decisions passed by the Congress and Council in compliance with the President's directives;
 - 4.2 attending the Congress and meetings of the Council and the standing and ad-hoc committees;
 - 4.3 organising the Congress and meetings of the Council and other bodies;

- 4.4. Их хурал, Зөвлөл, Байнгын хороод болон Түр хорооны хурлын тэмдэглэлийг хариуцах;
 - 4.5. Холбооны нягтлан бодох бүртгэлийг зөв хөтлөх;
 - 4.6. Холбооны захидал харилцааг хариуцах;
 - 4.7. Холбооны гишүүд, хороод, ОУХБХ, АХБХ, ЗАХБХ-той харилцах харилцааг хариуцах;
 - 4.8. Ерөнхий нарийн бичгийн даргын газрын бүтэц, зохион байгуулалтыг хариуцах;
 - 4.9. Ерөнхий нарийн бичгийн дарга газрын албан хаагчдыг томилох, чөлөөлөх;
 - 4.10. Удирдах албан тушаалд томилох хүнийг Ерөнхийлөгчид санал болгох;
 - 4.11. Өөрөөр заагаагүй бусад тохиолдолд хороодоос гарсан шийдвэрийг баталгаажуулж гарын үсэг зурах;
 - 4.12. Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн хороонд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
5. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Их хуралд төлөөлөгчөөр оролцохгүй бөгөөд Холбооны аль нэг байгууллагад гишүүн байж үл болно.

- 4.4 compiling the minutes for the meetings of the Congress, Council and standing and ad-hoc committees;
 - 4.5 managing and keeping the accounts of MFF properly;
 - 4.6 the correspondence of MFF;
 - 4.7 relations with the Members, committees, FIFA, AFC and EAFF;
 - 4.8 organising the general secretariat;
 - 4.9 the appointment and dismissal of staff working in the general secretariat;
 - 4.10 proposing managerial staff to the President;
 - 4.11 In circumstances if not stated otherwise he shall sign by confirming the committee decisions;
 - 4.12 Providing the electoral committees with logistic and operative support for the elections.
5. The General Secretary may not be a Congress delegate or a member of any body of MFF.

V. ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУД

57-Р ЗҮЙЛ. ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙДАЛ

1. Хараат бус байгууллагууд болон тэдгээрийн гишүүд нь үүргээ биелүүлж, үйл ажиллагаа явуулахдаа хараат бус байх боловч МХБХ-ны ашиг сонирхол, МХБХ-ны дүрэм болон бусад журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
2. Эрх зүйн байгууллагууд, Сонгуулийн хороодын дарга, дэд дарга, гишүүд, Аудит ба дүрэм, журмын хяналтын нэгжийн ажилтан нь энэ зүйлийн 3 дахь заалтанд заасан хараат бус байдлын шалгуурыг хангасан байна.
3. Дээр дурдсан байгууллагуудын гишүүд, хамаарал бүхий гэр бүлийн гишүүд дөрвөн жилийн сонгуульд ажлын хугацаанд МХБХ-ны Зөвлөл, гишүүдийн аль нэг, лиг эсвэл клуб харьяалагдсан компани (байгууллагын хэлбэрээр)-д үүрэг гүйцэтгэх, дээр дурдсан газруудтай бизнес харилцаа үүсгэхийг тус тус хориглоно. Хамаарал бүхий гэр бүлийн гишүүд гэдэгт тухайн хүнтэй холбоотой, тухайн хүний эхнэр, нөхөр эсвэл гэр бүлийн хамтрагч, эгч дүүс, эцэг эх, эмээ/өвөө, нагац, авга, хүүхдүүд (дагавар хүүхэд эсвэл өргөж авсан хүүхэд), ач/зээ хүүхэд, хадам ах дүү, хадам эцэг эх, цусан болон цусан бус хамааралтай, санхүүгийн туслалцаа үзүүлдэг гэр бүлийн харилцаатай хүмүүсийг тус тус хэлнэ.

58-Р ЗҮЙЛ. АУДИТ БА ДҮРЭМ, ЖУРМЫН ХЯНАЛТЫН НЭГЖ

1. Аудит ба дүрэм, журмын хяналтын ажилтан нь аудит ба дүрэм, журмын хяналтын нэгжийг хариуцан ажиллана. Тус ажилтан нь санхүү, хууль, дүрэм журмын талаар мэдлэгтэй, туршлагатай байх бөгөөд Холбооны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй.
2. Тус ажилтан нь Холбооны санхүү, хууль, дүрэм журмыг хянаж, Холбооны Зөвлөлд зөвлөх, туслах үүрэгтэй. Тус ажилтан дүрэм, журмын хяналтыг зохицуулах тогтолцоог бий болгож, хянаж ажиллана. Мөн тус ажилтан нь санхүү болон дүрэм,

V. INDEPENDENT BODIES

ARTICLE 57 INSTITUTIONAL INDEPENDENCE

1. The independent bodies as well as their individual members shall conduct their activities and perform their duties entirely independently but always in the interests of MFF and in accordance with its Statutes and regulations.
2. The chairperson, vice-chairperson and members of the electoral committees and the Audit and Compliance Officer as well as the chairperson and vice-chairperson of the judicial bodies shall comply with the independence criteria as defined in par. 3 below.
3. The persons mentioned in par. 2 above as well as any of their immediate family members may not exercise or have exercised during the four years preceding their initial terms any executive function at MFF, one of MFF's Members, a league or a club (including any of their affiliated companies/organisations), nor have or have had in the four years preceding their initial term any material business relationship with MFF, one of MFF's Members, a league or a club (including any of their affiliated companies/organisations). "Immediate family member" shall mean, with respect to a person, such person's spouse or domestic partner, siblings, parents, grandparents, uncles, aunts, children (including any stepchild or adopted child), grandchildren, son-, daughter-, father- or mother-in-law, and including anyone else, whether by blood or otherwise, with whom the individual has a relationship akin to a family relationship for which such person provides financial support.

ARTICLE 58 AUDIT AND COMPLIANCE UNIT

1. The Audit and Compliance Officer shall be in charge of the Audit and Compliance Unit. The Audit and Compliance Officer shall be knowledgeable and experienced in financial and/or regulatory and legal matters and may not be involved in any decision affecting the operations of MFF.
2. The Audit and Compliance Officer shall advise, assist and oversee

журмын хэрэгжилттэй холбоотой асуудлаар Ерөнхий нарийн бичгийн даргын газарт зөвлөж, санхүүгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, хараат бус хөндлөнгийн аудитын тайлан зэргийн үнэн зөв, бүрэн байдлыг нягтална. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд Холбооны санхүү, дүрэм журмын асуудлыг хянах зорилгоор зохих байгууллагуудаар шийдвэр гаргуулна.

3. Аудит ба дүрэм, журмын хяналтын нэгжийн үүрэг хариуцлага, дотоод уялдаа холбоо, бусад асуудлын дэлгэрэнгүйг Холбооны дотоод зохион байгуулалтын журамд дэлгэрэнгүй тусгана.
4. Аудит ба дүрэм, журмын хяналтын ажилтныг МХБХ-ны Их хурлаар дөрвөн жилийн хугацаатай сонгох бөгөөд бүрэн эрхийг гагцхүү Их хурал дуусгавар болгоно. Тус ажилтан Холбооны өөр бусад байгууллагад хамаарах, харъяалагдан ажиллахыг хориглоно.

59-Р ЗҮЙЛ. **СОНГУУЛИЙН ХОРООД**

1. Сонгуулийн хороод нь Сонгуулийн дүрмийн дагуу Сонгуультай холбоотой үйл явцыг зохион байгуулж, удирдан хянана. Сонгуулийн хороод нь Сонгуулийн хороо (анхан шатны байгууллага), Сонгуулийн хяналтын хороо (хоёр дахь шатны байгууллага)-ноос бүрдэнэ. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагааг Холбооны Сонгуулийн дүрмийн дагуу зохицуулна.

60-Р ЗҮЙЛ. **ЭРХ ЗҮЙН БАЙГУУЛЛАГУУД**

1. Холбооны Эрх зүйн байгууллагуудад дараах хороодыг ойлгоно. Үүнд:
 1. Сахилгын хороо;
 2. Ёс зүйн хороо;
 3. Маргаан таслах хороо.
2. Тус хороо бүр нь дарга, дэд дарга, гурван гишүүн гэсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байна.

the Council in monitoring MFF's financial and compliance matters, set up compliance mechanisms and monitor compliance with the relevant regulations of MFF. He shall also supervise the general secretariat in financial and compliance issues. The Audit and Compliance Officer shall ensure the completeness and reliability of the financial accounting and review the consolidated financial statements and the independent and external auditor's report. The Audit and Compliance Officer shall furthermore monitor MFF's financial and compliance matters and suggest to the appropriate bodies any action that it deems necessary as a result of such monitoring.

3. Details on the Audit and Compliance Unit's responsibilities, its internal cooperation and other procedural matters are stipulated in the Internal Organisation Regulations of MFF.
4. The Audit and Compliance Officer shall be elected by the Congress for a period of four years and may only be relieved of his duty by the Congress. He shall not belong to any other body of MFF.

ARTICLE 59 **ELECTORAL COMMITTEES**

1. The Electoral Committees are the bodies in charge of organising and supervising the election process in accordance with the Electoral Code of MFF. The electoral committees consist of the Electoral Committee (the first instance body) and the Election Appeal Committee (the second instance body). The composition and function of the electoral committees shall be governed by the Electoral Code of MFF.

ARTICLE 60 **JUDICIAL BODIES**

1. The judicial bodies of MFF are:
 1. the Disciplinary Committee;
 2. the Ethics Committee;
 3. the Appeal Committee.
2. The judicial bodies shall consist of a chairperson, a deputy chairperson and three ordinary members.

3. Тус байгууллагууд нь зорилгоо бүрэн биелүүлэхэд шаардагдах мэдлэг чадвар, мэргэшсэн туршлагатай гишүүдээр багаа бүрдүүлнэ. Тус байгууллагуудын дарга нь процессийн эрх зүйгээр мэргэшсэн чадвартай байна. Хороодын гишүүд 4 жилээр сонгогдоно. Мөн улиран сонгогдож болно. Хорооны гишүүдийг үүрэгт ажлаас нь хэзээ ч чөлөөлж болох боловч гагцхүү Их Хурлаар чөлөөлөх асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.
4. Хороодын дарга, дэд дарга, гишүүдийг Зөвлөлийн санал болгосноор Их хурлаас сонгоно.
5. Хороодын дарга, дэд дарга, гишүүд нь Зөвлөл, Байнгын хороо, Холбооны бүтцийн байгууллагын гишүүн байхыг хориглоно.
6. Хороодын дарга, дэд дарга эсвэл гишүүн нь бүрэн эрхийнхээ хугацаанд үүрэгт ажлаа бүр мөсөн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Зөвлөл нь орны хүнийг ээлжит Их хурал хүртэлх хугацаанд томилно.
7. Эрх зүйн байгууллагуудын хариуцлага болон чиг үүргийг Холбооны Сахилгын дүрэм болон Холбооны Ёс зүйн дүрмээр зохицуулна.

61-Р ЗҮЙЛ. **САХИЛГЫН ХОРОО**

1. Тус хорооны үйл ажиллагааг Холбооны Сахилгын дүрмээр зохицуулна. Хорооны гурваас доошгүй гишүүн оролцсон тохиолдолд хурлаас шийдвэр гарна. Зарим тохиолдолд хорооны дарга нь дангаараа шийдвэр гаргаж болно.
2. Тус хороо нь Холбооны ба Сахилгын дүрэмд заасан шийтгэлийг холбооны гишүүд, албаны хүн, клуб, дундын зуучид оногдуулж болно.
3. Гишүүнээс түдгэлзүүлэх ба хасах зэрэг шийтгэлүүд нь зөвхөн Их хурал ба Зөвлөлийн эрх хэмжээний асуудал мөн.
4. ОУХБХ-ны Сахилгын хорооны дүрмийн зарчмын дагуу Холбооны Сахилгын дүрмийг Зөвлөлөөс батална.

3. The judicial bodies are to be composed in such a way that the members, together, have the knowledge, abilities and specialist experience that is necessary for the due completion of their tasks. The chairpersons of the judicial bodies shall be qualified to practise law. The term of office shall be four years. The members may be re-elected or relieved of their duties at any time, although they may only be relieved of their duties by the Congress.
4. The Chairpersons, deputy chairpersons and other members of the judicial bodies shall be elected by the Congress upon proposal of the Council.
5. The Chairpersons, deputy chairpersons and members of the judicial bodies shall not be members of any other bodies of MFF.
6. If the chairpersons, the deputy chairperson or a member of a judicial body permanently ceases to perform his official function during his term of office, the Council shall appoint a replacement to serve until the next Congress.
7. The responsibilities and function of the judicial bodies shall be stipulated in the Disciplinary Code of MFF and the Code of Ethics of MFF.

ARTICLE 61 **DISCIPLINARY COMMITTEE**

1. The function of the Disciplinary Committee shall be governed by the Disciplinary Code of MFF. The Disciplinary Committee shall pass decisions only when at least three members are present. In certain cases, the chairman may rule alone.
2. The Disciplinary Committee may pronounce the sanctions described in these Statutes and the Disciplinary Code of MFF on Members, Officials, Players, Clubs and match and agents and intermediaries.
3. These provisions are subject to the disciplinary powers of the Congress and the Council regarding the suspension and expulsion of Members.
4. The Council shall issue the Disciplinary Code of MFF, which shall be in accordance with the principles laid down in the FIFA Disciplinary Code.

62-Р ЗҮЙЛ. ЁС ЗҮЙН ХОРОО

1. Тус хорооны үйл ажиллагааг Холбооны ёс зүйн дүрмээр зохицуулна. Хорооны гурваас доошгүй гишүүн оролцсон тохиолдолд хурлаас шийдвэр гаргана. Зарим тохиолдолд Хорооны дарга нь дангаараа шийдвэр гаргаж болно.
2. Тус Хороо нь Холбооны гаргасан Ёс зүйн дүрэм болон Сахилгын дүрэмд заасан шийтгэлийг Холбооны гишүүд, албаны хүн, тоглогч, клуб, тоглолт болон тоглогчдын дундын зуучид оногдуулж болно.
3. ОУХБХ-ны Ёс зүйн хорооны дүрмийн зарчмын дагуу Холбооны Ёс зүйн дүрмийг Зөвлөлөөс батална.

63-Р ЗҮЙЛ. МАРГААН ТАСЛАХ ХОРОО

1. Тус хорооны үйл ажиллагааг Холбооны Сахилгын ба Ёс зүйн дүрмээр зохицуулна. Хорооны гурваас доошгүй гишүүн оролцсон тохиолдолд хурлаас шийдвэр гаргана. Зарим тохиолдолд Хорооны дарга нь дангаараа шийдвэр гаргаж болно.
2. Тус Хороо нь Холбооны холбогдох журамд өөрөөр заагаагүй бол Сахилгын ба Ёс зүйн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдлыг хянаж шийдвэрлэнэ.
3. Маргаан таслах хорооноос гаргасан шийдвэрийг энэхүү дүрэмд зааснаар Монголын Олон улсын ба Үндэсний спортын шүүхээр дахин хянуулж болно.

ARTICLE 62 ETHICS COMMITTEE

1. The function of the Ethics Committee shall be governed by the Code of Ethics of MFF. The Ethics Committee shall pass decisions only when at least three members are present. In certain cases, the chairman may rule alone.
2. The Ethics Committee may pronounce the sanctions described in these Statutes, the Code of Ethics of MFF and the Disciplinary Code of MFF on MFF Members, Clubs, Officials, Players and match agents and intermediaries.
3. The Council shall issue the Code of Ethics of MFF, which shall be in accordance with the principles laid down in the FIFA Code of Ethics.

ARTICLE 63 APPEAL COMMITTEE

1. The function of the Appeal Committee shall be governed by the Disciplinary Code of MFF and the Code of Ethics of MFF. The Appeal Committee shall pass decisions only when at least three of the members are present. In certain cases, the chairman may rule alone.
2. The Appeal Committee is responsible for hearing appeals against decisions from the Disciplinary Committee and the Ethics Committee that are not declared final by the relevant regulations of MFF.
3. Decisions pronounced by the Appeal Committee may only be appealed to the Mongolian International and National Sports Arbitration Tribunal, as specified in these Statutes.

VI. САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

64-Р ЗҮЙЛ. САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Сахилгын дараах шийтгэлүүд байна. Үүнд:

1. Хувь хүн болон хуулийн этгээдэд
 - а) Сануулах;
 - б) Нээлттэй сануулах;
 - в) Торгох;
 - г) Олгосон шагналыг буцаан авах.
2. Хувь хүнд
 - а) Хуудсаар торгох;
 - б) Тоглолтоос хөөх;
 - в) Тоглолт өнжүүлэх;
 - г) Нийгмийн ажил хийлгүүлэх;
 - д) Хувцас солих өрөөнд орох ба эсвэл сэлгээний суудалд суухыг хориглох;
 - е) Цэнгэлдэх хүрээлэнд орохыг хориглох;
 - ё) Хөлбөмбөгт хамааралтай аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглох.
3. Хуулийн этгээдэд
 - а) Тамирчны шилжилт хөдөлгөөн хийхийг хориглох;
 - б) Тоглолтыг үзэгчгүй явуулах;
 - в) Тоглолтыг гуравдагч этгээдийн талбай дээр явуулах;
 - г) Тодорхой цэнгэлдэх хүрээлэнд тоглохыг хориглох;
 - д) Тоглолтын дүнг хүчингүйд тооцох;
 - е) Тэмцээнээс хөөх, хасах;
 - ё) Эрх хасах;
 - ж) Оноо хасах;
 - з) Лигийн зэрэглэл бууруулах;
 - и) Тоглолтыг дахин явуулах.
4. Сахилгын арга хэмжээг дараалал үл харгалзан оногдуулна.

VI. DISCIPLINARY MEASURES

ARTICLE 64 DISCIPLINARY MEASURES

The disciplinary measures are primarily:

1. for natural and legal entities:
 - a) a warning;
 - b) a reprimand;
 - c) a fine;
 - d) the return of awards.
2. for natural persons:
 - a) a caution;
 - b) an expulsion;
 - c) a match suspension;
 - d) a ban from the dressing rooms and/or the substitutes' bench;
 - e) a ban from entering a stadium;
 - f) a ban on taking part in any football-related activity;
 - g) a social work;
3. for legal entities:
 - a) a transfer ban;
 - b) playing a match without spectators;
 - c) playing a match on neutral territory;
 - d) a ban on playing in a stadium;
 - e) annulment of the result of the match;
 - f) expulsion from a competition;
 - g) a forfeit;
 - h) deduction of points;
 - i) relegation to a lower division;
 - j) replaying a match.
4. Disciplinary measures shall be taken disregarding its ordering.

VII. АРБИТР

65-Р ЗҮЙЛ. АРБИТР

1. Холбоо, Лиг, лигийн гишүүд, клуб, тэдгээрийн гишүүд, тоглогч, албаны хүмүүс болон бусад холбоодын албаны хүмүүстэй хамааралтай эсвэл тэдгээрийн хоорондох маргааныг Монгол улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол иргэний шүүхэд хандахтай холбоотой асуудлыг Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитраар хянан хэлэлцүүлнэ.
2. ОУХБХ эсвэл АХБХ-ны дүрэм, журам, чиглэл, шийдвэртэй холбоотой Олон улсын хэмжээний маргааныг ОУХБХ, АХБХ, ЗАХБХ-ны дүрмийн дагуу Олон улсын спортын арбитрын шүүхэд (CAS) хандаж болно.

66-Р ЗҮЙЛ. МАРГААНЫГ ШҮҮН ТАСЛАХ ЭРХ ХЭМЖЭЭ

1. Монгол Улсын хэмжээний маргаан (жишээ нь, Холбоонд хамааралтай талуудын маргаан)-ыг Холбооны эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх бөгөөд хэрэв шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ дүрмийн 65 дугаар зүйлд заасны дагуу Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитрт хандана. Бусад орны болон тивийн Хөлбөмбөгийн холбоотой үүссэн олон улсын шинжтэй маргааныг ОУХБХ хариуцна.
2. Холбоо нь ОУХБХ-ны байгууллага, АХБХ-ны байгууллага, ЗАХБХ-ны байгууллага, Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитр эсвэл Олон Улсын Спортын арбитрын шүүх (CAS)-ийн гаргасан эцсийн шийдвэрийг дагаж мөрдөнө.

VII. ARBITRATION

ARTICLE 65 ARBITRATION

1. Disputes within MFF or disputes affecting Members of MFF, Leagues, members of leagues, Clubs, members of Clubs, Players, Officials and other Association Officials may only be referred in the last instance (i.e. after exhaustion of all internal channels within MFF) to the Mongolian International and National Sports Arbitration Tribunal, which shall settle the dispute definitively to the exclusion of any ordinary court, unless expressly prohibited by the legislation of Mongolia.
2. Disputes of international dimension arising from or related to the Statutes, regulations, directives and decisions of FIFA or the AFC may only be submitted in the last instance to CAS as specified in the Statutes of FIFA, AFC and EAFF.

ARTICLE 66 JURISDICTION

1. MFF shall have authority on internal national disputes, i.e. disputes between parties belonging to MFF. If such decision is not accepted by parties, disputes can be lodged against in line with Article 65. FIFA and/or the AFC shall have authority on international disputes, i.e. disputes between parties belonging to different Associations and/or Confederations.
2. MFF shall ensure its full compliance and that of all those subject to its jurisdiction with any final decision passed by a FIFA body, an AFC body, an EAFF body, the Mongolian International and National Sports Arbitration Tribunal or CAS.

VIII. САНХҮҮ

67-Р ЗҮЙЛ. САНХҮҮГИЙН ЖИЛ

1. Холбооны санхүүгийн тайлант хугацаа нэг жил байх бөгөөд тухайн жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхэлж, арванхоёрдугаар сарын 31-ний өдрөөр дуусна.
2. Санхүүгийн тайлант хугацаанд орлого зарлагыг тэнцвэржүүлэх менежментийг хийнэ. Холбооны цаашдын үйл ажиллагааны баталгаа болгож нөөц хөрөнгөтэй болох чиглэлийг баримтална.
3. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Холбооны санхүүгийн нэгдсэн тайланг тухайн жилийн арванхоёрдугаар сарын 31-ний дотор гаргана.

68-Р ЗҮЙЛ. ОРЛОГО

1. Холбооны орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 1.1. Гишүүнчлэлийн татвар;
 - 1.2. Холбооны маркетингийн ашиг;
 - 1.3. Эрх бүхий байгууллагуудаас оногдуулсан торгууль;
 - 1.4. Холбооны зорилтыг биелүүлэхтэй холбоотой татвар хураамж;
 - 1.5. Хандив;
 - 1.6. Хөлбөмбөгийн үйл ажиллагаатай холбоотой олж буй бүхий л орлого;
 - 1.7. ОУХБХ, АХБХ, ЗАХБХ-ноос ирүүлж буй санхүүжилт.

69-Р ЗҮЙЛ. ЗАРДАЛ

1. Холбооны зардал:
 - 1) Төсвийн зардал;
 - 2) Их хурал ба Зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд батлагдсан бусад зардал;
 - 3) Холбооны зорилгыг биелүүлэхтэй холбоотой бусад зардал.

VIII. FINANCE

ARTICLE 67 FINANCIAL PERIOD

1. The financial period of MFF shall be one year and shall begin on 1 January and end on 31 December.
2. The revenue and expenses of MFF shall be managed so that they balance out over the financial period. MFF's major duties in the future shall be guaranteed through the creation of reserves.
3. The General Secretary is responsible for drawing up the annual consolidated accounts of MFF with its subsidiaries as at 31 December.

ARTICLE 68 REVENUE

1. The revenue of MFF arises specifically from:
 - 1.1. members' annual subscriptions;
 - 1.2. receipts generated by the marketing of rights to which MFF is entitled;
 - 1.3. fines imposed by the authorised bodies;
 - 1.4. other subscriptions and receipts in keeping with the objectives pursued by MFF;
 - 1.5. donations;
 - 1.6. any other revenue related to football activities.
 - 1.7. funding from FIFA, AFC and EAFF.

ARTICLE 69 EXPENSES

1. MFF bears:
 - 1) the expenses stipulated in the budget;
 - 2) other expenses approved by the Congress and expenses that the Council is entitled to incur within the scope of its authority;
 - 3) all other expenses in keeping with the objectives pursued by MFF.

70-Р ЗҮЙЛ. **ХАРААТ БУС, ХӨНДЛӨНГИЙН АУДИТ**

1. Их хурлаар батлагдсан Хараат бус, хөндлөнгийн аудит нь санхүүгийн хорооноос баталсан санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу хянаж, дүгнэлтээ Их хуралд танилцуулна. Аудитын шалгалтыг жил бүр явуулах бөгөөд тухайн аудитыг дөрвөн жилээр томилно. Улируулан сонгохгүй.

71-Р ЗҮЙЛ. **ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТАТВАР**

1. Их хурлын гишүүний татварыг жил бүрийн нэгдүгээр сарын 31-ний дотор төлсөн байна. Шинэ гишүүд тухайн жилийн татварыг гишүүнээр элссэн Их хурлаас хойш 30 хоногийн дотор төлнө.
2. Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэж, Их хурал нь татварын хэмжээг дөрвөн жилд нэг удаа тогтооно. Гишүүн бүр ижил хэмжээний татвар төлөх ба жилийн татвар нь 100,000 төгрөг байна.

72-Р ЗҮЙЛ. **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

1. Холбоо нь Гишүүдээс үүссэн өр төлбөрийг тухайн гишүүний хөрөнгөнөөс барагдуулж болно.

73-Р ЗҮЙЛ. **ХУРААМЖ**

1. Холбоо нь тоглолтын хураамж төлөхийг гишүүдээс шаардаж болно.

74-Р ЗҮЙЛ. **САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

1. Холбоо өөрийн цахим сайт дээр Их хурлаар батлагдсан, тус дүрэмд заасны дагуу (33.2.9, 33.2.10, 33.2.11) санхүүгийн албан ёсны бичиг баримтуудыг нийтэлнэ.

ARTICLE 70 INDEPENDENT AND EXTERNAL AUDITORS

1. The independent and external auditors appointed by the Congress shall audit the accounts approved by the Finance Committee in accordance with the appropriate principles of accounting and present a report to the Congress. The auditors shall carry out yearly independent audits of accounts and shall be appointed for a period of four years. This mandate shall not be renewed.

ARTICLE 71 MEMBERSHIP SUBSCRIPTIONS

1. Membership subscriptions are due on 31 January each year. The annual subscription for new Members for the year in question shall be paid within 30 days of the close of the Congress at which they are admitted.
2. The Congress shall fix the amount of the annual subscription every four years on the recommendation of the Council. It shall be the same for every Member and amount to 100.000 tugrugs.

ARTICLE 72 SETTLEMENT

1. MFF may debit any Member's assets to settle claims.

ARTICLE 73 LEVIES

1. MFF may demand that a levy be paid by its Members for matches.

ARTICLE 74 PUBLICATION OF FINANCIAL DATA

1. MFF shall publish on its official website the financial documents referred to under art. 33 par. 2.9, 2.10 and 2.11 of these Statutes once the relevant items have been approved by the Congress.

IX. ТЭМЦЭЭН БА ТЭМЦЭЭНИЙ БОЛОН БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР ЭДЛЭХ ЭРХ

75-Р ЗҮЙЛ. ТЭМЦЭЭНҮҮД

1. Холбоо нь Монгол улсын нутаг дэвсгэрт албан ёсны дараах тэмцээнүүдийг өмчилж, зохион байгуулж зохицуулна:
 - 1.1. Өсвөр ба идэрчүүдийн 4 насны тэмцээн;
 - 1.2. Залуучуудын УАШТ;
 - 1.3. Футзалын бүх насны тэмцээн;
 - 1.4. Эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн тэмцээн;
 - 1.5. Үндэсний лиг;
 - 1.6. Холбооны цом;
 - 1.7. Супер цом;
 - 1.8. Үндэсний цом;
 - 1.9. Сонирхогчдын тэмцээн;
 - 1.10. Мастер ангиллын тамирчдын тэмцээн;
 - 1.11. Бүсийн аварга шалгаруулах тэмцээн.
2. Зөвлөл нь Орон нутгийн хөлбөмбөгийн холбоонд тэмцээн зохион байгуулах эрх олгож болно. Эдгээр тэмцээнүүд нь Холбооноос зохион байгуулж буй тэмцээнүүдтэй давхардаж үл болох бөгөөд Холбооны тэмцээнүүдэд тэргүүн ач холбогдол өгнө.
3. Орон нутгийн хөлбөмбөгийн холбоонд тэмцээн зохион байгуулах эрх олгох талаар Зөвлөлөөс тусгай журам гаргаж болно.

IX. COMPETITIONS AND RIGHTS IN COMPETITIONS AND EVENTS

ARTICLE 75 COMPETITIONS

1. MFF owns, organises and coordinates the following official competitions held within the territory of Mongolia:
 - 1.1. Junior 4 age groups national Championship;
 - 1.2. Youth National Championship;
 - 1.3. Futsal (all age categories, incl. league);
 - 1.4. Women's tournaments;
 - 1.5. National League;
 - 1.6. MFF Cup;
 - 1.7. Super Cup;
 - 1.8. National Cup;
 - 1.9. Amateur Championship;
 - 1.10. Masters Championship;
 - 1.11. Regional championships.
2. The Council may delegate to MFF's subordinate Regional Associations the authority to organise competitions. The competitions organised by the Regional Associations shall not interfere with those competitions organised by MFF. Competitions organised by MFF shall take priority.
3. The Council may issue special regulations to this end.

76-Р ЗҮЙЛ. ТЭМЦЭЭНИЙ ЭРХ

1. Холбоо болон түүний гишүүд өөрийн эрх зүйн мэдлийн хүрээнд зохион явуулж буй тэмцээн болон бусад арга хэмжээтэй холбоотой бүхий л эрхийн анхдагч эзэмшигч мөн. Үүнд тэмцээний агуулга, явуулах цаг хугацаа ба байршилд хязгаар тогтоохгүй. Эзэмших эрх дотор санхүүгийн бүхий л төрлийн эрх, дуу дүрс ба радио бичлэг, хувилах ба дамжуулах эрх, мультимедиа эрх, маркетинг ба сурталчилгааны эрх, зохиогчийн эрхийг хамгаалах хуулийн хүрээнд багтсан тухайлбал эмблем гэх зэрэг эрхүүд багтана.
2. Дээрх эрхийг ямар хэмжээнд, хэрхэн яаж эдлэх асуудлыг Зөвлөл шийдвэрлэх бөгөөд уг асуудлаар тусгай журам гаргана.

77-Р ЗҮЙЛ. ЭРХ ОЛГОХ

1. Холбоо болон түүний гишүүд өөрийн эрх зүйн мэдлийн хүрээнд зохион явуулж буй тэмцээн болон бусад арга хэмжээтэй холбоотой дүрс, дуу авиа, бусад мэдээллийг түгээн дэлгэрүүлэх эрхийг олгох онцгой эрх эдэлнэ. Тэмцээний агуулга, цаг хугацаа, газар, техникийн болон хууль зүйн талаас хязгаар тогтоохгүй.

ARTICLE 76 RIGHTS

1. MFF and its Members are the original owners of all the rights emanating from competitions and other events coming under their respective jurisdiction, without any restrictions as to content, time, place and law. These rights include, among others, every kind of financial rights, audiovisual and radio recording, reproduction and broadcasting rights, multimedia rights, marketing and promotional rights and incorporeal rights such as emblems and rights arising under copyright law.
2. The Council shall decide how and to what extent these rights are utilised and draw up special regulations to this end.

ARTICLE 77 AUTHORISATION

1. MFF and its Members are exclusively responsible for authorising the distribution of image and sound and other data carriers of football matches and events coming under their respective jurisdiction, without any restrictions as to content, time, place and technical and legal aspects.

X. ОЛОН УЛСЫН ТОГЛОЛТ БА ТЭМЦЭЭН

78-Р ЗҮЙЛ. ОЛОН УЛСЫН ТОГЛОЛТ БА ТЭМЦЭЭН

1. Шигшээ баг, лиг болон клубын багийн олон улсын тоглолт ба тэмцээнийг зохион явуулах эрх мэдлийг зөвхөн ОУХБХ, Тивийн холбоод болон ОУХБХ-ны гишүүн Холбоод эдэлнэ. ОУХБХ-ны олон улсын тоглолтыг зохицуулах журамд зааснаар ОУХБХ, Тивийн холбоод болон ОУХБХ-ны гишүүн Холбооны урьдчилсан зөвшөөрөлгүйгээр ямар ч тэмцээн болон тоглолт явагдахгүй.
2. Холбоо нь ОУХБХ-ноос гаргасан олон улсын тэмцээнүүдийн календарьчилсан төлөвлөгөөг дагаж мөрдөнө.

79-Р ЗҮЙЛ. ХАРИЛЦАА ХОЛБОО

1. Холбоо, түүний гишүүд, тоглогчид, албаны хүмүүс, тоглолтын болон тоглогчдын агентууд нь ОУХБХ-ны зөвшөөрөлгүйгээр ОУХБХ-ны гишүүн бус Холбоод, эсвэл Тивийн холбооны албан бус гишүүн Холбоотой тоглолт хийх, эсвэл спортын арга хэмжээнд оролцож үл болно.

80-Р ЗҮЙЛ. ЗӨВШӨӨРӨЛ

1. Холбоонд харьяалагдах клуб, лиг ба багууд нь зөвхөн Холбоо, ОУХБХ-ны гишүүн бусад байгууллага, харьяалагдах Тивийн холбоо, ОУХБХ-ны зөвшөөрлөөр ОУХБХ-ны гишүүн бусад байгууллагатай харилцаатай байж болно.
2. Холбоонд харьяалагдах клуб, лиг ба багууд нь ОУХБХ-ны олон улсын тоглолтыг зохицуулах журамд зааснаар Холбоо, ОУХБХ-ны бусад гишүүн байгууллага, ОУХБХ болон харьяалагдах Тивийн холбооны зөвшөөрөлгүйгээр ОУХБХ-ны бусад гишүүн байгууллагын нутаг дэвсгэрт зохион явуулж буй тэмцээнд оролцож үл болно.

X. INTERNATIONAL MATCHES AND COMPETITIONS

ARTICLE 78 INTERNATIONAL MATCHES AND COMPETITIONS

1. The authority for organising international matches and competitions between representative teams and between Leagues, Club teams and/or scratch teams lies solely with FIFA, the Confederation(s) and/or the FIFA Member Association(s) concerned. In accordance with the FIFA Regulations Governing International Matches, no such match or competition shall take place without the prior permission of FIFA, the Confederation(s) and/or the FIFA Member Association(s) concerned.
2. MFF is bound to comply with the international match calendar compiled by FIFA.

ARTICLE 79 CONTACTS

1. MFF, its Members, Players, Officials and match and player's agents shall not play matches or make sporting contacts with Associations that are not members of FIFA or with provisional members of a Confederation without the approval of FIFA.

ARTICLE 80 APPROVAL

1. Clubs, Leagues or any other group of Clubs that are affiliated to MFF may only join another FIFA Member Association with the authorisation of MFF, the other FIFA Member Association, the respective Confederation(s) and FIFA.
2. Clubs, Leagues or any other group of Clubs that are affiliated to MFF cannot participate in competitions on the territory of another Association without the authorisation of MFF, the other FIFA Member Association(s), FIFA and the respective Confederation(s) according to the FIFA Regulations Governing International Matches.

XI. ТӨГСГӨЛИЙН ЗҮЙЛҮҮД

81-Р ЗҮЙЛ. УРЬДЧИЛАН ТООЦООЛОХ БОЛОМЖГҮЙ БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад өөр асуудлаар болон давагдашгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд ОУХБХ, АХБХ, ба ЗАХБХ–ны холбогдох журмын дагуу эцсийн бодит шийдвэр гаргах эрхийг Зөвлөл эдэлнэ.

82-Р ЗҮЙЛ. БАЙГУУЛЛАГЫН БИЧИГ БАРИМТУУДЫГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ

1. Холбоо нь дараах бичиг баримтуудыг цахим сайт дээр байршуулна. Үүнд:
 - 1.1. МХБХ Дүрэм ба Их хурал хуралдуулах дэгийн заавар;
 - 1.2. Сонгуулийн дүрэм;
 - 1.3. Сахилгын дүрэм ба Ёс зүйн дүрэм;
 - 1.4. Холбооны дотоод зохион байгуулалтын журам;
 - 1.5. Чухал шийдвэрүүд;
 - 1.6. Стратеги төлөвлөгөө;
 - 1.7. Их хурал болон Зөвлөлийн хурлуудын хэлэлцэх асуудал;
 - 1.8. Захидал, албан бичиг.

83-Р ЗҮЙЛ. ТАТАН БУУЛГАХ

1. Холбоог татан буулгах шийдвэр гаргахад тусгайлан Их Хурлыг хуралдуулж төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
2. Холбоо татан буугдсан тохиолдолд Холбооны хөрөнгийг байгууллагад түр хугацаагаар шилжүүлэх бөгөөд Холбоог дахин байгуулагдах хүртэлх хугацаанд мэргэжлийн чиг үүргийн дагуу хөрөнгийг хадгална. Холбооны хөрөнгийг хүлээн авах этгээдийг Холбооны Их хуралд оролцсон төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар сонгож шийдвэрлэнэ.

XI. FINAL PROVISIONS

ARTICLE 81 UNFORESEEN CONTINGENCIES AND FORCE MAJEURE

1. The Council shall have the power to decide on all cases of force majeure and on all matters not provided for in these Statutes, such decisions to be made per right and justice, considering the relevant regulations of FIFA, AFC and EAFF.

ARTICLE 82 PUBLICATION OF CORPORATE DOCUMENTS

1. MFF shall make available on its official website the following documents and information:
 - 1.1. Statutes and Standing Orders of the Congress;
 - 1.2. Electoral Code;
 - 1.3. Disciplinary and Ethics Code;
 - 1.4. Internal Organisation Regulations;
 - 1.5. Most important/key decisions;
 - 1.6. Its strategy;
 - 1.7. Agenda for Council and Congress meetings;
 - 1.8. Circular letters.

ARTICLE 83 DISSOLUTION

1. Any decision relating to the dissolution of MFF requires most two-thirds of all the Members of MFF, which must be obtained at a Congress specially convened for the purpose.
2. If MFF is disbanded, its assets shall be transferred to It shall hold these assets as a trustee in accordance with the relevant professional duties until MFF is re-established. The final Congress may, however, choose another recipient for the assets on the basis of a two-thirds majority.

84-Р ЗҮЙЛ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ НЬ

1. Энэхүү Дүрэм нь 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хотноо хуралдсан Холбооны ээлжит Их Хурлаар батлагдсан бөгөөд мөн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Мөн өдрөөс эхлэн өмнөх дүрэм хүчингүйд тооцогдоно.

85-Р ЗҮЙЛ. ТӨГСГӨЛИЙН ЗҮЙЛ

1. Тус дүрмийн 12 дугаар зүйлд заасны дагуу Их хурлын гишүүд нь 12 сарын хугацаанд эрх эдэлж, үүрэг хүлээж, 13 дугаар зүйлийн 2 дахь заалтад заасан шаардлагуудыг зайлшгүй дагаж мөрдөнө. Хэрэв биелүүлээгүй тохиолдолд Их хуралд санал өгөх эрхээ алдаж, Их хурлын ирцэд оролцоогүйд тооцно. Дээр дурдсан шаардлагуудыг хангасан тохиолдолд Их хуралд санал өгөх эрх нь сэргэнэ.
2. Энэ дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтад заасан гишүүн нь энэ дүрмийг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс эхлэн 13.2.1-13.2.13 дахь заалтад заасан шалгуур үзүүлэлтийг зургаан сарын хугацаанд заавал хангах үүрэгтэй. Тус шаардлагыг хангаагүй гишүүн нь Их хурлын санал өгөх эрхээ алдах бөгөөд ирцэд тооцогдохгүйгээр Их хуралд оролцоно. Улмаар тус гишүүнд тухайн шаардлагыг хангах зургаан сарын хугацаа олгоно. Энэ хугацаанд клубын лицензийг аваагүй тохиолдолд Холбооны Их хурлын санал өгөх эрхтэй гишүүнээс автоматаар түдгэлзүүлж, Их хуралд тус гишүүнийг түдгэлзүүлсэн тухай баталгаажуулах шаардлагагүй. Энэ дүрмийн 13.2.14 дэх заалтад заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд түдгэлзүүлсэн гишүүний эрхийг сэргээнэ.
3. Энэ дүрмийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтад заасан шударга байдлын мэдэгдлийг бөглөх нь энэ дүрмийг батлах үед Зөвлөлийн гишүүнээр нэгэнт сонгогдсон байсан гишүүдэд хамаарахгүй. Харин энэ дүрэм батлагдсаны дараа сонгогдохоор нэр дэвшиж буй удирдах зөвлөлийн гишүүд 38.4 дэх шаардлагыг хангана.
4. Чөлөөлөх асуудлыг хэлэлцэхдээ Зөвлөл болон Их хурлын санал хураалтыг нууцаар явуулж, хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёр (2/3)-ын саналаар шийдвэрлэнэ.
5. Үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн этгээд нь оногдсон үүргээсээ нэн даруй чөлөөлөгдөнө. (түр эсвэл бүрэн)

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

А. ИХ ХУРАЛ

26-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН ТОДОРХОЙЛОЛТ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

1. Их хурал нь Холбооны гишүүдийн тогтмол хуралддаг эрх барих дээд байгууллага бөгөөд дүрмийн дагуу хуралдсан Их хурлын шийдвэр нь хүчин төгөлдөр байх болно. Их хурал нь ардчилсан, хөлбөмбөг дэх хүйсийн эрх тэгш байдлыг хангасан зарчмыг баримтална. Их хурал нь тус Дүрмийн дагуу хуралдсан тохиолдолд шийдвэрийг хүчинтэйд тооцно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

2. Их хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас цахим хэлбэрээр хуралдаж болно. Харилцаа холбооны аргаар, телеконференц, видеохурал хэлбэрээр явагдах үед цахим саналыг хүчин төгөлдөрт тооцно. Сонгуульт Их хурлыг цахимаар зохион байгуулахгүй.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

4. Зөвлөл Их хуралд оролцох ажиглагчийг томилж болох бөгөөд тус ажиглагч нь хэлэлцүүлэгт орох болон санал өгөх эрхгүй байна.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

27-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН ГИШҮҮД ТӨЛӨӨЛӨГЧИД, САНАЛ ХУРААЛТ

1. Их хурал 52 гишүүдээ төлөөлөгчдөөс бүрдэнэ. Их хурлын гишүүдийн төлөөлөгчдийн тоог дараах хуваарийн дагуу тогтооно. Үүнд:

1.6. Ахмадын Мастер ангиллын тамирчдын зөвлөл 2

3. Төлөөлөгч бүр Их хурлын санал хураалтад тэгш эрхтэй (саналын нэг эрхтэй) оролцоно. Их хуралд зөвхөн өөрийн биеэр оролцсон төлөөлөгч санал өгөх эрхтэй. Санал өгөх эрхээ бусдад шилжүүлэх эсвэл албан бичгээр санал өгөхийг хориглоно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

28-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

1. Их хурал дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
3. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид болон Зөвлөлийн гишүүдийг сонгох,

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4. Эрх зүйн байгууллагуудын Хараат бус байгууллагуудын дарга, дэд дарга болон гишүүдийг сонгох,

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5. Клуб лицензжүүлэх байгууллагуудын гишүүдийг сонгох ба чөлөөлөх;

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

5. Их хурлын тооллогын комиссын гурван гишүүнийг томилох;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

12. Их хурлын гишүүнээр элсүүлэх, Их хурлын гишүүнийг түдгэлзүүлэх болон Их хурлын гишүүнээс чөлөөлөх хасах эсвэл хөөх асуудлыг шийдвэрлэх;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

13. Гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс чөлөөлөх эсвэл хөөх асуудлыг шийдвэрлэх;

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

14. Холбооны байгууллагын нэг буюу хэд хэдэн гишүүний бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгох **гишүүдийг чөлөөлөх**;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

16. Их хурлын гишүүнээс байгууллагаас гаргасан хүсэлтийг дүрмийн дагуу хүлээж авах эсэх талаар шийдвэрлэх;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

17. ~~Сонгуулийн хороо, Сонгуулийн Хяналтын хорооны гишүүдийг сонгох ба чөлөөлөх;~~

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

18. ~~Зөвлөлийн саналаар Аудит ба Хяналт шалгалтын хорооны гишүүдийг сонгох ба чөлөөлөх;~~

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

17. Дүрмийн дагуу гишүүнээс гаргасан хүсэлтийг тогтоолоор батлах, эсвэл дүрмийн дагуу Их хурлын гаргасан шийдвэрүүдийг тогтоолоор батлах.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

29-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН ИРЦ

2. Хурлын ирц олонход хүрээгүй тохиолдолд 24 цагийн дотор тухайн хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүйгээр Их хурлаа дахин хуралдуулна.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4. Их хурлын төлөөлөгчдийн ирцийг хүчин төгөлдөрт тооцсоны дараа төлөөлөгчид явсан тохиолдолд ирцэд нөлөөлөхгүй. Нэгэнт Их хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсоны дараа ирсэн төлөөлөгч Их хуралд санал өгөх эрхгүй оролцоно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

31-Р ЗҮЙЛ. СОНГУУЛЬ

1. Сонгуулийг нэр дэвшүүлж явуулна. Сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Нэр дэвшигчийн тоо мандатын тоотой тохирсон тохиолдолд нэр дэвшигчдийг шууд батална **карт эсвэл гар өргөж сонгоно.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3. Зөвлөлийн гишүүдийн сонгуулиудыг **энэ дүрмийн 38.1-д заасны дагуу** дараах дарааллаар явуулна. Ерөнхийлөгч, эрэгтэй ба эмэгтэй 2 Дэд ерөнхийлөгч, зөвлөлийн гишүүд, зөвлөлийн эмэгтэй гишүүн, Орон нутгийн холбоодоос сонгогдсон гишүүнийг батламжлах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөлөөс сонгогдсон гишүүнийг шууд батламжлах. Үүнд:

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

5. **Эмэгтэй** гишүүн: Эмэгтэй гишүүнийг хүчин төгөлдөр олонхийн (50 хувиас дээш) саналаар сонгоно. Эхний санал хураалтаар аль нэг нэр дэвшигч нь санал өгсөн гишүүдийн 50 хувиас дээш саналыг авч чадахгүй байх тохиолдолд хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтаар хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдаж, энгийн олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

7. **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөг:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөл нь өөрийн дүрмийн дагуу төлөөллөө сонгох бөгөөд **тус төлөөлөгчийг Холбооны Их хурлын 50 хувиас дээш саналаар батламжилна.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4. Холбооны бусад байгууллагын Дарга, дэд дарга болон гишүүдийг хамгийн их санал авсан дарааллаар сонгоно. **Тус сонгуулийг багцаар нь явуулна.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5. Санал тэнцсэн тохиолдолд хоёр дахь дараагийн санал хураалтыг тус Дүрэмд заасны дагуу дахин явуулна. (санал тэнцэж санал хураалтыг дахин явуулах тоо 5-аас хэтрэхгүй байна) Хэрэв дээрх тохиолдолд санал тэнцсэн тохиолдолд энэ Дүрмийн дагуу шинээр сонгуульт Их хурал зарлах хүртэл нэр дэвшиж буй албан тушаалыг хоосон үлдээнэ.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

7. Хоосон саналын хуудас, хүчингүй саналын хуудас, цахим хуурамч саналын хуудас зэргийг саналын хүчинтэй хуудаст тооцохгүй.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

32-Р ЗҮЙЛ. ЭЭЛЖИТ ИХ ХУРАЛ

3. Гишүүд Их хурлаар хэлэлцүүлэх аливаа саналаа бичгээр товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн газарт Их хурал болохоос 30 хоногийн өмнө ирүүлнэ.

/Энэ хэсгийг 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс шилжүүлснийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор батлав/

4. Их хурал болохоос 10 хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудал, ажлын тайлан, санхүүгийн болон аудитын тайлан, бусад холбогдох бичиг баримтыг Холбооны Их хурлын төлөөлөгчдөд хүргүүлнэ.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

33-Р ЗҮЙЛ. ЭЭЛЖИТ ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Зөвлөл болон Их хурлын гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэж Их Хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулна. Гишүүд Их Хурлаар хэлэлцүүлэх аливаа саналаа бичгээр товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн газарт Их хурал болохоос 30 хоногийн өмнө ирүүлнэ.

/Энэ хэсгийг 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэг рүү шилжүүлснийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор батлав/

2. Их хурал дараах асуудлыг дарааллын дагуу хэлэлцэнэ. Үүнд:
- 2.9. Санхүүгийн **тайлан тэнцэл болон хараат бус хөндлөнгийн аудитын тайланг** танилцуулах;
- 2.10. Санхүүгийн **аудитын тайланг** батлах;
- 2.12. Холбооны дүрэм **болон Их хурал хуралдуулах дэгийн зааварт** нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал хураах;
- 2.13. Энэ зүйлийн **3-т заасны дагуу** Холбооны гишүүд болон Зөвлөлөөс гаргасан саналыг хэлэлцэх;
- 2.15. Холбооны байгууллагыг татан буулгах эсвэл хувь хүнийг чөлөөлөх **(шаардлагатай бол)**;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

- 2.17. ~~Эрх зүйн байгууллагуудын~~ **Хараат бус байгууллагуудын гишүүдийг сонгох (Аудит ба дүрэм журмын хяналтын нэгж, сонгуулийн хороод, эрх зүйн байгууллагууд гэх мэт)** (шаардлагатай бол);
- 2.18. ~~Аудит ба Хяналт шалгалтын хорооны гишүүдийг сонгох~~ **(шаардлагатай бол)**;

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

- 2.19. ~~Сонгуулийн хороо, Сонгуулийн хяналтын хорооны гишүүдийг сонгох;~~

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

- 2.18. **Гишүүнчлэлийг батлах (шаардлагатай бол)**;

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

- 2.19. ~~Бусад.~~

34-Р ЗҮЙЛ. ЭЭЛЖИТ БУС ИХ ХУРАЛ

2. Холбооны **Их хурлын гишүүдийн** гуравны хоёроос дээш гишүүдийн албан ёсоор ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Зөвлөл ээлжит бус Их хурлыг хуралдуулна. **Их хурлын гишүүд** тавьсан хүсэлтэндээ хэлэлцэх асуудлыг тодорхой заана. Хүсэлтийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор ээлжит бус Их хурлыг хуралдуулна. Хэрэв ээлжит бус Их хурлыг хуралдуулахгүй тохиолдолд хүсэлт гаргасан **гишүүдийн** төлөөлөгчид өөрсдөө ээлжит бус Их хурлыг хуралдуулж болно. **Хүсэлт гаргасан гишүүдийн төлөөлөгчид мөн Олон улсын Хөлбөмбөгийн Холбоо (FIFA) болон Азийн Хөлбөмбөгийн Холбоо (AFC)-ноос туслалцаа хүсч болно.** Энэ тохиолдолд Холбооны **Их хурлын гишүүд Зөвлөлд ээлжит бус Их хурал болох газар, хурлын товыг энэ зүйлийн 3 дахь заалтад заасан хэлэлцэх асуудлын хамт мэдэгдэнэ.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

35-Р ЗҮЙЛ. ХОЛБООНЫ ДҮРЭМ БОЛОН ИХ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ДЭГИЙН ЗААВАРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

1. Их хурал нь Дүрэм, **Их хурал хуралдуулах дэгийн зааварт** нэмэлт, өөрчлөлт оруулах эрх, ~~үүрэгтэй бөгөөд, хэрэв боломжтой бол нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хариуцна.~~
2. **Их хурлын гишүүд** эсвэл Зөвлөл Холбооны дүрэм болон Их хурал хуралдуулах дэгийн зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа бичгээр гаргаж товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлнэ. **Гишүүнээс гаргаж буй санал нь гурваас доошгүй гишүүд дэмжиж түүнийгээ бичгээр илэрхийлсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 10 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

3. Холбооны дүрэм болон **Их хурал хуралдуулах дэгийн зааварт** орох нэмэлт, өөрчлөлтийг санал өгөх эрхтэй төлөөлөгчдийн ирц олонхид (50 хувиас дээш) хүрсэн тохиолдолд хэлэлцэнэ.

4. Холбооны дүрэм болон Их хурал хуралдуулах дэгийн зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал нь хуралд оролцсон, санал өгөх эрхтэй нийт гишүүдийн **дийлэнх олонхийн** (50 хувиас дээш) **(2/3)-ын** саналаар дэмжигдэж батлагдана.
5. **Холбоо нь Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг ОУХБХ болон АХБХ-нд мэдэгдэнэ.**

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

Б. ЗӨВЛӨЛ

38-Р ЗҮЙЛ. БҮРЭЛДЭХҮҮН

1. Зөвлөл 15 гишүүнтэй байна. Үүнд:
 - 1.3. **Эмэгтэй Дэд ерөнхийлөгч-1;**
 3. **Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид болон Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Бүрэн эрхийн хугацаа тухайн сонгуулиар сонгогдсон даруйд хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгчийг 1 удаа улируулан сонгож болно. Ерөнхийлөгч (дараалсан эсвэл дарааллаагүй нийт хоёроос илүү удаа сонгогдохгүй)-өөс бусад Зөвлөлийн гишүүд улиран сонгогдож болно. (Тухайн сонгогдсон дөрвөн жилийг бүрэн гүйцэтгээгүй ч ажилласанд тооцно)**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4. Зөвлөлийн гишүүн нь 18-аас дээш настай, **энэ дүрмийн хавсралт 3-т заасан шударга байдлын мэдэгдлийг бөглөж, хангасан, сонгууль эсвэл дахин сонгуулиас өмнө сонгуулийн хороонд материалаа шалгуулсан, хөлбөмбөгийн спортод дөрвөөс доошгүй жил идэвхтэй оролцсон, Холбооны 5-аас доошгүй гишүүн байгууллага нэр дэвшихийг дэмжиж санал бэлгэсэн, Монгол улсын хууль тогтоомжийг зөрчиж, гэмт хэрэгт холбогдоогүй, Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэн байна.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5. Зөвлөлийн гишүүн нь **Аудит, Хяналтын хороо, Их хурлын**

төлөөлөгч, эсвэл Холбооны Хараат бус байгууллагуудын гишүүнээр давхар томилогдон ажиллахыг хориглоно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

6. Зөвлөлийн гишүүн эсвэл Зөвлөлийн гишүүдийн 50 хүртэлх хувь нь орон гарсан тохиолдолд Зөвлөл дараагийн ээлжит болон ээлжит бус Их хурлаар ижил шалгуурын дагуу хуралдуулах асуудлыг хариуцах бөгөөд Их хурал дутуу гишүүдийн тоог орон гарсан гишүүний бүрэн эрхийнх нь хугацаагаар нөхөж сонгоно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7. Зөвлөлийн гишүүдийн 50 хувиас дээш хувь нь орон гарсан тохиолдолд Шуурхай зөвлөл Ерөнхий нарийн бичгийн дарга нь ээлжит бус Их хурал зарлан хуралдуулж, үлдсэн бүрэн эрхийн хугацааны дахин сонгууль явуулна. Шуурхай зөвлөлийн хурлын ирц бүрэлдэхгүй байх тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн даргын газар ээлжит бус Их Хурлыг тодорхой заасан хугацаанд хуралдуулна.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

8. Зөвлөлийн гишүүн нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан эсвэл хуралдаанд нэг жилд гурван удаа оролцоогүй бол гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно. (үүнд ээлжит болон ээлжит бус хуралдаан аль аль нь хамаарна)

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

39-Р ЗҮЙЛ. ХУРАЛДААН

2. Зөвлөлийн хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит бус хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж, оролцож болно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

3. Зөвлөлийн ээлжит хуралдаан нь улиралд нэг удаа хуралдана. Ерөнхийлөгч хуралдааныг зарлан хуралдуулж даргална.

4. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг ~~Зөвлөлийн гишүүдийн 50 хувь нь хуралдаан зарлах хүсэлт гаргасан тохиолдолд Ерөнхийлөгч 21 долоо~~ хоногийн дотор зарлан хуралдуулна. Хэрэв Ерөнхийлөгч энд дурдсан хугацаанд хуралдааныг зарлан хуралдуулахгүй бол ~~Зөвлөлийн гишүүдийн 50 хувийн саналаар~~ зарлан хуралдуулна.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5. Ерөнхийлөгч хуралдааны хэлэлцэх асуудлыг тодорхойлно. Зөвлөлийн гишүүн бүр хэлэлцэх асуудлын талаар санал өгөх эрхтэй. ~~Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудалд оруулах саналаа Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хуралдаан болохоос 14 хоногийн өмнө ирүүлнэ байна. Хэлэлцэх асуудлыг ээлжит хуралдаан болохоос долоо хоногийн өмнө, Ээлжит бус хуралдаан болохоос гурав хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.~~

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

6. Ерөнхий нарийн бичгийн дарга Зөвлөлийн хуралдаанд саналын эрхгүйгээр зөвлөх үүрэгтэй оролцоно. ~~Ерөнхий нарийн бичгийн дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд өөрийн төлөөллийг Зөвлөлөөр батлуулсан даруйд оролцуулж болно.~~

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

8. Хоёр хуралдааны хооронд шуурхай хэлэлцэх асуудал гарсан тохиолдолд Ерөнхийлөгч Зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааг үл хамаарч эсвэл өөрчилж болно. Шийдвэрүүдийг харилцаа, холбооны бүхий л хэлбэрээр батална. (и-мэйл, мессеж гэх мэт)

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

40-Р ЗҮЙЛ. ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

2. Холбооны Их хурлын бүрэн эрхэд хамаараагүй бусад асуудлыг эсвэл Дүрэмд заасан бусад байгууллагуудын бүрэн эрхэд заагаагүй асуудлыг шийдвэрлэнэ;

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

- Их хурлаас сонгогддог Байнгын хороодын дарга, дэд дарга болон гишүүдийг Холбооны гишүүд эсвэл Ерөнхийлөгчийн санал болгосноор томилох;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

- Ээлжит Их хурал хүртэл түр хугацаагаар хувь хүнийг чөлөөлөх ба Холбооны байгууллагын гишүүнийг татан буулгана чөлөөлнө; эсвэл Холбооны гишүүн байгууллагыг гишүүнчлэлээс чөлөөлж болно;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж, хассан/

- Их хурал болох хүртэл эрх зүйн байгууллага болон Аудит ба Хяналт шалгалтын Хараат бус байгууллагуудын дутуу гишүүдийг томилно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

- Клуб лицензжүүлэх байгууллагуудын гишүүдийг сонгох ба чөлөөлнө.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж, нэмсэн/

41-Р ЗҮЙЛ. ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРҮҮД

- Зөвлөлийн хуралдааны ирц олонх (50 хувиас дээш)-д хүрсэн тохиолдолд хурал хүчинтэйд тооцогдоно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 10 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

- Зөвлөлийн шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар (50 хувиас дээш) батална. Санал тэнцсэн үед Ерөнхийлөгчийн саналаар шийдвэрлэнэ. Санал өгөх эрхийг бусдад шилжүүлэх эсвэл албан бичгээр өгөхийг үл зөвшөөрнө. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас харилцаа холбооны аргуудаар эсвэл видео болон телеконференц хэлбэрээр зөвлөлийн хуралдаан зохион байгуулагдсан тохиолдолд цахим саналыг хүчин төгөлдөрт тооцно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

3. Ашиг сонирхлын зөрчил гарах магадлалтай тохиолдолд Зөвлөлийн гишүүн нь тухайн асуудал хэлэлцэх мөн шийдвэр гаргахаас татгалзана. болно:

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 10 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

40-Р ЗҮЙЛ. АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ, БАЙГУУЛЛАГА ТАТАН БУУЛГАХ

- a. — Их хурал нь хувь хүн эсвэл байгууллагын гишүүнийг чөлөөлж болно. Зөвлөл нь хувь хүнийг чөлөөлөх, байгууллагыг татан буулгах саналыг Их Хурлаар хэлэлцэх асуудалд оруулж болно. Зөвлөл нь түр хугацаагаар хувь хүнийг чөлөөлж, Холбооны байгууллагыг татан буулгаж болно. Зөвлөлийн гишүүн бүр хувь хүнийг чөлөөлөх, байгууллагыг татан буулгах тухай саналыг Их хурал эсвэл Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудалд оруулж болно.
- b. — Хувь хүнийг чөлөөлөх, байгууллагыг татан буулгах талаар санал гаргахад заавал шалтгаан, үндэслэлийг нь заан өгч түүнийгээ хэлэлцэх асуудлын хамт Зөвлөл ба Холбооны бүх гишүүдэд хүргэнэ.
- c. — Албан тушаалаас чөлөөлөгдөж буй хувь хүн, татан буугдаж буй байгууллага нь өөрийгөө өмгөөлөх эрхтэй.
- d. — Чөлөөлөх эсвэл татан буулгах тухай асуудлыг нууц санал хураалтаар явуулж гуравны хоёр $\{2/3\}$ ын саналаар шийднэ.

Албан тушаалаасаа чөлөөлөгдсөн {түр}, татан буугдсан {түр} этгээд нь ногдсон үүргээсээ нэн даруй чөлөөлөгдөнө.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

V. ЕРӨНХИЙЛӨГЧ

42-Р ЗҮЙЛ. ЕРӨНХИЙЛӨГЧ

6. Ерөнхийлөгч Их хурал, Зөвлөлийн хуралдааныг—Шуурхай зөвлөлийн хуралдааныг тус тус даргална.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

7. Ерөнхийлөгч Зөвлөлийн хуралдаанд **энгийн саналаар оролцох бөгөөд эрх тэгш саналтай оролцоно: гагцхүү санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгчийн санал шийдвэрлэх үүрэгтэй байна.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж, хассан/

8. Ерөнхийлөгч нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан аль эсвэл Зөвлөлийн хуралдаанд **нэг жилд 3 удаа оролцоогүй** Ерөнхийлөгч энэ дүрмийн 38.8 дахь заалтанд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд **хамгийн удаан ажилласан Дэд ерөнхийлөгч, мөн тэдгээрийн эзэнгүй тохиолдолд дараагийн Их хурал болтол хамгийн олон жил ажилласан Зөвлөлийн гишүүн Ерөнхийлөгчийн үүргийг орлоно.** Ерөнхийлөгч чөлөөлөгдсөн тохиолдолд үлдсэн хугацаанд сонгогдон ажиллах Ерөнхийлөгчийг Их хурлаар сонгоно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж, хассан/

Д. ШУУРХАЙ ЗӨВЛӨЛ

42-Р ЗҮЙЛ. ШУУРХАЙ ЗӨВЛӨЛ

1. **Шуурхай зөвлөл нь Зөвлөлийн ээлжит хуралдаан болохоос өмнө яаралтай шийдвэрлүүлэх асуудлуудыг хариуцна. Шуурхай зөвлөл нь Холбооны Ерөнхийлөгч болон Зөвлөлийн таван гишүүдээс бүрдэнэ. Эдгээр гишүүдийг Зөвлөл 4 жилийн хугацаагаар томилно.**
2. **Шуурхай зөвлөлийн хурлыг Ерөнхийлөгч зарлана. Хурлыг шаардлагатай хугацаанд хуралдуулах боломжгүй тохиолдолд захидал харилцааны бусад шугамыг ашиглаж шийдвэрт хүрч болно. Шийдвэр нь гарсан даруйдаа хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгч эдгээр шийдвэрүүдийг Зөвлөлд шуурхай танилцуулна.**
3. **Шуурхай зөвлөлийн хурлын ирц 3-аас доош гишүүнтэй байвал**

хурлын хэлэлцүүлэг хүчингүйд тооцно. Шуурхай зөвлөлийн гаргасан шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхын (50 хувиас дээш) саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгч шийдвэрлэх саналтай байна.

4. Шуурхай зөвлөлийн гаргасан шийдвэрүүдийг Зөвлөлийн дараагийн хуралдаанаар батална.
5. Зөвлөлийн хуралд Ерөнхийлөгч биечлэн оролцох боломжгүй тохиолдолд Ерөнхийлөгчийн санал болгосон аль нэг Дэд ерөнхийлөгч хурлыг удирдана даргална.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

Г. БАЙНГЫН ХОРООД

44-Р ЗҮЙЛ. БАЙНГЫН ХОРООД

1. Холбоо нь дараах Байнгын хороодтой байна. Үүнд:

- 1.2. Аудит Хяналтын шалгалтын хороо;

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

2. Аудит, хяналт шалгалтын хорооноос Шүүгчийн хорооноос бусад байнгын хороодыг Зөвлөлийн гишүүд даргална. Зөвлөл нь Ерөнхийлөгч эсвэл Холбооны гишүүдийн саналыг үндэслэж Байнгын хороо тус бүрийн гишүүдийг томилно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

6. Байнгын хороодын гишүүд нь тухайн ажил үүргийг гүйцэтгэх ур чадвартай, туршлагатай, мэдлэг чадвартай, мэргэшсэн гишүүдээс бүрдсэн байна. Зөвлөл Байнгын хороодын зохих эмэгтэй төлөөллийг хангаж ажиллуулна.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

44-Р ЗҮЙЛ. АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХОРОО

1. Тус хороо нь санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг хангах болон санхүүгийн тайлан, нэгдсэн санхүүгийн тайлан болон хөндлөнгийн аудиторын тайланг хянах үүрэгтэй.
2. Тус хороо нь Холбооны санхүү болон холбогдох бусад асуудалд хяналт тавихад, мөн Холбооны холбогдох журамд үнэн зөв нийцүүлсэн эсэхэд хяналт тавих асуудлаар Зөвлөлд зөвлөж, туслалцаа үзүүлнэ.
3. Тус хорооны хариуцлага, дотоодын хамтын ажиллагаа болон үйл ажиллагаатай холбогдох бусад асуудлыг тус Холбооны холбогдох журмаар зохицуулна.
4. Тус хорооны дарга, орлогч дарга болон гишүүдийг Их хурлаас 4 жилийн хугацаатай сонгох бөгөөд зөвхөн Их Хурлаар чөлөөлнө.
5. Аудит, Хяналт шалгалтын хорооны дарга, дэд дарга нь хараат бус байна. Сонгогдсон 4 жилийн хугацаанд гэр бүлийн аль нэг гишүүд нь (эхнэр/нөхөр, хүүхэд, дагавар хүүхэд, эцэг эх, эгч/ах дүүс, хамтран амьдрагч, хадам аав/ээж, хамтран амьдрагчийн эгч/ах дүүс, хүүхдүүд):
 - 6.1. Холбоо, Лиг, Гишүүн, Клуб (хамааралтай компани, байгууллага) –той сарын 200 ам.доллар ба түүнээс дээш хэмжээний шууд эсвэл шууд бус аргаар мөнгөн төлбөрийн албан тушаал эрхлэх эсвэл материаллаг гэрээ байгуулсан тохиолдолд
 - 6.2. Холбооноос гадуурх хуулийн зөвлөхөөр ажилласан эсвэл Холбооны аудитороор ажилласан (Холбоог аудит хийж байсан) тохиолдолд
 - 6.3. Холбооны болон/эсвэл аливаа гишүүн байгууллага, тивийн холбоо, Лиг, эсвэл клубтэй жилийн 200 ам. доллар-аас багагүй хэмжээний мөнгөн дүн бүхий ажил сайн дураар эсвэл төлбөрт байдлаар ажилласан төрийн бус байгууллага байвал хараат гэж үзнэ.
6. Тус хорооны дарга, орлогч дарга болон гишүүн нь

өөрийн бүрэн эрхийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Гүйцэтгэх Хороо Зөвлөл дараагийн Их хурал болтол уг албан тушаалд ажиллах хүнийг нөхөн томилно.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

48-Р ЗҮЙЛ. ШҮҮГЧДИЙН ХОРОО

1. Тус хороо нь Тоглолтын Дүрмийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Түүнчлэн тус хороо нь Холбооноос зохион байгуулагдаж байгаа аливаа тоглолтын шүүгчийг томилох, Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газартай хамтран шүүгчийн асуудлыг зохион байгуулж, шүүгчийн боловсрол, сургалтад хяналт тавих үүрэгтэй. Тус Хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрднэ. **Гишүүдийн 50-иас багагүй хувь нь шүүгчээр ажиллаж байсан туршлагатай байна.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

50-Р ЗҮЙЛ. ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОРОО

1. Тус хороо нь хүүхдийн хөлбөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж хүүхдийн хөлбөмбөг **болон грассрүүтстэй** холбогдох бүхий л асуудлыг хариуцна. Тус хороо нь дарга, дэд дарга болон хоёр гишүүнээс бүрдэнэ.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Д. КЛУБ ЛИЦЕНЗЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД

54-Р ЗҮЙЛ. КЛУБ ЛИЦЕНЗЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД

1. Тус байгууллага клуб лицензжүүлэх асуудлыг хариуцаж, ажлаа АХБХ болон **МХБХ тэдгээрийн гаргасан** Клуб Лицензжүүлэх Журамд нийцүүлнэ.
2. Клуб лицензжүүлэх байгууллагууд нь **Хянан хэлэлцэх байгууллага болон Давж заалдах байгууллагуудаас бүрдэнэ.**

Давж заалдах байгууллагаас гаргасан шийдвэрийг **ЭНЭ дүрмийн дагуу** Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитрт давж заалдаж болно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3. Холбооны уралдаан, тэмцээнд клубүүд хэрхэн яаж оролцох тогтолцоог тодорхойлсон клуб лицензжүүлэх журмыг Зөвлөлөөс гаргана. Энэ нь ОУХБХ-ны клуб лицензжүүлэх журамд нийцсэн АХБХ-ны гаргасан тогтолцооны зайлшгүй шаардлагыг хангасан байна.
4. Хянан хэлэлцэх байгууллага болон давж заалдах байгууллага нь тус бүр дарга, дэд дарга, гишүүн гэсэн гурван хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээр нь хуулийн, санхүүгийн, хөлбөмбөгийн спортын мэргэшсэн этгээд байна.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

Е. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР

56-Р ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

4. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 4.2. Их хурал, Зөвлөл, ~~Шуурхай зөвлөл~~, Байнгын хороод Түр хорооны хуралд оролцох;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж, хассан/
 - 4.3. Их хурал, Зөвлөл болон **бусад байгууллагуудын** ~~Клуб лицензжүүлэх байгууллагуудын~~ хурлыг зохион байгуулах;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж, хассан/
 - 4.4. Их хурал, Зөвлөл, ~~Шуурхай зөвлөл~~, Байнгын хороод болон Түр хорооны хурлын тэмдэглэлийг хариуцах;

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж, хассан/

V. ЭРХ ЗҮЙН БАЙГУУЛЛАГУУД ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУД

57-Р ЗҮЙЛ. ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙДАЛ

1. Хараат бус байгууллагууд болон тэдгээрийн гишүүд нь үүргээ биелүүлж, үйл ажиллагаа явуулахдаа хараат бус байх боловч МХБХ сонирхол, МХБХ-ны дүрэм болон бусад журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
2. Эрх зүйн байгууллагууд, Сонгуулийн хороодын дарга, дэд дарга, гишүүд, Аудит ба дүрэм, журмын хяналтын нэгж нь энэ зүйлийн 3 дахь заалтанд заасан хараат бус байдлын шалгуурыг хангасан байна.
3. Дээр дурдсан байгууллагуудын гишүүд, хамаарал бүхий гэр бүлийн гишүүд дөрвөн жилийн сонгуульт ажлын хугацаанд МХБХ-ны Зөвлөл, гишүүдийн аль нэг, лиг эсвэл клуб/харьяалагдсан компани (байгууллагын хэлбэрээр)-д үүрэг гүйцэтгэх, дээр дурдсан газруудтай бизнес харилцаа үүсгэхийг тус тус хориглоно. Хамаарал бүхий гэр бүлийн гишүүд гэдэгт тухайн хүнтэй холбоотой, тухайн хүний эхнэр эсвэл гэр бүлийн хамтрагч, эгч дүүс, эцэг эх, эмээ/өвөө, нагац, авга, хүүхдүүд (дагавар хүүхэд эсвэл өргөж авсан хүүхэд), ач/зээ хүүхэд, хадам ах дүү, хадам эцэг эх, цусан болон цусан бус хамааралтай, санхүүгийн туслалцаа үзүүлдэг гэр бүлийн харилцаатай хүмүүсийг тус тус хэлнэ.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

58-Р ЗҮЙЛ. АУДИТ БА ДҮРЭМ, ЖУРМЫН ХЯНАЛТЫН НЭГЖ

1. Аудит ба дүрэм, журмын хяналтын ажилтан нь аудит ба дүрэм, журмын хяналтын нэгжийг хариуцан ажиллана. Тус ажилтан нь санхүү, хууль, дүрэм журмын талаар мэдлэгтэй, туршлагатай байх бөгөөд Холбооны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй
2. Тус ажилтан нь Холбооны санхүү, хууль, дүрэм журмыг хянаж, Холбооны Зөвлөлд зөвлөх, туслах үүрэгтэй. Тус ажилтан дүрэм, журмын хяналтыг зохицуулах тогтолцоог бий болгож,

хянаж ажиллана. Мөн тус ажилтан нь санхүү болон дүрэм, журмын хэрэгжилттэй холбоотой асуудлаар Ерөнхий нарийн бичгийн даргын газарт зөвлөж, санхүүгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, хараат бус хөндлөнгийн аудитын тайлан зэргийн үнэн зөв, бүрэн байдлыг нягтална. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд Холбооны санхүү, дүрэм журмын асуудлыг хянах зорилгоор зохих байгууллагуудаар шийдвэр гаргуулна.

3. Аудит ба дүрэм, журмын хяналтын нэгжийн үүрэг хариуцлага, дотоод уялдаа холбоо, бусад асуудлын дэлгэрэнгүйг Холбооны дотоод зохион байгуулалтын журамд дэлгэрэнгүй тусгана.
4. Аудит ба дүрэм, журмын хяналтын ажилтныг МХБХ-ны Их хурлаар дөрвөн жилийн хугацаатай сонгох бөгөөд бүрэн эрхийг гагцхүү Их хурал дуусгавар болгоно. Тус ажилтан Холбооны өөр бусад байгууллагад хамаарах, харьяалагдан ажиллахыг хориглоно.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

59-Р ЗҮЙЛ. СОНГУУЛИЙН ХОРООД

1. Сонгуулийн хороод нь Сонгуулийн дүрмийн дагуу Сонгуультай холбоотой үйл явцыг зохион байгуулж, удирдан хянана. Сонгуулийн хороод нь Сонгуулийн хороо (анхан шатны байгууллага), Сонгуулийн хяналтын хороо (хоёр дахь шатны байгууллага)-ноос бүрдэнэ. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагааг Холбооны Сонгуулийн дүрмийн дагуу зохицуулна.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

60-Р ЗҮЙЛ. ЭРХ ЗҮЙН БАЙГУУЛЛАГУУД

2. Тус хороо бүр нь дарга, дэд дарга, **гурван** гишүүн гэсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байна.
3. Тус хороодын дарга, дэд даргыг гишүүд нь дотроосоо сонгоно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

3. Тус байгууллагууд нь зорилгоо бүрэн биелүүлэхэд шаардагдах мэдлэг чадвар, мэргэшсэн туршлагатай гишүүдээр багаа бүрдүүлнэ. Тус байгууллагуудын дарга нь **процессийн эрх зүйгээр мэргэшсэн** чадвартай байна. Хороодын гишүүд дөрвөн жилээр сонгогдоно. Мөн улиран сонгогдож болно. Хорооны гишүүдийг үүрэгт ажлаас нь хэзээ ч чөлөөлж болох боловч гагцхүү Их Хурлаар чөлөөлөх асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

6. Эрх зүйн байгууллагын дарга, дэд даргад Аудит, хяналт шалгалтын хорооны дарга, дэд даргад тавигдсан шаардлагын дагуу ижил шаардлага тавина.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

62-Р ЗҮЙЛ. ЁС ЗҮЙН ХОРОО

2. Тус Хороо нь Холбооны гаргасан Ёс зүйн дүрэм **болон Сахилгын дүрэмд** заасан шийтгэлийг Холбооны гишүүд, албаны хүн, тоглогч, клуб, тоглолт болон тоглогчдын дундын зуучид оногдуулж болно.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

63-Р ЗҮЙЛ. МАРГААН ТАСЛАХ ХОРОО

3. Маргаан таслах хорооноос гаргасан шийдвэрийг энэхүү дүрэмд зааснаар Монголын Олон улсын ба Үндэсний спортын шүүхээр аль эсвэл Швейцарь улсын Лозанн хотод байршилтай Спортын Арбитрын шүүхээр дахин хянуулж болно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

VI. САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

64-Р ЗҮЙЛ. САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Сахилгын дараах шийтгэлүүд байна. Үүнд:

2. Хувь хүнд

- а. Хуудсаар торгох;
- б. Тоглолтоос хөөх;
- в. Тоглолт өнжүүлэх;
- г. Нийгмийн ажил хийлгүүлэх;

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

VII. АРБИТР

65-Р ЗҮЙЛ. ҮНДЭСНИЙ АРБИТР

1. Холбоо, Лиг, лигийн гишүүд, клуб, тэдгээрийн гишүүд, тоглогч, албаны хүмүүс болон бусад холбоодын албаны хүмүүстэй хамааралтай эсвэл тэдгээрийн хоорондох маргааныг ӨУХБХ-ны журам, Дүрэм, эсвэл тухайн асуудалд хамааралтай тусгайлсан дүрэмд Шүүхэд хандахыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд Шүүхэд хандахыг хориглоно. **Монгол улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол иргэний шүүхэд хандахтай холбоотой асуудлыг Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитраар хянан хэлэлцүүлнэ.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2. Холбоо — 61.1.-д заасан маргааныг Холбооны хүлээн зөвшөөрсөн Үндэсний Арбитраар эсвэл Швейцарь улсын Лозанна хотод байрладаг Спортын Арбитрын шүүхээр хянуулж болно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

2. ОУХБХ эсвэл АХБХ-ны дүрэм, журам, чиглэл, шийдвэртэй холбоотой Олон улсын хэмжээний маргааныг ОУХБХ болон АХБХ-ны дүрмийн дагуу Олон улсын спортын арбитрын шүүхэд (CAS) хандаж болно.

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

66-Р ЗҮЙЛ. МАРГААНЫГ ШҮҮН ТАСЛАХ ЭРХ ЭҮЙ-ХЭМЖЭЭ

1. Монгол Улсын хэмжээний маргаан (жишээ нь, Холбоонд хамааралтай талуудын маргаан)-ыг Холбооны эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх бөгөөд хэрэв шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ дүрмийн 65 дугаар зүйлд заасны дагуу Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитрт хандана. Бусад орны болон тивийн Хөлбөмбөгийн холбоотой үүссэн олон улсын шинжтэй маргааныг ОУХБХ хариуцна.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2. Холбоо нь ОУХБХ-ны байгууллага, АХБХ-ны байгууллага, ЗАХБХ-ны байгууллага, Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитр эсвэл Олон Улсын Спортын арбитрын шүүх (CAS)-ийн гаргасан эцсийн шийдвэрийг дагаж мөрдөнө.

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

66-Р ЗҮЙЛ. СПОРТЫН АРБИТРЫН ШҮҮХ (CAS)

1. 61-р зүйлд заасны дагуу тухайн маргааныг шүүн таслах эрх Үндэсний Арбитрт хамааралгүй тохиолдолд ОУХБХ-ноос эцэслэн гаргасан шийдвэрийг ОУХБХ-ны Дүрмийн холбогдох зүйлд заасны дагуу Швейцарь улсын Лозанна хотод байршилтай Спортын Арбитрын шүүхээр хянуулж болно. Гэхдээ энэ шүүхээр тоглолтын дүрмийн зөрчил болон 4-өөс доош тоглолт эсвэл 3 сараас бага хугацаанд тоглолтоос түдгэлзүүлсэн тухай шийтгэл, мөн зохих журмын дагуу байгуулагдсан дотоод эсвэл тивийн хөндлөнгийн Арбитрын

шүүхийн шийдвэрийг авч хэлэлцэхгүй.

2. ӨУХБХ-ны байгууллага, Холбооны зөвшөөрөгдсөн дотоодын Үндэсний Арбитр, аль эсвэл Швейцарь улсын Лозанна хотод байршилтай Спортын Арбитрын шүүхээс гаргасан эцсийн шийдвэрийг Холбоо өөрөө болон түүний гишүүд, тоглогчид, албаны хүмүүс, тоглолтын ба тоглогчдын дундын зуучид бүрэн дагаж мөрдүүлэхийг Холбоо хариуцна.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор хассан/

68-Р ЗҮЙЛ. ОРЛОГО

1. Холбооны орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 1.1. Гишүүнчлэлийн татвар;
 - 1.2. Холбооны маркетингийн ашиг;
 - 1.3. Эрх бүхий байгууллагуудаас оногдуулсан торгууль;
 - 1.4. Холбооны зорилтыг биелүүлэхтэй холбоотой татвар хураамж;
 - 1.5. Хандив;
 - 1.6. Хөлбөмбөгийн үйл ажиллагаатай холбоотой олж буй бүхий л орлого;
 - 1.7. **ОУХБХ, АХБХ, ЗАХБХ-ноос ирүүлж буй санхүүжилт.**

/Энэ хэсгийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

70-Р ЗҮЙЛ. ХАРААТ БУС, ХӨНДЛӨНГИЙН АУДИТ

1. Их хурлаар батлагдсан Хараат бус, хөндлөнгийн аудит нь санхүүгийн Хорооноос баталсан санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу хянаж, дүгнэлтээ Их хуралд танилцуулна. **Аудитын шалгалтыг жил бүр явуулах бөгөөд тухайн аудитыг дөрвөн жилээр томилно. Улируулан сонгохгүй.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

71-Р ЗҮЙЛ. ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТАТВАР

1. Их хурлын гишүүний татварыг жил бүрийн нэгдүгээр сарын 31-ний дотор төлсөн байна. Шинэ гишүүд тухайн жилийн татварыг гишүүнээр элссэн Их хурлаас хойш 30 хоногийн дотор төлнө.
2. Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэж, Их хурал нь татварын хэмжээг дөрвөн жилд нэг удаа тогтооно. Гишүүн бүр ижил хэмжээний татвар төлөх **ба жилийн татвар нь 100,000 төгрөг байна.**

/Энэ хэсэгт МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/

74-Р ЗҮЙЛ. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

1. Холбоо өөрийн цахим сайт дээр Их хурлаар батлагдсан, тус дүрэмд заасны дагуу (33.2.9, 33.2.10, 33.2.11) санхүүгийн албан ёсны бичиг баримтуудыг нийтэлнэ.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

IX. ТЭМЦЭЭН БА ТЭМЦЭЭНИЙ БОЛОН БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР ЭДЛЭХ ЭРХ

75-Р ЗҮЙЛ. ТЭМЦЭЭНҮҮД

1. Холбоо нь Монгол улсын нутаг дэвсгэрт албан ёсны дараах тэмцээнүүдийг өмчилж, зохион байгуулж зохицуулна:

1.7. Супер цом;

/Энэ заалтыг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

1,10. Мастер ангиллын тамирчдын тэмцээн

XI. ТӨГСГӨЛИЙН ЗҮЙЛҮҮД

82-Р ЗҮЙЛ. БАЙГУУЛЛАГЫН БИЧИГ БАРИМТУУДЫГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ

1. Холбоо нь дараах бичиг баримтуудыг цахим сайт дээр байршуулна. Үүнд:
 - 1.1. МХБХ Дүрэм ба Их хурал хуралдуулах дэгийн заавар;
 - 1.2. Сонгуулийн дүрэм;
 - 1.3. Сахилгын дүрэм ба Ёс зүйн дүрэм;
 - 1.4. Холбооны дотоод зохион байгуулалтын журам;
 - 1.5. Чухал шийдвэрүүд;
 - 1.6. Стратеги төлөвлөгөө;
 - 1.7. Их хурал болон Зөвлөлийн хурлуудын хэлэлцэх асуудал;
 - 1.8. Захидал, албан бичиг.

/Энэ зүйлийг МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэмсэн/

85-Р ЗҮЙЛ. ТӨГСГӨЛИЙН ЗҮЙЛ

1. Холбооны одоогийн байгууллагуудын бүрэн эрхийн хугацааг тухайн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр хэвээр гэж үзнэ.
2. Шүүгчдийн зөвлөл, Дасгалжуулагчийн зөвлөл, эмэгтэйчүүдийн зөвлөл, ахмадын зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл байгуулагдаагүй тохиолдолд байгуулагдаж Холбоо хүлээн зөвшөөрөх хүртэл дүрмийн 25.1-д заасны дагуу санал өгөх эрхгүй гэж үзнэ.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл байгуулагдаагүй тохиолдолд дүрмийн 36.1-д заасан Зөвлөлийн 1 суудлыг хөөсөнд тооцно.

1. Тус дүрмийн 12 дугаар зүйлд заасны дагуу Их хурлын гишүүд нь 12 сарын хугацаанд эрх эдэлж, үүрэг хүлээж, 13 дугаар зүйлийн 2 дахь заалтад заасан шаардлагуудыг зайлшгүй дагаж мөрдөнө. Хэрэв биелүүлээгүй тохиолдолд Их хуралд санал өгөх эрхээ алдаж, Их хурлын ирцэд оролцоогүйд тооцно. Дээр дурьдсан шаардлагуудыг хангасан тохиолдолд Их хуралд санал өгөх эрх нь сэргэнэ.
2. Энэ дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтад заасан гишүүн нь энэ дүрмийг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс эхлэн 13.2.1-13.2.13 дахь заалтад заасан шалгуур үзүүлэлтийг зургаан сарын хугацаанд заавал хангах үүрэгтэй. Тус шаардлагыг хангаагүй гишүүн нь Их хурлын санал өгөх эрхээ алдах бөгөөд ирцэд тооцогдохгүйгээр Их хуралд оролцоно. Улмаар тус гишүүнд тухайн шаардлагыг хангах зургаан сарын хугацаа олгоно. Энэ хугацаанд клубын лицензийг аваагүй тохиолдолд Холбооны Их хурлын санал өгөх эрхтэй гишүүнээс автоматаар түдгэлзүүлж, Их хуралд тус гишүүнийг түдгэлзүүлсэн тухай баталгаажуулах шаардлагагүй. Энэ дүрмийн 13.2.14 дэх заалтад заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд түдгэлзүүлсэн гишүүний эрхийг сэргээнэ.
3. Энэ дүрмийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтад заасан шударга байдлын мэдэгдлийг бөглөх нь энэ дүрмийг батлах үед Зөвлөлийн гишүүнээр нэгэнт сонгогдсон байсан гишүүдэд хамаарахгүй. Харин энэ дүрэм батлагдсаны дараа сонгогдохоор нэр дэвшиж буй удирдах зөвлөлийн гишүүд 38.4 дэх шаардлагыг хангана.
4. Энэ дүрмийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь заалтад заасан албан тушаалын хугацаа нь энэ дүрмийн дагуу сонгууль болсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
5. Энэ дүрэм батлагдсан өдрөөс эхлэн 12 сарын дотор Их хурлаар энэ дүрмийн 58-63 дугаар зүйлүүдэд дурдсан Хараат бус байгууллагуудын сонгогдоогүй сул орон тооны гишүүдийг зайлшгүй сонгоно. Мөн энэ хугацаанд Их хурлыг хуралдуулж, энэ дүрмийн 57.3 дахь заалтад заасан хараат бус хөндлөнгийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй Хараат бус байгууллагуудын гишүүдийг чөлөөлж, шинэ гишүүдийг сонгоно.

/Энэ зүйлд МХБХ-ны Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/